



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ЖЕНДЭРЭРИЙН ТЭГШ  
БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ  
ХОРОО



НИЙГМНИЙ АЖЛЫН  
ХӨГЖЛИИН ТӨВ



# ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЭЛ МОНГОЛД

СУДАЛСАН БАЙДАЛ, УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

2011



# ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХУЧИРХИЙЛЭЛ МОНГОЛД

СУДАЛСАН БАЙДАЛ, УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

2010

НҮБХХ @ Зохиогчийн эрх хамгаалагдсан болно.  
Ашгийн зорилгоор олшруулан хувилж тараахыг хориглоно.

НҮБХХ-ийн Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба  
Хүний эрх төслийн санхүүжилтээр хэвлэв.



Үсэг хоршооны хэвлэх үйлдвэрт хэвлэв.  
Хэвлэсэн тоо 500 ширхэг.  
Хэвлэлийн хуудас 9.5.

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	7
ТОВЧ АГУУЛГА .....	9
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙГ</b>	
СУДАЛСАН БАЙДЛЫН ТОЙМ .....	13
Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тодорхойлолт .....	14
Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хэлбэрүүд .....	15
Жендерээс үүдэлтэй хүчирхийллийг судлах хандлага, арга зүй .....	17
<b>ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙГ МОНГОЛ УЛСАД</b>	
СУДАЛСАН БАЙДАЛ .....	24
А. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг судалсан байдал .....	29
Б. Эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг судалсан байдал .....	36
В. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг судалсан байдал .....	38
Г. Ахмад настны эсрэг хүчирхийллийг судалсан байдал .....	40
Д. Хүчирхийллийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан байдал .....	41
Е. Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн үр дагавар, өртөг .....	45
Ж. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн хүчирхийлэлд үзүүлэх хариу үйлдэл .....	46
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	49
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ЖЕНДЭРИЙГ</b>	
ИНСТИТУЦИЛАХ ҮЙЛ ЯВЦ .....	51
Институцилал гэж юу вэ? .....	52
Институциллын тор .....	52
Институциллын торны элементүүд .....	53
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ</b>	
БАЙДАЛД ХИЙСЭН ЦОГЦ ШИНЖИЛГЭЭ .....	61
Удиртгал .....	62
А. ИРГЭНИЙ ХҮРЭЭ .....	64
Эмэгтэй, эрэгтэйчүүдийн амьдралын туршлага, бодит байдлыг тайлбарлаж	
буй байдал .....	64
Сонирхлын бүлгийн шахалт .....	68
Улс төрийн төлөөллийн бүтэц .....	69
Б.БОДЛОГЫН ХҮРЭЭ .....	70
Улс төрийн үүрэг амлалт .....	70

Бодлого, төлөвлөлт .....	71
Эх үүсвэр .....	72
<b>В.ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭ .....</b>	<b>74</b>
Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, зохион байгуулалт .....	74
Заавар журам .....	75
Хүний нөөцийг хөгжүүлэх .....	78
<b>Г.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ .....</b>	<b>80</b>
Үйлчилгээ хүргэх нь .....	80
Хэрэглээний судалгаа .....	83
Онол бий болгох нь .....	84
Арга зүй .....	85
<b>ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>87</b>
Хавсралт нэг. Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл үйлчилгээ .....	89
Хавсралт хоёр. Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тухай эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн туршлага-Фокус бүлгийн судалгаа .....	101
Ашигласан эх сурвалж, ном зүй .....	103

**Товчилсон үгийн жагсаалт**

АББ	Албан бус боловсрол
АББД	Ажлын байран дахь бэлгийн дарамт
АДРА	АДРА олон улсын ТББ
АЙПЕК	Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр
АНУОУХА/USAID	АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ДБ	Дэлхийн Банк
ДЗ	Дэлхийн зэн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖТБҮХ	Жендерээрийн тэгш байдлын үндэсний хороо
ЖҮХ	Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл
ЖХҮБ/GAD	Жендер ба Хөгжил үзэл баримтлал
ЗХЖТ	Залуучууд, хөгжил, жендер төв
ИАТ	Иргэдийн альянс төв
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
МАОЭХ	Монголын ажил олгогч эздийн холбоо
МОНФЕМНЕТ	Монголын эмэгтэйчүүдийн ТББ-уудын сүлжээ
МУИС	Монгол Улсын их сургууль
МЭрХ	Монголын эрэгтэйчүүдийн холбоо
МЭС	Монголын эмэгтэйчүүдийн сан
МУБИС	Монгол Улсын боловсролын их сургууль
МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
НАХТ	Нийгмийн ажлын хөгжлийн төв
НҮБ/UN	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХАС/UNFPA	НҮБ-ын Хүн амын сан
НҮБХС/UNICEF	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБХТХ	НҮБ-ын Хөгжлийн туслалцааны хүрээ
НҮБХХ/UNDP	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБЭС/UNIFEM	НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОУХБ/ILO	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ӨҮХТ	Өсвөр үеийнхний хөгжлийн төв
СЯ	Сангийн яам

ТББ	Төрийн бус байгууллага
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАББСТ	Хүний аюулгүй байдлын бодлого судлалын төв
ХАЗССТ	Хүн ам зүйн сургалт судалгааны төв
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХИС	Хүүхдийг ивээх сан
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв
ХХТХ	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр
ХХХҮХ	Хүүхэд хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенци
ХЭС	Хүүхдэд ээлтэй сургууль
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭХТ	Хүний эрх хөгжил төв
ШХА/SCD	Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг
ЭКПАТ	Хүүхдийн биеийг үнэлүүлэх, садар самуунд ашиглах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалахын эсрэг хувь хүмүүс, байгууллагын сүлжээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭТУГ	Эрүүл мэндийн Тусlamжийн удирдах газар
ЭХЭХ	Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл
ЭЭХ	Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл
ЭЯГБХУТК	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци
ШХА/SCD	Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлаг
WID	“Эмэгтэйчүүд Хөгжилд” үзэл баримтлал

## ӨМНӨХ ҮГ

“Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хамтран НҮБХХ-ийн Жендерийн итгэлцлийн сан болон нэр дурдсан байгууллагуудын санхүүжилтээр 2007-2008 онд хэрэгжүүлсэн юм. Төслийн зорилго нь Монгол Улсад эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил явуулахад мэдлэгийн сан бий болгох, жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх, эдгээр үйлчилгээг хүргэх үүрэгтэй ажилтнуудыг чадваржуулах, Засгийн газар, иргэний нийгмийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, энэ үйл явцад НҮБ-ын зуучлагчийн үүргийг нэмэгдүүлэх явдал байв.

Тус төслийн бүтээгдэхүүн болох **Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл Монголд: судалсан байдал, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тойм судалгааны тайланг та бүхэнд толилуулж байна.** Энэ судалгааны онцлог нь өмнө нь энэ сэдвээр хийгдсэн бүх судалгаанд арга зүйн талаас дүгнэлт өгөхөөс гадна жендерээс үүдэлтэй хүчирхийллийг анх удаа хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн үүднээс бус харин холбогдох бодлогын орчин, иргэдийн ойлголт, үйлчилгээ, зохион байгуулалтын бүтцийн хамт шинэлэг аргачлалаар судалсан явдал юм. Түүнчлэн онол, арга зүй, нэр томъёоны тайлбар зэрэг өргөн мэдээллийг агуулж байгаа учраас дараа дараагийн судалгааны чанарыг дээшлүүлэх, бодлого боловсруулахад зохих хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

Судалгааг Нийгмийн ажлын хөгжлийн төв – төрийн бус байгууллага НҮБХХ, НҮБХАС-гийн санхүү, арга зүйн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв. Судалгааны ажлыг чанартай гүйцэтгэсэн Нийгмийн ажлын хөгжлийн төвийн хамт олон, судалгааны багийн удирдагч Ц.Эрдэнэчимэг, судалгааны төслийн менежер Ч.Тунгалаг, арга зүйн зөвлөгөө өгсөн олон улсын зөвлөх, доктор Надя Тахэр, судалгааны тайланг хянаж эцэслэн боловсруулахад туслалцаа үзүүлсэн Жендерийн тэгш байдлын үндэсний хорооны Ажлын албаны дарга Б.Энхсайхан нарт онцгойлон талархал илэрхийлж байна.

*Жендерээс цдэлтэй хүчирхийлэл Монголд*

---

Төслийг хэрэгжүүлэх, судалгааны ажлыг удирдахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан тус төслийн зохицуулагч Б.Алтанцоож, НҮБ-ын Хүн амын сангийн ажилтан Б.Оюун, Франсин Эгбэртс, НҮБ-ын Хүүхдийн сангийн ажилтан Б.Дарьханд, Д.Амараа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ажилтан Ш.Энхцэцэг нарт талархал илэрхийлье.

Тус төсөл нь Засгийн газар, иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын хүчин чармайлтаар бага хэмжээний санхүүжилтээр богино хугацаанд бодитой үр дүнд хүрч болохыг харуулсан билээ. Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Жендерийн тэгш байдлын үндэсний хороо, Хүний эрх хөгжил төв, Хүчирхийлийн эсрэг үндэсний төв, Монголын эрэгтэйчүүдийн холбоо, “Монгол өрх” сэтгэл заслын холбоо зэрэг төрийн бус байгууллагад Нэгдсэн үндэстний байгууллагын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж, цаашдын ажил үйлст нь өндөр амжилт хүсье.

Ц.Даваадулам

НҮБ-ын дэргэдэх Жендерээс үүдэлтэй хүчирхийлийн  
асуудлаарх техникийн ажлын хэсгийн ахлагч,  
НҮБХХ-ийн Засаглалын хөтөлбөрийн менежер

## ТОВЧ АГУУЛГА

Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл /ЖҮХ/-ийн тухай ойлголт Монголын нийгэмд бүрэн тогтоогүй, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондын хүйсийн ялгаатай байдал, эрх тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийллийг зөвхөн эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл гэдэг утгаар ойлгох нь нийтлэг байна. Гэтэл түүнд эмэгтэйчүүд, хүүхдээс гадна эрэгтэйчүүд өртдөг бөгөөд энэ төрлийн хүчирхийлэл гэр бүлийн хүрээнээс гадна ажлын байр, сургууль, гудамж талбай, олон нийтийн газар болон орон нутагт, цаашлаад төрийн бодлого, үйл ажиллагааны үр дагаврын улмаас гардаг байна. Жендерээс үүдэлтэй хүчирхийллийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хэмээн явцуу ойлгодгоос эмэгтэйчүүд-хохирогч, эрэгтэйчүүд-хүчирхийлэгч хэмээн ерөнхийлөх хандлага түгээмэл байна. Судлаачид, бодлого боловсруулагчдын дунд ч ийм явцуу ойлголт байдаг нь судалгааны арга зүй, бодлого, хөтөлбөр боловсруулах, үйлчилгээ хүргэхэд өрөөсгөл хандлага бий болоход нөлөөлж байна. Тус судалгаа нь энэхүү ойлголтыг тодорхой болгох, жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч, тэдгээрт төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлэх үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан бий болгоход туслах зорилготой юм.

Тус тайлан үндсэн гурван бүлэг, хавсралтуудаас бүрдэж байна. Нэгдүгээр бүлгийн эхний хэсэгт тус судалгаанд ашигласан олон улсын түвшинд бий болсон жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тодорхойлолтууд, судалгааны хандлага, арга зүйг танилцуулав. Дараагийн хэсэгт жендерээс үүдэлтэй хүчирхийллийг Монгол Улсад судалсан байдлыг тоймлон харууллаа. Монгол Улсад 1998 оноос хойш одоог хүртэл Засгийн газрын болон төрийн бус байгууллагууд, Нэгдсэн үндэстний байгууллага, олон улсын байгууллагуудаас их, бага хэмжээний 18 судалгаа хийжээ. Эдгээр судалгааны арга зүй, үр дүнд жендерийн дүн шинжилгээ хийх замаар жендерээс үүдэлтэй хүчирхийллийг судалсан байдал, судалгааны арга зүйн давуу болон сул талуудыг тодорхойлохыг зорив. Судалгааны сэдэв, хамрах хүрээ, хүн амын түүврийн хэмжээ, оролцогчдыг нас, хүйсээр ялгасан байдлыг харьцуулсан мэдээллийг үзүүлэв. Түүнчлэн дээрх судалгааны мэдээлэлд үндэслэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ахмад настны эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл тэсэн ангилалд хуваан хүчирхийллийн

Эдгээр хэлбэр тус бүрийн тархалт, байршил, хохирогч болон хүчирхийлэгчийн талаархи мэдээллийг нэгтгэн үзүүлсний зэрэгцээ цаашид ЖҮХ-ийг судлахад анхаарах арга зүйн асуудлын талаар дүгнэлт хийллээ.

Хүн амд суурилсан хэд хэдэн судалгааны үр дунгээс харахад Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг нь, дөрвөн эрэгтэй тутмын нэг нь хүчирхийлэлд өртдөг, хүүхдүүдийн тэн хагас нь, дөрвөн ахмад настны нэг нь ямар нэг хүчирхийлэлд өртдөг байна. Гэвч өмнө хийгдсэн хүн амд суурилсан судалгаанд хугацааны хязгаарыг амьдралын турш хэмээн авч үзсэн нь жендерээс үүдэлтэй хүчирхийллийн динамик өөрчлөлтийг харуулж чадахгүй байна. Хүн амын өргөн түүврийг хамарсан үндэсний хэмжээний судалгааг 1998 оноос хойш хийгээгүй байгаа нь цаашид ийм судалгаа хийх, чингэхдээ динамик өөрчлөлтийг харуулсан аргачлал бий болгох хэрэгцээг илтгэж байна.

Хоёрдугаар бүлэгт бодлого, төлөвлөлт, практикт жендерийн асуудлыг тусгахад цогц хандлагыг бий болгох зорилгоор боловсруулсан загвар – “Институцилалын тор”-ыг танилцуулж байна. “Институцилалын тор” нь төр, зах зээл, иргэний нийгэм хоорондын харилцаан дахь жендерийн тэгш байдлын асуудлыг авч үзэхэд тус тусдаа тодорхой эрх мэдлийн харилцааг илэрхийлдэг 13 элементээс бүрддэг байна. Эдгээр 13 элементийг өөр хоорондоо харилцан үйлчилдэг, өөрчлөлт шинэчлэлийн нөхцөлийг харилцан бүрдүүлдэг “зохион байгуулалтын”, “иргэний”, “үйлчилгээний”, “бодлогын” гэсэн дөрвөн хүрээнд бүлэглэн авч үздэг ажээ.

Гуравдугаар бүлэгт жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газар, иргэний нийгэм, бусад оролцогч талуудаас авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, бүтэц, зохион байгуулалтын орчин болон бодит нөхцөл байдалд “Институцилалын тор”-ыг ашиглан хийсэн цогц дүн шинжилгээг толилуулав.

Институциллын торын “иргэний хүрээний” элемент болох жендерээс үүдэлтэй хүчирхийллийн талаарх эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ойлголт, тэдний амьдралын бодит туршлагыг харуулах зорилгоор хийсэн фокус бүлгийн судалгааны үр дүнг нэгтгэн үзүүлэв. Судалгааны зорилго нь

жөндэрээс үүдэлтэй хүчирхийлэл гэр бүл, ажлын байр, сургуулийн орчин, олон нийтийн газар эмэгтэй, эрэгтэйчүүдийн амьдралд хэрхэн ялгаатайгаар илэрдэг, хэн хүчирхийлэгч, хэн хохирогч болох эрсдэлтэй байдаг, үүнээс хамгаалах хүчин зүйлс болон эрэгтэй, эмэгтэйчүүд энэ асуудлыг хэрхэн шийддэг зэргийг тодорхойлоход оршсон болно. Судалгаанд Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүрэг, Монгол Улсын баруун болон зүүн бүсийн төлөөлөл болгон сонгон авсан Ховд, Дорнод аймгийн хүн амын өөр хоорондоо нас хүйс, нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай хэсгүүдийг төлөөлсөн 52 бүлгийг хамруулан хийсэн ярилцлагын үр дүнг ашиглав.

Монгол Улс бодлого, хөтөлбөр боловсруулах, бодлогын түвшний өөрчлөлт хийх талаар нэлээдгүй амжилт олсон билээ. Энд Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2004-2015), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2007-2015), Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр (2005-2015), хүн худалдаалах гэмт хэргийн талаар Эрүүгийн хуульд оруулсан өөрчлөлт болон Дээд шүүхийн тайлбар (2008), Боловсролын хуульд суралцагчийн бие махбодид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэхийг хориглох талаар оруулсан нэмэлт өөрчлөлт (2006) зэргийг дурьдаж болно. Гэхдээ гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах, гэрчийг хамгаалах, гэрлэлтийн хүчинг гэмт хэрэгт тооцох, хүчирхийлэл үйлдэгчидтэй хариуцлага тооцох, хүүхдийг бэлгийн болон эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт хангалтгүй байгаа, ЖҮХ-ийн хохирогчдод эрх зүйн болон сэтгэл зүйн тусламж үзүүлэх механизм бүрдүүлэх шаардлагатай байгааг Олон улсын гэрээний хороодоос хийсэн дүгнэлтэд дурдсан байна.

Бүтэц, зохион байгуулалтын хүрээнд жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдэд үйлчилгээ үзүүлэх үүргийг үндсэндээ төрийн бус байгууллагууд, гол төлөв олон улсын байгууллагын санхүүгийн тусламжтайгаар гүйцэтгэж байгаа, мэргэжлийн үйлчилгээний хүртээмж орон нутагт хангалтгүй, ихэвчлэн Улаанбаатар хотод төвлөрсөн талаар тайланд дүгнэсэн байна. Гэхдээ энэ чиглэлээр ахиц гарч байгаа бөгөөд зөвхөн 2009 он гэхэд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай”, “Гэр бүлийн болон бэлгийн

хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээ байгуулах тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журмыг батлах тухай” ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ-ны хамтарсан шийдвэр гарсан нь жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь салбар дамнасан асуудал болохыг хүлээн зөвшөөрч байгаагийн тод илрэл болж байна.

Энэхүү бүлгийн хавсралт болгон жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Засгийн газар, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, үзүүлж буй үйлчилгээний талаарх тойм мэдээллийг өгөв.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

**ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙГ  
СУДАЛСАН БАЙДЛЫН ТОЙМ**

## Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тодорхойлолт

Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлд эмэгтэй, эрэгтэй хүмүүс аль аль нь өртөх боловч гол төлөв эмэгтэйчүүд хохирогч нь байдаг. Хүчирхийлэл гэр бүл, нийгэм, төрийн хүрээн дэх эрх мэдлийн тэгш бус харьцаанаас үүдэн гардаг бөгөөд төрөл бүрийн шалтгаанаар эмэгтэйчүүдийн эсрэг чиглэж, тэд илүүтэйгээр хохирол амсдаг байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай Нэгдсэн үндэстний байгууллагын тунхаглалын<sup>1</sup> 1-р зүйлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг: “Гэр булийн болон нийгмийн хүрээнд гарснаас үл хамааран эмэгтэйчүүдэд бэлгийн, эсвэл сэтгэл санааны болон аливаа дарамт учруулсан, эсвэл учруулж болзошгүй, айлган сурдуулэх, албадлага хэрэглэх, эсвэл дур зоргоороо эрх чөлөөг нь боогдуулах зэрэг жендерээс үүдэлтэй хүчирхийллийн аливаа үйлдэл” хэмээн тодорхойлжээ. Тунхаглалын 2-р зүйлд дээрх тодорхойлолтыг гэр бүл, нийгэм, төрийн хүрээнд гарч буй бие мах бодь, бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өргөжүүлэн хэрэглэхийг зөвлөсөн байна.

“Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай” /ЭЯГБХУТК/ конвенцийн 2-р зүйлд эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн, бие махбодийн, сэтгэл санааны хүчирхийлэлд:

1. Гэр булийн хүрээнд – зодох, бэлгийн замаар хүүхдийг хүчирхийлэх, эмэгтэйчүүдийн бэлэг эрхтэнийг зэрэмдэглэх, бэлгийн хүчирхийлэл;
2. Нийгмийн хүрээнд – бэлгийн хүчирхийлэл, ажлын байран дахь бэлгийн дарамт, доромжлол, хил дамнуулан худалдаалах, хүчээр биенийг нь үнэлүүлэх;
3. Төрийн хүрээнд – эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль нь чанаргүй боловсруулагдсан, эсвэл хэрэгждэггүй, хууль сахиулах байгууллага нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хэрэглэдэг, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хамгаалах, анагаах байр байхгүй, урьдчилан сэргийлэх ба шийтгэх арга хэмжээ авдаггүй, жендерийн тэгш бус харилцааг гүнзгийрүүлсэн үйлдлүүд хэмээн тодорхойлжээ. Түүнчлэн

---

<sup>1</sup> НҮБ-ын Ерөнхий ассамблэйн тогтоол. 1993 оны 12 сарын 20

төрөөс эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэх, боловсрох бололцоо, оролцоогоор хангах, нийгмийн үйлчилгээнд хамруулах талаар хийж буй эс үйлдэл нь жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хэлбэр мөн гэжээ.

НҮБ 2005 онд “Хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх ялгаатай байдлаас үүдсэн, тухайн хүний хүслийн эсрэг хийж буй аливаа гэмт үйлдэл” хэмээн тодорхойлоод “ЖҮХ нь ийнхүү нийгмээс тогтоосон ялгаатай байдлаас үүдэлтэй тул ийм хүчирхийлэлд бэлгийн хүчирхийлэл хамаарах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлахгүй. Хохирогчдын ихэнх нь бүх насны эмэгтэйчүүд, охид байдаг боловч эрэгтэйчүүд, хөвгүүд мөн адил шууд болон шууд бус хохирогч байж болно. Энэхүү хүчирхийллийн улмаас бие махбодийн болон сэтгэл санааны хохирол аль алийг нь амсах бөгөөд хохирогчид, тэдгээрийг хүрээлэн байгаа орчныхонд удаан хугацааны сөрөг үр дагавартай”<sup>2</sup> гэжээ.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар 2005 онд хийсэн судалгааны тайланд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль нь ч ЖҮХ-ийн хохирогч, эсвэл хүчирхийлэгч байж болох боловч эмэгтэйчүүдийн эсрэг ЖҮХ эрэгтэйчүүдийн эсрэг ЖҮХ-ээс зарим шинж чанараараа ялгаатай хэмээн онцолжээ. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд дайн тулаан, эсвэл танхайн холбогдолтой хүчирхийлэлд өртөж амь насаа алдах, эсвэл гэмтэл бэртэл авах нь элбэг байдаг бол харин эмэгтэйчүүд ихэвчлэн гэр бүлийн гишүүд, эсвэл бэлгийн хамтрагч зэрэг ойр дотны хүмүүсийнхээ зүгээс үйлдсэн бие махбодийн хүчирхийлэл, аллагад өртөх нь элбэг. Түүнчлэн бүх насны эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлтэй байдаг хэмээн дүгнэжээ.<sup>3</sup>

### **Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хэлбэрүүд**

Олон улсын түвшинд ЖҮХ-ийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, эмэгтэйчүүд болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, жендерээс үүдэлтэй

<sup>2</sup> UN Inter-Agency Standing Committee. “Guidelines on the Prevention of Gender-Based Violence in Humanitarian Settings.” UN: New York, 2005.

[http://www.womenwarpeace.org/issues/violence/GBV\\_Guidelines\\_English.pdf](http://www.womenwarpeace.org/issues/violence/GBV_Guidelines_English.pdf)

<sup>3</sup> НҮБ (2005) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл: НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын судалгаа.

хүчирхийлэл, үүний дотор гэр бүлийн хүчирхийлэл хэмээн ангилан авч үздэг байна:

#### **Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл (ЭЭХ)**

- Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүл, ажлын байр, олон нийтийн газар, үндэсний болон олон улсын хүрээнд гарч байгаа бие махбодь, сэтгэл санаа, эдийн засгийн болон бэлгийн дарамт, хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг.
- Эрэгтэйчүүд хүчирхийлэл үйлдэгч, эмэгтэйчүүд хохирогч байдлаар харагддаг.
- Хандлага нь эмэгтэйчүүдэд чиглэсэн (феминизм, хөгжил дэх эмэгтэйчүүд)
- Шийдвэрлэх арга зам: хохирогчдод чиглэсэн үйлчилгээ (хорогдох байр, сурталчилгаа г.м.), хууль эрх зүйн шинэчлэл (хүчирхийлэл үйлдэгчдийг шийтгэх, залхаан цээрлүүлэх, хүмүүжүүлэх), хууль сахиулах (шүүх, цагдаа), эрүүл мэндийн байгууллага (эмч, сувилагчид), нийгмийн ажилтнуудыг сургах.

#### **Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэл (ЭХЭХ)**

- Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүл, ажлын байр, олон нийтийн газар, үндэсний болон олон улсын хүрээнд гарч байгаа бие махбодь, сэтгэл санаа, эдийн засгийн болон бэлгийн дарамт, хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг.
- Эрэгтэйчүүд хүчирхийлэл үйлдэгч, эмэгтэйчүүд, хүүхэд хохирогч байдлаар харагддаг.
- Хандлага нь эмэгтэйчүүдэд чиглэсэн (феминизм, хөгжил дэх эмэгтэйчүүд), хүүхдүүдийг охид, хөвгүүд гэж салгахгүйгээр өрөнхий байдлаар авч үздэг.
- Шийдвэрлэх арга зам нь өмнөхтэй адил.

#### **Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл (ЖҮХ)**

- Гэр бүлийн хүрээнд ихэнхдээ эмэгтэйчүүд, түүнчлэн охид, хөвгүүд, зарим тохиолдолд эрчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа бие махбодь, сэтгэл санаа, эдийн засгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, мөн ажлын байран дээрх бэлгийн дарамт, нийтийн газар, үндэсний болон олон улсын хэмжээнд гарч байгаа дээрх бүх хэлбэрийн хүчирхийлэл, дээр нь хүн худалдаалах гэмт хэрэг.

- Хүчирхийллийг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн хоорондох эрх мэдлийн харилцааны хүрээнд авч үздэг бөгөөд эрэгтэйчүүдийн эмэгтэйчүүдэд хяналт тогтоох, эрх мэдлээ хэрэгжүүлэх туйлын арга хэрэгсэл хэмээн үздэг.
- Хандлага нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд, тэдгээрийн хоорондын жендерэрийн харилцааг авч үзэх.
- Шийдвэрлэх арга зам: нийгмийн өөрчлөлтийг өргөн хүрээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алинд нь чиглүүлэх.

#### *Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)*

- Гэр бүлийн хүрээнд гэр бүлийн гишүүд, тэднийг тойрон хүрээлэгчдийн хооронд болж байгаа хүчирхийлэл.
- Эмэгтэйчүүд, хүүхдүүд, заримдаа ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдэгчдийг гол төлөв эрчүүд гэж үздэг.
- Хандлага нь эмэгтэйчүүдэд чиглэсэн (феминизм, хөгжил дэх эмэгтэйчүүд)
- Шийдвэрлэх арга зам: хохирогчдод чиглэсэн үйлчилгээ (хорогдох байр, сурталчилгаа г.м.), хууль эрх зүйн шинэчлэл (хүчирхийлэл үйлдэгчдийг шийтгэх, залхаан цээрлүүлэх, хүмүүжүүлэх), хууль сахиулах (шүүх, цагдаа), эрүүл мэндийн байгууллага (эмч, сувилагчид), нийгмийн ажилтнуудыг сургах.

#### **Жендерээс үүдэлтэй хүчирхийллийг судлах хандлага, арга зүй**

Хүчирхийллийн талаар хийсэн судалгаанд жендерэрийн дүн шинжилгээг хэрхэн ашигласнаар дараахи үндсэн дөрвөн ангилалд хуваадаг байна.

Нэгд, “өрөнхий судалгаа” буюу “жендерэрийн мэдрэмжгүй” судалгаа багтана. Үүнд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийг хамарсан байж болох ч мэдээллийг хүйсээр ялгаатай ангилаагүй байдаг.

Хоёрт, “эмэгтэйчүүдэд илүүтэйгээр анхаарсан” судалгаа багтана. Энэ нь WID буюу “Эмэгтэйчүүд хөгжилд” гэсэн феминист үзэл баримтлалд суурилдаг. Энэхүү үзэл баримтлал нь эмэгтэйчүүдэд илүү анхаарсан үйл ажиллагаа явуулах зэргээр эмэгтэйчүүдийн асуудлыг хөгжлийн үйл явцын салшгүй хэсэг болгохыг зорьдог. Харин эмэгтэйчүүдийн эрхийг өргөжүүлэх, чадавхийг бий болгох үйл явцад эрэгтэйчүүдийн үүрэг,

хариуцлагын талаар авч үздэггүй.<sup>4</sup> Энэ үзэл баримтлааар жендерээс үүдэлтэй хүчирхийллийг зөвхөн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэдэг утгаар нь авч үздэг. ЭЭХ нь эмэгтэйчүүдийг хохирогч, эрэгтэйчүүдийг хүчирхийлэгч хэмээн үздэгээс зөвхөн эмэгтэйчүүдэд чиглэсэн хамгаалах үйлчилгээ бий болгох, эрэгтэй хүчирхийлэгчдийг шийтгэх хуулийн механизмыг чангатгахыг зорьдог.

Гурав дахь ангилал буюу ЖҮХ нь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд, эсвэл охид ба хөвгүүдийн аль аль нь тэдний эрх мэдлийн ялгаатай байдлаас үүдэн хохирогч болж болох учраас хүчирхийлэл нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд эсвэл эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дотор ч гарч болно гэж үздэг. GAD буюу “жендер ба хөгжил” үзэл баримтлал нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоо, тэгш эрхтэй шийдвэр гаргах, үр ашгийг тэгш түгээхэд анхаарч жендерийн тэнцвэртэй байдал бий болгохыг зорьдог. Энэ төрлийн судалгаа хэн нь хохирогч, хэн нь хүчирхийлэгч гэдэгт биш жендерийн дүн шинжилгээнд суурилдаг.

Дөрөв дэх төрөл нь эрэгтэй хүний шинж байдалд анхаарал хандуулдаг эрэгтэйчүүд төвтэй судалгаа юм. Энэ төрлийн судалгаа нь эмэгтэйчүүдтэй холбоотойгоор эрэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлохыг оролддог.

Дараахи хоёр хүснэгтэд жендерийн дүн шинжилгээний хандлагыг хэрхэн ашигласныг харьцуулан үзүүлэв.

---

<sup>4</sup> (Source: UNESCO's Gender Mainstreaming Implementation Framework for 2002-2007. <http://unesdoc.unesco.org/images/0013/001318/131854e.pdf>)

**Хүснэгт 1.1 ЖҮХ ба ЭЭХ-ийг судлах арга зүйг харьцуулах нь:**

Харьцуулах үзүүлэлтүүд	Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг хүчирхийлэл	Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл
Байршил, хэлбэр	Гэр бүл, ажлын байр, олон нийтийн хүрээнд, үндэсний болон олон улсын түвшинд эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн дарамт, хүчирхийлэл	ЭЭХ-тэй адил гэр бүл, олон нийтийн хүрээнд, үндэсний болон олон улсын түвшинд бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн дарамт, хүчирхийлэл.
Хүчирхийлэгч ба хохирогч:	Хүчирхийлэгч нь эрэгтэйчүүд, хохирогч нь эмэгтэйчүүд, хүүхдүүд хэмээн авч үздэг.	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн хаорондын эрх мэдлийн харилцаагаар хүчирхийллийг тайлбарладаг тул эрэгтэйчүүд эсвэл эмэгтэйчүүдийн аль нь ч хохирогч, эсвэл хүчирхийлэгч байж болно. Мөн нэг хүйсийн хаоронд үйлдэгдэж болно.
Суурь үзэл баримтлал	Эмэгтэйчүүд төвтэй буюу феминист, эсвэл “эмэгтэйчүүд хөгжилд” үзэл баримтлалд суурилдаг. Хүүхдийг охид, хөвгүүд гэж зааглахгүйгээр ерөнхий авч үздэг.	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд, тэдгээрийн хаорондын жендерийн харилцаанд анхаардаг. “Жендер ба хөгжил” үзэл баримтлалд суурилдаг.

Шийдвэрлэх арга зам	Эмэгтэй хохирогчдод чиглэсэн хороогох байр, ойлголт мэдлэг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа; хууль эрх зүйн шинэчлэл эсвэл хуулийн хэрэгжилтийг сайжруулах (хүчирхийлэл үйлдэгчийг шийтгэх шийтгэлийг чангатгах); хууль сахиулагчид (шүүгч, цагдаа) эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд (эмч, сувилагч) болон нийгмийн ажилтнуудыг сургах гэх мэт.	Өмнөх аргуудын дээр нийгмийн өөрчлөлтийг өргөн хүрээнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алинд чиглүүлэх
---------------------	--	--

Эх сурвалж: Тахер, Н (2007-08) Жендерээс үүдэлтэй хүчирхийллийг авч үзэх хандлага

## Хүснэгт 1.2 Судалгаанд жендерийн дүн шинжилгээг тусгасан байдал

**“Ерөнхий судалгаа”** нь хүн амыг бүхэлд нь хамарсан гэж үзэж байгаа боловч жендерийн хувьд харалган судалгаа юм. Ийм судалгаанд эрэгтэйчүүдийг төлөөлсөн, эсвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хамруулсан жендерийн ялгаатай дүн шинжилгээ ихэнхдээ хийгдээгүй байдаг.

### “Эмэгтэйчүүд төвтэй” судалгаа

- “Уламжлалт” буюу эмэгтэйчүүд төвтэй судалгаа – Эдгээр судалгаанд нөхөн үргижүйн үүрэгтэй холбоотой асуудлыг судлахдаа зөвхөн эмэгтэйчүүдийг хамруулдаг.
- Эмэгтэйчүүд ба хөгжил сэдэвт судалгаа – Эмэгтэйчүүдийн жендерийн үүрэгт анхаарлаа хандуулдаг.
- Феминист, эмэгтэйчүүд төвтэй судалгаа – Энэ төрлийн судалгаа тэгш бус байдлын тухай ойлголтыг авч үздэг ба жендерээс үүдэлтэй улс төрийн асуудал, эрх мэдлийн харилцаа, хүйсийн төлөвшилд анхаарлаа хандуулдаг. Ихэнх феминист судалгаанд эцгийн эрхт ёсноос үүдэлтэй нийгмийн харилцааг ил гаргахыг зорьдог.

### “Жендер төвтэй судалгаа”

- “Жендержсэн” судалгаа – Ийм судалгаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийг тус тусад нь авч үзсэн байдаг. Судалгаа нь тодорхой нэг асуудлыг судлахыг зорьсон байж болох ч дүн шинжилгээ нь эрэгтэй, эмэгтэй хүйс, тэдний доторх ялгаатай нөхцөл байдал ба тухайн асуудал тэдэнд хэрхэн нөлөөлж буйг тусгасан байдаг.
- Феминист, жендер төвтэй судалгаа – Ийм судалгааны зорилго нь феминист, эмэгтэйчүүд төвтэй судалгаатай ижил боловч эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг хамруулан судалдаг. Жишээ нь эцгийн эрхт ёс, капитализм эсвэл өрхийн түвшин дэх жендерийн харилцаа гэх мэт асуудлыг судалж болно.

**Эрэгтэйчүүдийг судлах судалгаа** – “Шинээр” анхаарлын төвд орж ирсэн асуудал болох эр хүн гэж хэн бэ, эрэгтэй хүний шинж байдал гэх мэт сэдвийг эрэгтэйчүүдийн өнцгөөс дахин тодорхойлохыг зорьдог. Жишээ нь, гэр бүлийн хүчирхийллийн асуудалд эрэгтэйчүүд ба эр хүний шинж байдал нөлөөлөх нь гэх мэт.

**Эх сурвалж:** Taxer, H (2007-08) Жендерээс үүдэлтэй хүчирхийллийг авч үзэх хандлага

ЖҮХ-ийн талаархи тоо баримтыг цуглуулах дараахи аргууд байна:

- Хүн амд суурилсан түүвэр судалгаа (тусгайлсан болон модуль асуулга)
- Захиргааны болон үйлчилгээний тоо баримтын судалгаа

### **Хүн амд суурилсан түүвэр судалгаа**

Хүн амд суурилсан судалгаа буюу өрхийн түүвэр судалгаагаар хүчирхийллийн талаархи мэдээллийг иргэдээс асуух замаар цуглуулдаг ба энэ арга нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл ямар түвшинд байгаа талаар өрөнхий мэдээлэл цуглуулах хамгийн найдвартай аргад тооцогддог. Хүн амын түүвэр судалгаанд оролцогчдыг хүн амаас санамсаргүй түүврийн аргаар сонгон авдаг тул үр дүн нь хүн амыг төлөөлөх чадвартай байна. Санамсаргүй түүвэр буюу магадлал тооцсон түүврийн аргыг ашиглаагүй тохиолдолд судалгааны үр дүн нь тухайн судалгаанд оролцсоноос бусад хүмүүсийг төлөөлж чадахгүй. Мөн ийм төрлийн судалгаанд оролцогчдыг сонгохдоо тэдний хүчирхийлэлд өртсөн эсэхээс үл хамааралтайгаар сонгодог тул хүн амын дунд хүчирхийлэл ямар түвшинд байгааг захиргааны тоо баримтаас илүү бодитойгоор хэлж чаддаг. Тиймээс ийм төрлийн судалгаа нь жендерээс үүдэлтэй хүчирхийллийн цар хүрээг тодорхойлох, түүний цаг хугацааны өөрчлөлт, төлөв байдал, чиг хандлагад мониторинг хийх, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, бодлого боловсруулахад үр дүнтэй байдаг.

Хүн амд суурилсан судалгааны тоо баримтыг хоёр аргаар цуглуулж болно. Нэгдүгээрт, жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тодорхой хэлбэрүүдийн талаар мэдээлэл цуглуулахад чиглэсэн “тусгайлсан” судалгаа юм. Монгол Улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, ахмад настны эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг гэх мэт жендерээс үүдэлтэй хүчирхийллийн “тусгайлсан” асуудлаар нилээдгүй судалгаа хийгдсэн байна (Хүснэгт 1.1-ийг харна уу). Эдгээр судалгааны үр дүнгийн талаар энэхүү бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Хоёр дахь арга нь ядуурал, гэмт хэрэг, нөхөн үржихүйн эрүүл мэнд зэрэг нийгмийн чиглэлийн томоохон судалгаанд ЖҮХ-ийн талаар модуль асуулга оруулах арга юм. Монгол Улсад 2008 оны “Нөхөн үржихүйн эрүүл

мэндийн судалгаанд” эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар модуль асуулгыг анх удаа оруулжээ. Энэхүү судалгааг Үндэсний статистикийн хорооноос 5 жил тутам явуулдаг бөгөөд түүвэр нь хүн амын 1.13%-ийг хамардаг. Түүвэр судалгаанд хүмүүсийн үзэл бодол, зан үйлийг ихэвчлэн тоо, баримтаар илэрхийлдэг. Тоон судалгааны арга нь тухайн судлагдаж буй асуудал, нөхцөл байдлын давтамж, хүн амын дундах тархалтыг хэмжихэд илүү тохиромжтой байдаг. (Жишээ нь хэр олон эмэгтэй хүчирхийлэлд өртөж байгаа, ямар наасны эмэгтэйчүүд илүү өртдөг гэх мэт). Харин ийм төрлийн судалгаа нь нийт хүн амыг төлөөлөхүйц түүврийн хэмжээг шаарддаг тул өртөг өндөртэй бөгөөд түүвэрлэлтийг зохистой хийгээгүй тохиолдолд тухайн хүн амын талаар ерөнхийлөн дүгнэж болдоггүй. Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн чиглэлээр өмнө хийгдсэн судалгаануудад түүвэрлэлтийн аргыг тэр бүр дурьдаагүй байгаагаас тэдгээрийн үр дүн хүн амын төлөөллийг хангаж чадсан эсэхийг дүгнэхэд хүндрэлтэй байна.

### **Үйлчилгээний мэдээлэлд суурилсан судалгаа**

Иргэд хүчирхийлэлд өртсөний улмаас, эсвэл өөр асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагад хандаж үйлчилгээ авсан тухай захиргааны тоо баримт, мэдээлэлд үндэслэн судалгаа хийж болно. Үйлчилгээнд суурилсан мэдээллийг эрүүл мэндийн төвүүд, шүүх, цагдаагийн байгууллага, нийгмийн халамжийн үйлчилгээ, хамгаалах байр болон хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас авч болно.

Үйлчилгээнд суурилсан мэдээллийг хүчирхийллийн цар хүрээг тодорхойлоход ашигладаггүй. Учир нь хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн цөөн хэдхэн хувь л цагдаа, бусад үйлчилгээний байгууллагад ханддаг бөгөөд зөвхөн хүнд гэмтсэн тохиолдолд хандах нь бий. Гэхдээ эдгээр мэдээлэл нь хүчирхийллийн шалтгаан, динамик өөрчлөлт, хүчирхийлэлд нийгмийн зүгээс үзүүлж буй хариу үйлдлийн талаар олон чухал мэдээллийг өгдөг. Үйлчилгээнд суурилсан мэдээллийн эх сурвалжид Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн тайлан, цагдаагийн байгууллагын статистик мэдээ, Гэмтэл согогийн үндэсний төв, бусад эмнэлгийн байгууллагуудын өвчтөний түүхийг дурьдаж болох юм.

## **ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙГ МОНГОЛ УЛСАД СУДАЛСАН БАЙДАЛ**

Энэ хэсэгт Монгол Улсад урьд өмнө хийгдсэн судалгааны арга зүй, үр дүнд жендерийн дүн шинжилгээ хийх замаар жендерээс үүдэлтэй хүчирхийллийг судалсан байдал, судалгаанд ашигласан арга зүйг тоймлон үзүүлэв. Дараагийн хэсэгт өмнөх судалгааны үр дүнг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэсэн ангиллын дагуу хүчирхийллийн төрөл тус бүрийн тархалт, байршил, хэлбэр, хохирогч болон хүчирхийлэгчийн талаархи мэдээллийг өмнөх судалгаан дээр үндэслэн нэгтгэн дүгнэв.

### **Судалгааны сэдэв ба оролцогч байгууллагууд**

Шилжилтийн эхэн үеийн жендерээс үүдэлтэй хүчирхийллийн судалгаа нь хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн орчин дахь хүчирхийллийн асуудалд төвлөрч байсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсанаас хойш ахмад настны эсрэг хүчирхийлэл, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэх мэт тусгай хэрэгцээт бүлгүүдийг судалж эхэлсэн. Эдгээр судалгааг судалгааны мэргэшсэн төвүүд, хүний эрхийн болон хүүхдийн эрхийн байгууллагууд, ахмадын холбоо, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн холбоо, эрэгтэйчүүдийн холбоо зэрэг судалгаа, үйлчилгээ, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд ихэвчлэн НҮБХАС, НҮБХС, НҮБЭС, ДЗ-Монгол, Их Британий ХИС зэрэг олон улсын байгууллагууд болон Монголын эмэгтэйчүүдийн ТББ-ын санхүүжилтээр явуулжээ.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн эсрэг ЭКПАТ-ын Үндэсний сүлжээ, Ажлын байран дахь бэлгийн дарамтын (АББД) эсрэг ТББ-уудын үндэсний сүлжээ, Тэгш мөр зэрэг зарим ТББ хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн асуудлаар мэргэшин ажиллаж эхэлсэн зэргээс үүдэлтэйгээр судалгааны сэдэв нь гэр бүлийн хүчирхийллээс хальж хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, ажлын байран дахь бэлгийн дарамт гэх мэт нийгмийн хүрээн дэх хүчирхийллийн асуудлыг хамрах болсон.

ЭЯГБХУТК-ийн сүлжээнээс НҮБЭС-гийн санхүүжилттэйгээр 2008 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хүчирхийллийн асуудлаар сэдэвчилсэн

багц судалгааг хийсэн. Үүнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээ, ажлын байран дахь бэлгийн дарамт, гэрлэлт нэрийдлээр хүн худалдаалах гэмт хэрэг, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголт гэсэн сэдвүүдийг хамарсан байна<sup>5</sup>.

---

<sup>5</sup> UNIFEM 2009, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” төслийн тайлан. Тус тайланд эдгээр багц судалгааны бүрэн тайланг биш, зөвхөн товч танилцуулгыг ашигласан учраас судалгааны дизайн ба түүврийн талаар ямар нэг дүгнэлт хийх боломжгүй байв. Харин судалгааны гол үр дүнг зохих сэдвийн хүрээнд дурьдах болно.

Жендерээс цүдэлтэй хүчирхийлэл Монголд

**Хүснэгт 1.3 Монгол Улсад хийгдсэн хүн амд сууринсан судалгааг харьцуулах нь**

№	Судалгааны нар	Сэргэв	Он	Гүйцэтгэсэн байгууллага	Хамарсан хүрээ	Түүврийн хэмжээ	Судалгаанд оролцсон хүн ам	Судалгаанд оролцсон хүн амны нас
1	Хүчирхийлэл ба хүуль	Гэр бүлийн хүчирхийлийн тухай ойлголт	1998	ХАЗССТ, ХЭҮТ 2 дүүргэг	21 аймаг, УБ хотын 5000 хүн	1942 эмэгтэй; 1828 эрагтай; 1131 хүүхэд	13+	
2	Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг өр бүлийн хүчирхийлэл	Хүүхэд, эмэгтэйчүүдийн тухай тулгуур ойлголт	2005	ЭММЯ, ЭММХГ, НУБХС	УБ хотын 2 дүүргэг	1000 өрх	Эмэгтэйчүүд, 13+ настны хүүхэд	8% <14; 24% 15-24; 62% 25-54; 7% 55+
3	Сургууль, цэцэрлагийн орчин дахь бие мааходийн шийтгэл	Бие мааходийн шийтгэлийн тухай ойлголт	2005	ХИС, ЗХХКТ	УБ хот, Дорнод, Завхан, Овхрахангай, Архангай аймийн 14 сургууль, 8 цэцэрлаг	280 сургач, багш	Сургачид, сургууль, цэцэрлагийн багш нар	6-15
4	Ахмад настны зорэг хүчирхийлэл	Ахмад настны хүчирхийлийн тухай ойлголт	2004	Ахмадын Холбоо, ЗХХЖТ, ХЭҮТ	Төв аймаг, УБ хотын 7 дүүргэг	1000	55-аас дээш настны эмэгтэйчүүд; 60-аас дээш настны эрэгтэйчүүд	55+, 60+
5	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн талаархи ойлголт	2004	НУБЭС	Төвийн бусийн аймгууд	...	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд	...
6	Ажлын байран дахь бэлтийн дарамтын тухай ойлголт	Ажлын байран дахь бэлтийн дарамтын тухай ойлголт	2006	Нисора, АББД-ын эсрэг сүлжээ	...	533 албан хаагч	Ажлын эрэлдэг 233 эмэгтэй 147 эрэгтэй	Хөдөлмөрийн насны хүмүүс
7	Охид, эмэгтэйчүүдийг бэлтийн мөлжлэгт ашиглах зорилгоор худалдаалах гэмт хэрэг	Биеэ унэлдэг эмэгтэйчүүдийн талаарх ойлголт	2006	НУБХС, ХТЭТ, ДЗ	Бэзжин, Мякао, Гонг Конг-Д ажиллаж байсан хохирогчид	16 бүржир, ирсэн 48 одоо хийж байгаа	Бэлтийн мөлжлэлийн хохирогч эмэгтэйчүүд	...
8	Дээрх судалгаа	Олон нийтийн ойлголт	2006	Дээрхтэй ижил	УБ	450	Эрсдэлт булэг: Хүүхдийн орлогнох баир, ажилчийн, бага орлоготой ажилчид, оюутнууд	

Жендерээс цүдэлтэй хүчирхийлэл Монголд

<p>Хүн худалдаалах гэмт хэрэг Монголд: эрөдэл, эмзэг байдал, үр дагавар</p> <p>9</p>	<p>Олон нийтийн ойлголт</p> <p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай</p> <p>10</p>	<p>2006</p> <p>Азийн Сан, ХТЭТ, АНГОУХА</p> <p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай</p> <p>2005</p> <p>ХЭХТ, АНГОУХА, ДЗ, Азийн сан</p>	<p>УБ хотын 8 дүүрэг, Баянхонгор, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл</p> <p>УБ, Дархан, Сүхбаатар, Чойбалсан, Замын-Үд, БНХАУ-ын Эрээн хот</p>	<p>1212</p> <p>14-17 настны 195 хүүхэд; 18-35 насты 806 хүн; 211 уурхайн ажилчид (14-35 настны)</p> <p>141 эмэгтэй Эрсдэлийн бүлэг: Оюутнууд болон залуу охид</p>	<p>14-17</p> <p>18-35 14-35</p> <p>14+</p>
<p>Бэлтийн мөлжлэг боловн хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн ойлголт</p> <p>11</p>	<p>Олон нийтийн ойлголтонд нөлөөлөх хүчин зүйлс</p> <p>Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн ойлголт</p> <p>12</p>	<p>2004</p> <p>ЭКПЛАТ, НҮБХС, Тэш мөр</p> <p>Хүчирхийлэгч эрэгтайчүүдийн хүчирхийллийн зан үйл</p>	<p>... ...</p> <p>450</p>	<p>80 эрсдэлтэй охид, 80 эмэгтэй оюутан, 100 зочид буудлын ажилчин, 190 иргэн</p>	<p>80 эрсдэлтэй охид, 80 эмэгтэй оюутан, 100 зочид буудлын ажилчин, 190 иргэн</p>
<p>Хүчирхийлэгч эрэгтайчүүдийн хүчирхийллийн зан үйл</p> <p>12</p>	<p>Хүчирхийлэгч эрэгтайчүүд болон хохирогчдын ойлголт хандлага</p>	<p>2007</p> <p>Монголын эрэгтайчүүдийн холбоо</p>	<p>УБ хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүрэг</p>	<p>131 анкет, 15 ярилцлага, 54 хүнээс фокус булгийн ярилцлага</p>	<p>Хүчирхийлэл Үйлдсэн насанд эрэгтайчүүд; эмэгтэй хохирогч; олон нийтийн бүлэг; өвөр үеийн бүлэг; нийтийн ажилтнууд</p>

**Хүснэгт 1.4 Монгол Улс дахь үйлчилгээнд суурилсан судалгаанууд**

№	Судалгааны нэр	Он	Гүйцэтгэсэн байгууллага	Судалгааны мэдээллийн эх үүсвэр	Хамрах хүрээ
1	Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл	2005	ЭМЯ, ЭМХГ, НҮБХС	Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн мэдээлэл	38 хохирогчийн эрүүл мэндийн түүх
2	Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн эсрэг хуулийн орчин	2002	ХЭХТ, ХЭҮТ	1998-2000 шүүх, цагдаа, ДОХ-ын үйлчилгээний мэдээлэл	158 эмэгтэй
3	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх	2005	ХЭХТ, АНУОУХА, ДЗ, Азийн Сан	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч	18-25 насны 20 эмэгтэй
4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдал	2007	ХЭҮТ, ДЗ	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх шүүх байгууллагын мэдээлэл	Бүгд 40: 6 хохирогч, 6 гэмт хэрэгтэн, 13 албадлагаар, 15 үйлчилгээ
5	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн үйлчилгээ хүртэгчдийн мэдээлэл	2006	ХЭҮТ	ХЭҮТ-өөр үйлчлүүлэгчдийн мэдээлэл	
6	Хүчирхийллийн судалгаа	2007	ДЭМБ, ЭМХГ	Гэмтлийн эмнэлгийн өвчтөний түүх	Гэмтлийн эмнэлэгт эмчлүүлэгчид

Зарим судалгаанд хүн амд суурилсан болон үйлчилгээнд суурилсан мэдээллийн аль алийг нь ашигласан. Жишээ нь: “Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл” (2005) судалгаа. Ийм судалгааг дээрх 2 хүснэгтийн аль алинд нь зохих ангиллын дор оруулан авч үзсэн болно.

## A. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг судалсан байдал

### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр

Ихэнх судалгаанд хүчирхийллийг сэтгэл зүйн, бие махбодийн, бэлгийн гэх мэтээр хохирогчид гарч буй үр дагавраар нь ангилсан байна. Аливаа хүчирхийллийн хохирогчид эдгээр үр дагаврыг нэг зэрэг амсдаг. Жишээ нь нөхөртөө зодуулсны улмаас ХЭҮТ-ийн хамгаалах байранд байрлаж байсан 110 эмэгтэйн 21% нь нөхрийнхөө бэлгийн хүчирхийлэлд давхар өртдөг гэж мэдээлжээ. Судалгаанд бие махбодь, бэлгийн, сэтгэл санааны, эдийн засгийн хүчирхийлэл гэсэн ангиллыг ашигласан боловч эдгээр ангиллын дор өөр өөр үйлдлийг авч үзсэн байна. Тухайлбал Хүчирхийлэл ба хууль (1998) судалгаагаар сэтгэл зүйн (55.1%), эдийн засгийн эрх (18.1%), зодож гэмтээх (11%), бэлгийн дарамт (5.2%), хорьж цагдах (4.6%), эдийн засгийн дарамт (4.1%) гэсэн ангилалд хуваасан бол ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн төв, НУБХС-гийн судалгаагаар эдийн засгийн хязгаарлалт (2%), үл хайхрах, доромжлох (4.7%), айлган сүрдүүлэх (5.6%), сэтгэл санааны дарамт учруулах (13.9%), хэл амаар доромжлох (25.4%), бэлгийн мөлжлөг (1.8%), гэмтээх, гэмтэл учруулах (10.8%), зодох (35.8%) гэсэн ангилалд хуваасан байна.

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хүн амд суурилсан судалгаанд (2005) гэр бүлдээ хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүд бие махбодь (46.6%) болон сэтгэл санааны (46.9%) хүчирхийлэлд өртдөг гэж тэмдэглэжээ.

### Хүснэгт 1.5 Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрийг тодорхойлсон байдал

Судалгааны нэр	Хүчирхийллийн хэлбэрүүд, %			
	Бие махбодийн	Бэлгийн	Сэтгэл санааны	Эдийн засгийн
Хүчирхийлэл ба хууль, ХАЗССТ, 1998	15.7	5.2	55.1	22.2
Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ЭМЯ, 2005	46.6	1.8	46.9	2.0
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, 2004	Тодорхой-лоогүй	39	Тодорхой-лоогүй	Тодорхой-лоогүй
Хүчирхийлэч эрэгтэйчүүдийн зан үйл, Монголын эрэгтэйчүүдийн холбоо, 2007	27.6	1.7	63.8	6.9

Хүн амд суурилсан судалгаагаар бэлгийн хүчирхийлэл, ялангуяа гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл бага хувьтай мэдээлэгддэг гэдгийг анхаарах хэрэгтэй. Гэсэн

хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд хийсэн судалгаагаар тэдний 39% нь бэлгийн дарамт хүчирхийлэлд өртдөг гэжээ. Гэхдээ бусад хүчирхийллийн талаар мэдээлэл авах боломжгүй байлаа. ХЭҮТ-ийн үйлчилгээнд суурилсан мэдээллээр хүчингийн гэмт хэргийн хохирогчдын 64% нь гэр бүлийн гишүүд, хамаатан садан нь үйлдсэн байдаг гэж мэдээлжээ.<sup>6</sup>

### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тархалт

*Хүчирхийллийн тархалт* гэдэг нь тухайн хүн амын бүлэг дотор хүчирхийлэлд өртөж буй хүмүүсийн эзлэх хувийг хэлнэ. Тухайлбал тодорхой цаг хугацааны хүрээнд буюу сүүлийн 12 сард эсвэл амьдралынхаа хугацаанд 18-аас дээш насны эмэгтэйчүүдийн хэдэн хувь нь хүчирхийлэлд өртөж буйг илэрхийлнэ. Тархалтыг хүн амд суурилсан түүвэр судалгаагаар тодорхойлдог. Өмнө хийгдсэн хүн амд суурилсан судалгаануудад хугацааны хязгаарыг амьдралын турш хэмээн авч үзсэн нь жендерээс үүдэлтэй хүчирхийллийн динамик өөрчлөлтийг харуулж чадахгүй байна.

Монгол Улсад хүчирхийллийн талаарх хүн амд суурилсан анхны судалгааг 1995 онд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) болон тухайн үеийн Хүн ам зүйн бодлого, хөдөлмөрийн яамнаас хийжээ. Энэхүү судалгаанд 3,000 эмэгтэйг хамруулсан ба гурван эмэгтэй тутмын нэг нь ямар нэг хүчирхийлэлд өртдөг ба арван эмэгтэй бүрийн нэг нь зодуулдаг гэсэн үр дүн гарчээ.

МИУС-ийн Хүн ам зүйн сургалт судалгааны төв (ХАЗССТ) ба ХЭҮТ-өөс хамтран “Хүчирхийлэл ба хууль” сэдэвт судалгааг 1998 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай шинэ хуулийг батлуулах нэлөөллийн ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг үнэлэх зорилгоор явуулжээ. Энэхүү судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийг “гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчил, маргаан” хэмээн тодорхойлсон ба ойролцоогоор эмэгтэйчүүдийн гуравны нэг нь (31.6 хувь) нь гэр бүлдээ хүчирхийлэлд өртдөг гэжээ.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, НҮБХС-аас хамтран 1000 өрхийг хамарсан өрхийн түүвэр судалгааг Улаанбаатар хотын сонгосон дүүргүүдэд 2005 онд явуулсан ба судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 36 хувь нь өөрийн гэр бүл, ажлын байр, олон нийтийн дунд хүчирхийлэлд өртдөг гэж дүгнэжээ.

ҮСХ-ноос таван жил тутам тогтмол явуулдаг. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 2009 оны судалгаанд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн модуль асуулт оруулсан

<sup>6</sup> Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн Монгол дахь байдал, ЭМЯ, ХҮЭТ, ДЭМБ, 2007 он

бөгөөд тус судалгаанд оролцсон 6894 эмэгтэйн 19% нь нөхөр, хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн бие махбодийн хүчирхийлэлд өртөж байсан, 3.6% нь хэн нэгний бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэжээ.

### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн байршил

Судалгааны дүнгээс харахад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэр бүл, ажлын байр, боловсролын байгууллага, орон нутаг, нийгэмд гэх мэт бүх түвшинд оршиж байдаг нь харагдаж байна.

#### Хүснэгт 1.6 Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн байршлыг судалсан байдал

Судалгааны нэр	Хүчирхийллийн байршил, %			
	Гэр бүл	Ажлын байр	Сургууль	Гудамж, нийтийн тээвэр
Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, ЭМЯ, ЭТУГ, НҮБХС, 2005 он	84.9	5.9	3.2	4.0
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, 2004 он	38.0	-	-	45.0
Эмэгтэйчүүдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг, 2006	-	-	-	100.0

**Гэр бүлийн хүрээн дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл.** 2004 онд батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуульд гэр бүлийн хүчирхийллийг “гэр бүлийн хэн нэгэн гишүүнээс өөр нэг гишүүний эсрэг үйлдэж буй тэр гишүүнд хор хохирол учруулахуйц санаатай үйлдэл” хэмээн тодорхойлжээ. “Эмэгтэйчүүд ба хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл” (2005) судалгаанд эмэгтэйчүүдийн хүчирхийлэл ихэнхдээ гэр бүлийн хүрээнд болдог (84.9 хувь нь) гэжээ. Харин хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дунд явуулсан судалгаагаар (2004) тэдний 45% нь олон нийтийн газар ялгаварлан гадуурхал, дарамтанд өртдөг, 38% нь гэр бүлдээ дарамтанд өртдөг гэжээ.

**Ажлын байран дахь бэлгийн дарамт /АББД/.** Эмэгтэйчүүд зөвхөн гэр бүлдээ хүчирхийлэлд өртөхөөс гадна олон нийтийн газар, тухайлбал ажлын байрандаа мөн дарамт, хүчирхийлэлд өртдөг байна. Нисора сангийн зохицуулагчаар ажиллаж байгаа АББД-ын эсрэг ТББ-ын сүлжээнээс АББД-ын талаархи судалгааг 2006 онд Монголын эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэйгээр хийжээ. Судалгаанд АББД гэдгийг “бусдыг бэлгийн сэдэлттэйгээр дооглон тохуурхахаас эхлээд хүсээгүй, хүлээн авашгүйгээр дарамт шахалт үзүүлж, бэлгийн харилцаанд оруулах хүртэл

үйлдэгддэг гэмт хэрэг” гэж тодорхойлсон ба энэ нь амаар буюу уг хэлээр дарамтлах, үйл хөдлөл буюу үзүүлэх харуулах байдлаар дарамтлах, биеэр дарамтлах, үр дагавраар нь дарамтлах (*quid pro quo*) хэлбэрүүдээр илрнэ гэж үзсэн<sup>7</sup>. Энэхүү судалгааны хүрээнд 533 хүнээс (451 нь дээд боловсролтой) АББД-ын аль нэг хэлбэрт өртөж байсан эсэх, хэний зүгээс дарамталсан, хаана дарамталсан, дарамтлах нь хэр элбэг тохиолдсон, ямар хор уршигтай байсныг тандан судалсан. Тус судалгаанд оролцогчдыг боломжит түүврийн аргаар сонгосон тул Монгол Улсын ажил эрхэлж буй нийт хүн амьг төлөөлөх чадваргүй ч нийт 533 оролцогчдын 53% нь ажлын байрандаа бэлгийн ямар нэг дарамтанд өртдөг гэжээ. Өөрийгөө АББД-д өртсөн гэж үзсэн 280 хүний 277 нь эмэгтэй, 3 нь эрэгтэй байсан байна. Энэ нь ажлын байран дахь бэлгийн дарамтанд эмэгтэйчүүд хэт илүүтэйгээр өртдөгийг харуулж байна.

Мөн дээрх судалгааны хүрээнд 380 хүнээс олон нийтийн санал асуулга авахад 70% нь эрэгтэй хүн үйлддэг, 17% нь эмэгтэй хүн үйлддэг, 9% нь аль аль нь үйлддэг гэж үзсэн бол 65% нь эмэгтэйчүүд, 8% нь эрэгтэйчүүд, 20% нь аль аль нь өртдөг гэж үзжээ.

**Боловсролын байгууллага дахь бэлгийн дарамт.** НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сангийн санхүүжилтээр 2007-2009 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд их дээд сургуулийн 600 оюутан залуучуудын дунд хийсэн судалгаагаар оролцогчдын 42% нь “бэлгийн дарамтанд өртсөн хэн нэгнийг мэднэ”<sup>8</sup> гэж хариулжээ.

**Хүчингийн гэмт хэрэг.** Гэмт хэргийн талаарх тоо баримтаас харахад 1998-2000 онуудад нийт 1,146 хүчингийн гэмт хэрэг бүртгэгджээ. Хохирогчид бүгд эмэгтэй, түүний 60% нь насанд хүрээгүй охид байсан ба эдгээр гэмт хэргийн 88%-ийг хэрэгсэхгүй болгожээ.

**Эмэгтэйчүүдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэрэг.** НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци, түүний нэмэлт протокол болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-д хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлоходоо: “хэн нэгнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх эсвэл хүч хэрэглэх, эсвэл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах эсхүл тухайн хүнийг халамжиндаа байлгаж буй өтгөөдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, эсвэл шан харамж өгөх эсвэл авах зэрэг аргаар хүмүүсийг элсүүлэх,

<sup>7</sup> АББД-ын эсрэг ТББ-ын сүлжээ ба Нисора сангаас 2008 оны 3-р сарын 5-аас 4-р сарын 30-ны хооронд зохион байгуулсан 420 сургач багш бэлтгэх сургалтын гарын авлагаас авав.

<sup>8</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Сангийн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл”. Төслийн тайлан. Хэрэгжүүлэгч байгууллагууд: Иргэдийн Альянс төв, Хүний эрх хөгжил төв, Хүчирхийлийн эсрэг үндэсний төв. Улаанбаатар. 2009 он.

тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээн авах үйлдлийг хэлнэ. Мөлжих гэдэг нь наад зах нь бусдын биеийг нь үнэлүүлэх, эсвэл бэлгийн харилцаанд оруулах, албадан ажиллуулах, эсвэл үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төстэй нөхцөлд байлгах, эрх чөлөөгүй байлгах, эсвэл эд эрхтэнийг нь авах зэрэг үйлдлийг багтаадаг".<sup>9</sup> Хүн худалдаалах гэмт хэрэг нь улс орны дотоодод болон улс орны хооронд явагддаг ба хохирогч нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг болон бэлгийн мөлжлөгийн талаарх судалгаа нь ихэвчлэн олон нийтийн болон эрсдэлтэй бүлгийн ойлголт, хандлагыг судлахад чиглэсэн байна. Хамгийн анх 2001 онд хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн асуудлыг судалсан. ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр /АЙПЕК/-ийн дэмжлэгтэйгээр ХАЗССТ-өөс өсвөр наслын 1193 хүүхдийг хамруулан бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэх асуудлын талаарх ойлголтыг судлахад оролцогчдын 12.8% нь хэн нэгнэтэй бэлгийн харилцаанд орсон, 17.2% нь биеэ үнэлдэг хэн нэгнийг мэднэ гэж хариулсан байна. ЭКПАТ, Тэгш мөр, НҮБ-ын Хүүхдийн сангаас 2004 онд хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголтыг судалсан судалгаанд оролцогч охидын 35% нь биеэ үнэлэх үйл ажиллагаанд уруу татагдсан хэн нэгэн охиниг мэднэ гэжээ. Энэхүү судалгаагаар биеэ үнэлэх явдал нь шөнийн клуб, цэнгээний газрууд (29%), зочид буудал (17.5%), дуудлагаар (11%), зуучлагчдын бэлтгэсэн тусгай байранд (25%), захууд дээр (17.5%) гэх мэт ихэвчлэн олон нийтийн газар тохиолддог гэж үзжээ.

Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас 2006 онд явуулсан хүн худалдаалах гэмт хэргийн талаархи ойлголтыг судалсан өөр нэг судалгаагаар насланд хүрэгчдийн 14.3%, хүүхдийн 8.2% нь бэлгийн мөлжлөгт өртсөн хэн нэгнийг мэднэ гэжээ. Мөн онд Хүйсийн тэгш эрхийн төвөөс Дэлхийн зөн, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 16 эмэгтэйг хамруулсан судалгаа хийж хохирогчийг хэрхэн элсүүлдэг, тэдэнд ямар үр дагавар, хор хөнөөлтэй талаар дэлгэрэнгүй мэдээллийг судалжээ.

### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй бүлгүүд

Хүн амд суурилсан болон үйлчилгээнд суурилсан судалгаанаас хараад 25-45 наслын эмэгтэйчүүд хүчирхийлэлд илүүтэйгээр өртөж байна. Тухайлбал ЭМЯ, ЭТУГ, НҮБХС-аас явуулсан 2004 оны судалгаанд 25-44 настай эмэгтэйчүүд судалгаанд оролцогчдын 48%-ийг эзэлж байсан боловч хүчирхийлэлд өртөгсдийн


<sup>9</sup> НҮБ-ын Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх тухай конвенцийн "Хүн худалдаалах, тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай" нэмэлт протоколоос авав.

## Жендерээс цдэлтэй хүчирхийлэл Монголд

60% орчмыг эзэлж байжээ. ХЭҮТ-өөр үйлчлүүлэгчдийн 77%-ийг 25-39 насны эмэгтэйчүүд эзэлж байна.

**График 1.1**

**Хүчирхийллийн хохирогчийн насны ангилал, судалгааны үр дүнг харьцуулах нь**



Судалгаанаас харахад дээд боловсролтой байх нь эмэгтэйчүүдийг хүчирхийлээс хамгаалдаггүй. ЭМЯ-ны судалгаагаар хохирогчдын 48% нь дээд боловсролтой, 8% нь техник мэргэжлийн дунд, 36% нь бүрэн дунд, 8% нь бүрэн бус дунд мэргэжилтэй байжээ. Гэхдээ энэ тоо баримт дээд боловсролтой эмэгтэйчүүд тусламж үйлчилгээнд илүүтэйгээр хамрагддагийг илэрхийлж байж болох юм.

ХЭҮТ-ийн мэдээгээр эмэгтэйчүүд ажилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, эсвэл бага цалинтай байх нь хүчирхийлэлд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг. Хохирогч эмэгтэйчүүдийн ихэнх нь ажилгүй (36%), эсвэл төсвийн байгууллагад доогуур албан тушаалд ажилладаг (24%), хувиараа хөдөлмөр эрхэлдэг (16%), хувийн компанийд ажилладаг (20%) байна. Хүн амд сууринсан судалгаагаар “өрхийн сарын орлого нь 60000 төгрөгнөөс доош орлоготой эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл нь өндөр байна”<sup>10</sup> гэжээ.

### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хэн үйлдэж байна вэ?


Хүчирхийлэл хаана болж буйгаас шалтгаалан эмэгтэйчүүд гэр бүлдээ бэлгийн хамтрагч, эцэг эх, насанд хүрсэн хүүхдүүдийнхээ хүчирхийлэлд, ажлын байрандаа тэдний удирдах ажилтнууд, хамтран ажиллагсдын зүгээс, гудамж талбайд танихгүй эрэгтэйчүүдийн хүчирхийлэлд өртөж байгаа нь судалгаануудаас харагдаж байна.

Эмэгтэйчүүд ихэвчлэн гэр бүлдээ буюу хамгийн дотны хүмүүсийнхээ хүчирхийлэлд өртөж байна.

<sup>10</sup> ЭМЯ, ЭТУГ, НУБХС. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр булийн хүчирхийлэл. УБ хот, 2005 он

### График 1.2


#### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид: судалгааны үр дүнг харьцуулах нь



Хүн амд сууринсан болон үйлчилгээнд сууринсан судалгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг гол буруутан нь тэдний бэлгийн хамтрагч болж байна. ЭМЯ, ЭТУГ, НҮБ-ын Хүүхдийн сангийн 2005 оны судалгаагаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдийн 57.1% нь тэдний нөхөр, найз залуу, салсан нөхөр байсан бол ХАЗССТ, ХЭҮТ-ийн 1998 оны судалгаанд энэ хувь 49% байжээ. ХЭҮТ-өөр үйлчлүүлэгч эмэгтэйчүүдийн 85% нь нөхрийнхөө хүчирхийлэлд өртсөн байжээ.

### График 1.3

#### Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид насын бүлгээр (ХЭҮТ-ийн үйлчилгээнд сууринсан мэдээлэл)



**Хүчирхийлэгчийн насны ангилал.** ХЭҮТ-өөр үйлчлүүлэгчдийн дунд хийсэн судалгаанаас харахад 30-40 насны эрэгтэйчүүд хамгийн ихээр хүчирхийлэл үйлддэг ба үүний дараа 40-50, 20-30 насны эрэгтэйчүүд орж байна. Дээрх хүснэгтийг харна уу.

**Хүчирхийлэгчийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал.** Эрэгтэйчүүдийн холбооноос 2007 онд явуулсан хүчирхийлэгч эрэгтэйчүүдийн зан үйлийн талаархи судалгаагаар тэдний 21% нь дээд, 10.5% нь техник мэргэжлийн, 29% нь бүрэн дунд, 31.5% нь бүрэн бус дунд, 7% нь бага боловсролтой байсан нь хүчирхийлэгч эрэгтэйчүүдийн боловсролын түвшин хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн боловсролын түвшингээс харьцангуй доогуур байгааг харуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувьд 25% нь ажилгүй, 29% нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 21% нь хувийн хэвшилд, 4% нь төсвийн байгууллагад ажилладаг байна.

#### **Б. Эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг судалсан байдал**


Өмнөх судалгаануудад хүчирхийллийг зөвхөн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” гэдэг өнцгөөс судалсан нь эрэгтэйчүүд, хөвгүүдийн эсрэг хүчирхийллийг авч үзэхгүй байхад хүргэсэн. Иймээс өмнөх судалгаануудаас эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдээллийг түүвэрлэж олоход хүндрэлтэй байлаа. Иймээс энэ хэсэгт жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тодорхойлолтыг ашиглан “эрэгтэй болж төрснөөсөө эрэгтэй хүн хохирч буй, эсвэл эрэгтэйчүүд илт илүүтэйгээр хохирч буй хүчирхийллийг” эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хэмээн авч үзлээ.

#### **Эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тархалт, байршил, хэлбэр**

1998 оны “Хүчирхийлэл ба хууль” судалгаагаар 20-оос дээш насны 1828 эрэгтэйчүүдийг хамруулсан ба тэдний 25.1% буюу 4 эрэгтэй тутмын 1 нь гэр бүлдээ хүчирхийлэлд өртдөг гэж үзжээ. Гэхдээ энэ судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг “гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчил маргаан” хэмээн өргөн хүрээтэй тодорхойлсныг дурьдах нь зүйтэй гэж үзлээ.

ЭМЯ, ЭТУГ, НҮБХС-гийн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл” судалгааны гэмтэл согогийн эмнэлгийн үйлчилгээний талаарх тайланд хүчирхийллийн улмаас гэмтэл бэртэл авч эмчлүүлэгсдийн 80% нь эрэгтэйчүүд гэж мэдээлжээ. Эдгээрийн дунд 5-14 насны хүүхэд, 25-34 насны залуучууд ихэнх хувийг эзэлж байлаа.

**График 1.4**  
**Хүчирхийлэлд өртсөн эрэгтэйчүүдийн насны ангилал**



Эх сурвалж: ЭМЯ, ЭТУГ, НУБХС, 2005

Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс ялгаатай нь олон нийтийн газар хүчирхийлэлд өртөх нь элбэг байна. Хохирогчдын 80%-ийг эрэгтэйчүүд эзэлж буй гэмтэл согогийн эмнэлгийн дээрх мэдээллээс харахад хүчирхийллийн 54.5% нь олон нийтийн газар, 9% нь сургууль ба нийтийн унаанд, 31% нь орон гэрт үйлдэгджээ.<sup>11</sup> Гудамжинд амь насаа алдагсдын 84.8% нь эрэгтэйчүүд байгаа<sup>12</sup> нь эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ихэвчлэн гудамжинд үйлдэгдэгийг харуулж байна. Хэдийгээр гудамжинд амь насаа алдсан тохиолдол бүрийг, тухайлбал авто замын ослыг хүчирхийлэл гэж үзэж болохгүй ч ийм төрлийн үйлдэлд эрэгтэйчүүд илт илүүтэйгээр өртөж байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн өөртөө хохирол учруулсан үйлдлүүдээс эрэгтэйчүүд илүүтэйгээр хохирч байна. 1991-2002 оны эрүүл мэндийн статистик тоо баримтаас харахад зөвхөн Улаанбаатар хотод нийт 5056 хүн өөртөө хохирол учруулснаас 1765 нь амиа хорлосон, 3271 нь амиа хорлох оролдлого хийсэн байна. Амиа хорлогсдын 80.9% нь эрэгтэйчүүд байсан ба амиа хорлохыг оролдогсдын 44% нь эрэгтэйчүүд байсан.

**Эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид**

Эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдээс ялгаатай нь судалгаанаас харагдаж байна. Гэмтэл согогийн эмнэлгийн мэдээллээс харахад (ЭМЯ, ЭТУГ, НУБХС, 2005)


<sup>11</sup> ЭМЯ, ЭТУГ, НУБХС. "Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл", УБ, 2005 он

<sup>12</sup> WHO Centre for Health Development (2007) National Report on Violence and Health in Mongolia. Kobe, Japan

эрэгтэйчүүдийг үл таних хүн (50%), тэдний найз, зүс таних хүмүүс (26%) хүчирхийлдэг байна. ХАЗССТ, ХЭҮТ-ийн хүн амд суурилсан судалгаагаар эрэгтэйчүүдийг тэдний ажлын байранд нь удирдах ажилтнууд (20%), гэр бүлд нь эхнэр (22%), хадам эцэг эх нь (17%) хүчирхийлдэг гэжээ.

График 1.5

Эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид: Судалгааны үр дүнг харьцуулах нь



Эндээс харахад эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлээс төрөл, хэлбэрээрээ ялгаатай байгаа нь харагдаж байна. Эмэгтэйчүүд өөрийн гэр бүлдээ тэдний дотны хүмүүсийн үйлдсэн хүчирхийллийн хохирогч болдог бол эрэгтэйчүүд ихэвчлэн олон нийтийн газар танихгүй хүний үйлдсэн бие маходийн хүчирхийллийн хохирогч болдог нь харагдаж байна.

## B. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг судалсан байдал

### Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд

Хүүхдүүд ихэвчлэн бие маходийн хүчирхийлэлд (28.9%) өртдөг ч мөн сэтгэл санааны хүчирхийлэл (18.8%), эдийн засгийн мөлжлөгөд (8.6%) өртөх тохиолдол байна. Хүн амд суурилсан судалгаагаар хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл тэмдэглэгдээгүй ч ХЭҮТ-ийн мэдээллээс харахад хүүхдүүд гэр бүлдээ бэлгийн хүчирхийллийн хохирогч болох нь элбэг байна. ХЭҮТ-өөр сүүлийн гурван жилд үйлчлүүлсэн 117 хүүхдийн 34.1% нь ураг төрлийн хүчингийн хохирогч болсон байна. Гэмт хэргийн талаарх тоо баримтаас харахад 1998-2000 онуудад нийт 1,146 хүчингийн гэмт хэрэг бүртгэгдсэнээс, хохирогчдын 60% нь насанд хүрээгүй охидууд байсан байна.

**Хүснэгт 1.7 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, судалгааны үр дүнг харьцуулах нь**

Судалгааны нэр	Хүчирхийллийн хэлбэрүүд, %			
	Бие махбодийн	Бэлгийн	Сэтгэл санааны	Эдийн засгийн
ЭМЯ, ЭТУГ, НҮБХС. 2005, Эмэгтэйчүүд хүүхдийн эсрэг хүчирхийлэл	28.9	..	18.8	8.6
ХИС, ЗХЖТ, 2005. Сургууль цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл	71.1	..	41.9	..

**Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тархалт, байршил**

Гэр бүлийн болон сургуулийн орчинд хийсэн хоёр өөр судалгаагаар хүүхдийн тэн хагас нь гэр бүлдээ болон сургуулийн орчиндоо хүчирхийлэлд өртдөг гэж мэдээлжээ. 1998 оны “Хүчирхийлэл ба хууль” судалгаанд 13-19 настны 1131 хүүхэд хамрагдсаны 55% буюу хоёр хүүхэд тутмын нэг нь гэр бүлдээ хүчирхийлэлд өртдөг гэж хариулжээ.

2005 оны Их Британий Хүүхдийг ивээх сангаас сургууль, цэцэрлэгүүдэд 18-аас доош настны хүүхдүүдийг хамруулан хийсэн судалгаанд оролцогсдын тал хувь нь боловсролын байгууллагад хүчирхийлэлд өртсөн гэжээ. Харамсалтай нь энэхүү судалгааны үр дүнг хүйсээр ялган харах боломжгүй байлаа.

ЭМЯ, ЭТУГ-ын 2005 оны судалгаагаар хүүхдүүдийн 38.7% нь хүчирхийлэлд өртдөгөөс гэр бүлдээ 70%, гудамж талбайд 25% хүчирхийлэлд өртдөг гэж дүгнэсэн байна. Дээрх судалгаагаар 6-18 настны хүүхдийн 35.7%, 5-аас доош настны хүүхдийн 26.5% нь хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлсэн нь бүх настны хүүхэд гэр бүлдээ хүчирхийлэлд өртөж байгааг харуулж байна.

**Хүснэгт 1.8 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн байршил, хувиар**

Судалгааны нэр	Байршил			
	Гэр бүл	Ажлын байр	Сургууль	Гудамж, олон нийтийн газар
Хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, ЭМЯ, ЭТУГ НҮБХС, 2005	69.9	–	5.0	25.0
ХИС, ЗХЖТ, 2005. Сургууль цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл	53.2	..	42.3	..

### Хүүдийн эсрэг хүчирхийлийг хэн үйлдэж байна вэ?

Хүүхэд гэр бүлдээ эцэг эх (27.2%), хойд эцэг эх (29.9%), ах дүү (13.6%), болон бусад гэр бүлийн гишүүдийнхээ хүчирхийлэлд,<sup>13</sup> сургуулийн орчиндоо тэдний багш нарын болон үе тэнгийнхний хүчирхийлэлд<sup>14</sup> өртөж байна.

#### Г. Ахмад настны эсрэг хүчирхийлийг судалсан байдал

ХЭҮТ, Монголын ахмадын холбооноос хамтран 2002 онд ахмад настнуудын эсрэг хүчирхийлийн талаар хүн амд суурилсан судалгааг хийсэн. Энэхүү судалгааг дээрх хоёр байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан 20 ахмад настан санаачилжээ.

#### Ахмад настны хүчирхийлийн хэлбэр

Ахмад настнуудын 63.2% ихэвчлэн үл хайхрах, хөгшин гэж доромжлох, айлан сүрдүүлэх зэрэг сэтгэл санааны хүчирхийлэлд, 25.7% тэтгэврийг нь хураан авах, гэр орныг нь зөвшөөрөлгүйгээр зарж, худалдах, хангалттай хоол хүнс өгөхгүй байх зэрэг эдийн засгийн хүчирхийлэлд, 14.3% нь бие махбодийн хүчирхийлэлд өртдөг ба энэ тохиолдолд гэмтэл, бэртэл авах нь элбэг байдаг.

#### Хүснэгт 1.9 Ахмад настны эсрэг хүчирхийлийн хэлбэрүүд

Судалгааны нэр	Хүчирхийлийн хэлбэрүүд, %			
	Сэтгэл санааны	Бие махбодийн	Бэлгийн	Эдийн засгийн
Ахмад настны эсрэг хүчирхийлэл	63.2	14.3	..	25.7

#### Ахмад настны эсрэг хүчирхийлийн тархалт, байршил

Дээрх судалгаагаар ахмадуудын 25% буюу 4 ахмад тутмын 1 нь хүчирхийлэлд өртдөг ба ихэвчлэн гэр бүлд (68.7%) үйлдэгддэг гэжээ. Эмэгтэйчүүд судалгааны түүврийн 52.9%, хохирогчдын 57.4%-г эзэлж байв.

#### Хүснэгт 1.10 Ахмад настны эсрэг хүчирхийлийн байршил

Судалгааны нэр	Байршил			
	Гэр бүл	Ажлын байр	Сургууль	Гудамж, олон нийтийн газар
Ахмад настны эсрэг хүчирхийлэл, 2005 он	68.7	..	..	31.3

<sup>13</sup> Хүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, ЭМЯ, ЭТУГ НУБХС, 2005


<sup>14</sup> ХИС, ЗХЖТ, 2005. Сургууль цэцэрлэгийн орчин дахь хүүдийн эсрэг хүчирхийлэл

### Ахмад настны эсрэг хүчирхийллийг хэн үйлдэж байна вэ?

Ахмад настнууд ихэвчлэн хамаатнуудын (58%), тухайлбал өөрийн төрсөн хүүхэд (38.6%), хүргэн, бэр (1.2%), ач хүүхэд (18.2%)-ийн хүчирхийлэлд өртөж байна. Түүнчлэн 10% нь эхнэр эсвэл нөхрийнхөө, 30.9% нь хэн нэгэн согтуу хүний хүчирхийлэлд өртдөг.<sup>15</sup>

График 1.6

### Ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдэгчид: Судалгааны дүн



### Д. Хүчирхийллийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан байдал

#### Олон нийтийн үзэл бодол


Өмнө хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад олон нийтийн дунд хүчирхийллийн шалтгааныг архидалт, ажилгүйдэл, ядууралтай холбож үзэх нь нийтлэг байна. Ялангуяа ахмад настнууд ядуурлыг хүчирхийллийн гол шалтгаан хэмээн үзэж байв. Энэ нь хүчирхийллийн асуудлыг жендэрийн орчинтой холбон дүн шинжилгээ хийх шаардлагатайг дахин нотолж байна. Хэдийгээр архидалт нь хүчирхийлэлд нөлөөлөх хүчин зүйл мөн боловч суурь шалтгаан нь биш юм. Тухайлбал, хүчингийн гэмт хэрэг үйлдэгчдийн тэн хагас нь гэмт хэрэг үйлдэхдээ согтуу байсан гэж мэдэгджээ. Эндээс хүчингийн гэмт хэргийн шалтгааныг архидалт гэж үзэж болохгүй нь мэдээж. Согтуу байсан нь хэн нэгний хүчирхийлэх шалтгаан биш юм.

Гэр булийн хүчирхийллийн шалтгааныг гэр булийн доторх хэрүүл маргаан, бие биенээ үл хүндлэх, тухайлбал ахмад настныг үл хүндэтгэх, хүүхдийн хүсэл сонирхлыг үл хайхрах зэрэг гэр булийн гишүүдийн хоорондын харилцааны асуудал хэмээн олон хүн үзсэн байна.

Зарим нь хүчирхийллийн шалтгааныг хүчирхийлэгчийн асуудал шийдвэрлэх ур чадвар дутмаг, хардалт зэрэг хувь хүний зан үйлтэй холбон тайлбарласан байна. График 1.7-г харна уу.

<sup>15</sup> Ахмадын Холбоо. Ахмад настны эсрэг хүчирхийлэл. 2002

**График 1.7**  
**ЖҮХ-ийн шалтгааны талаарх үзэл бодол, тайлбар**




### Хохирогчийн үзэл бодол

Хүчирхийллийн шалтгааны талаарх хохирогчийн болон хүчирхийлэгчийн үзэл бодол нь өмнө дурьдсан олон нийтийн үзэл бодлоос ялгаатай байгаа нь судалгаануудаас харагдаж байна. Хохирогч эмэгтэйчүүд хүчирхийллийн шалтгааныг хүчирхийлэл үйлдэгчийн зан байдалтай тухайлбал архидалт, догшин ааш авир, хардалт, харилцааны чадвар дутмаг, хүчирхийлэгчийн хүч чадал, эрх мэдлээ харуулах гэсэн хүсэл, гэр бүлийн хүмүүжил зэргээр тайлбарлаж байна. Харин ажилгүйдэл, ядуурлыг маш цөөн хохирогч хүчирхийллийн шалтгаан гэж үзжээ.

**График 1.8**

**Хүчирхийллийн шалтгааны талаарх хохирогчийн үзэл бодол**




### Хүчирхийлэгчийн үзэл бодол

Хүчирхийллийн шалтгааны талаарх хүчирхийлэгчийн үзэл бодлыг ХЭҮТ-ийн үйлчлүүлэгчдийн цөөн тохиолдол дээр судалсан байдаг. Энэхүү судалгаагаар хүчирхийлэгчид хүчирхийллийн гол шалтгааныг бие биеэ үл хүндэтгэх (47%), найз нөхдийн болон хэвлэл мэдээллийн нөлөө (39%), гэр бүлийн хүмүүжил (24%), архи хэтрүүлэн хэрэглэх (18%) зэрэгтэй холбон үзсэн байна.

График 1.9

#### Хүчирхийллийн шалтгааны талаарх хүчирхийлэгчийн үзэл бодол



## E. Жендерээс цүдэлтэй хүчирхийллийн үр дагавар, өртөг

Хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн өртгийг тооцоолох нь бодлого боловсруулагчдад хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны ач холбогдол, үр нөлөөг ойлгуулах чухал ач холбогдолтой байдаг.<sup>16</sup> Хүчирхийллийн үр дагавар, өртгийг дараах дөрвөн ангилалд хувааж авч үздэг. Үүнд:

1. **Шууд өртөг:** сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр, цагдаагийн дуудлага, баривчлах үйл явцын зардал, эрүүгийн байцаан шийтгэх зардал, түр хорогох байр болон урьдчилан сэргийлэх, нөлөөлөх сургалт зохион байгуулах зэрэг бүх төрлийн нийгмийн үйлчилгээний өртөг гэх мэт;
2. **Мөнгөн бус өртөг:** сэтгэлийн шарх, туулсан зовлон бэрхшээл, өвчлөл, нас барагт гэх мэт;
3. **Эдийн засгийн дам үр дагавар:** хөдөлмөрийн зах зээлийн бүтээмжид нөлөөлөх гэх мэт;
4. **Нийгмийн дам үр дагавар:** хүмүүсийн хоорондын харилцаа, амьдралын чанарт гарах үр дагавар гэх мэт.

Өмнө хийгдсэн судалгаанд хүчирхийлэл нь хохирогчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдгийг олон баримтаар баримтжуулсан байна. ЭМЯ, ЭТУГ, НУБХС-ын 2005 оны судалгаагаар эмэгтэйчүүдийн 68% нь сэтгэл зүйн ямар нэгэн цохилтонд орсон, 33.6% нь гэмтэж бэртсэн, 3.2% нь хар дарж зүүдэлдэг болсон гэжээ.<sup>17</sup> Үйлчилгээний тоо баримтууд ч мөн хүчирхийллийн улмаас иргэд эрүүл мэндээрээ хохирч байгааг харуулж байна. ХЭҮТ-өөр 2006 онд үйлчлүүлсэн 463 хохирогчийн 15 нь хүнд бэртэл авсан, 7 нь амиа хорлох оролдлого хийсэн, 11 нь сургууль завсардсан, 17 хүүхдийн зан байдалд өөрчлөлт орсон, 13 нь гэрээсээ дайжсан байжээ. Ахмад настны эсрэг хүчирхийллийн судалгаагаар хохирогчийн 42.8% нь сэтгэл зүйн дарамтанд өртсөн гэжээ. Хүн худалдаалах, биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүд сэтгэл санааны цочролд орох, бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ-ийн халдварт авах эрсдэлд өртдөг. Халдварт өвчний үндэсний төвийн мэдээлснээр хүчингийн гэмт хэргийн хохирогч 940 хүнээс ДОХ-ын шинжилгээ авахад 14.7% нь бэлгийн замын халдварт авсан байжээ.<sup>18</sup>

Дээрх үр дагавартай холбоотойгоор хүчирхийллийн хохирогчид болон үйлчилгээний байгууллагуудад тодорхой зардал гардаг. Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 38.2% нь хүчирхийллийн улмаас 7-10 хоног эмчлүүлсэн, 13.5% нь хөгжлийн бэрхшээлтэй болсон, үүнээс 35% нь хөдөлмөрийн чадвараа 20-

<sup>16</sup> UNICEF. Domestic Violence against Women and Girls, *Innocent Digest*, No. 6, June 2000.

<sup>17</sup> ЭМЯ, ЭТУГ, НУБХС. 2005. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллэл, 51-р тал

<sup>18</sup> WHO Health Research Center. 2007. National Report on Violence: Desk review. Kobe, Japan

30%-аар алдсан байна. Эмчилгээ хийлгэхдээ 53.6% нь гэртээ, 24.1% нь амбулатороор, 18.4% эмнэлэгт хэвтэн эмчлүүлжээ. Эмчилгээний зардалд хохирогч дунджаар (2005 онд)<sup>19</sup> 20,000-50,000 төгрөг заржээ. Ерөнхийлөгч асан Н.Багабанди 2005 онд УИХ-ыг нээж хэлсэн үгэндээ “сүүлийн 3 жилд 5821 хүн хүчирхийллийн хохирогч болж, үүнд төрөөс 70 тэрбум төгрөг зарцуулсан” гэж мэдээлсэн байна.<sup>20</sup> Эдгээр баримт нь хүчирхийлэл өрх гэр бүлийн төсөв болон улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлдгийг харуулж байна.

Хүн амд сууринсан зарим судалгаагаар хүчирхийллийн эдийн засагт гарах дам үр дагаврыг баримтжуулсан байна. ЭМЯ, ЭТУГ, НУБХС-ийн 2005 оны судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын 22.8% нь биеийн ил харагдах хэсэгтээ хөхрөл, гэмтэл авсны улмаас 3-7 хоног ажилдаа яваагүй ба энэ үеийнхээ цалинг хасуулсан, 25% нь ажлаасаа гарсан гэжээ. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад хүчирхийллийн улмаас ажлаасаа гарах нь 3 дахин илүү тохиолддог байна.

Өмнөх судалгаанд хүмүүсийн хоорондын харилцаа, хүүхдэд нөлөөлөх сөрөг үр дагавар гэх мэт нийгэмд гарах дам үр дагаврын талаар бараг дурьдаагүй байна.

Хүчирхийлэл нь зөвхөн хохирогчид биш хүчирхийлэгчдэд мөн ямар нэгэн байдлаар нөлөөлдөг байна. Хүчирхийлэгч эрэгтэйчүүдийн судалгаагаар тэдний 41.7% нь өөрийнхөө үйлдэлд буруутай гэдгээ ойлгосон, 41.7% нь өөрсдийгөө хүчирхийллийн хохирогч гэж үзсэн, 4.2% нь өөрсдийгөө ялсан гэж үзэж байжээ. Хүчирхийлэл үйлдэгчийн 75% нь зан үйлийг өөрчлөх сургалтанд суух хүсэлтэй, 21% нь ийм сургалтанд хамрагдах хүсэлгүй гэжээ. Хүчирхийлэгчийн 62.5% нь хүчирхийлэгчдэд чиглэсэн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх ямар нэг үйлчилгээ хэрэгтэй гэж үзжээ.

#### Ж. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүчирхийлэлд үзүүлэх хариу үйлдэл


Хүн амд сууринсан болон үйлчилгээний судалгаануудаас харахад хохирогчдын цөөн хувь нь буюу дөнгөж 20% нь хүчирхийллийг хэн нэгэнд мэдээлдэг байна.

---

<sup>19</sup> ЭМЯ, ЭТУГ, НУБХС. 2005. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл,


<sup>20</sup> WHO Health Research Center. 2007. National Report on Violence and Health. Kobe, Japan.

**График 1.10**  
**Хүчирхийллийг мэдээлэх ба үл мэдээлэх хувь**



Хүчирхийлэгч эрэгтэйчүүдийн дунд хийсэн судалгаагаар хохирогчдын 80% нь эхлээд хүчирхийлэгчийн зан үйлийг өөрчлөхийг оролдсон байна. Эдгээр тохиолдуудын 48% нь түр хугацаанд өөрчилж чадсан, 36% нь огт нөлөөлөөгүй гэжээ. Үүний дараа хохирогч гэр бүлдээ (25.8%), цагдаад (25.8%), үйлчилгээний байгууллагад (19.4%), нийгмийн ажилтанд (3.2%) мэдээлсэн ба 13% нь хаана хандахаа мэдэхгүй байжээ. ЭМЯ, ЭТУГ, НҮБХС-ийн судалгаагаар хохирогчийн 42% нь хамаатан садныхаа хүнд, 20% нь найз нөхөддөө, 16% нь цагдаад ханджээ.

**График 1.11**  
**Хүчирхийлгийн хохирогч хаана ханддаг вэ?**




Гэр бүлийнх нь гишүүд ямар ч дорвitoй арга хэмжээ авч чаддаггүй учраас үйлчилгээний байгууллагуудад ханддаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Доорхи зурагт харуулснаар гэр бүлийн гишүүдийн 34% нь хохирогчийг өөрийг нь буруутгасан, 21% нь ямар ч арга хэмжээ аваагүй, эсвэл хүчирхийлэгчээс айдаг учраас хүчирхийлэгчийн талд орсон ба зөвхөн 22% нь сэтгэл санааны дэмжлэг үзүүлсэн байна.

Эмэгтэйн хамт ажиллагсад нь сэтгэл санааны хувьд дэмжлэг үзүүлдэг (75%), ба зарим тохиолдолд хүчирхийлэгчтэй уулзаж ярилцдаг (18%) байна.

График 1.12

Гэр бүлийн гишүүд болон хамтран ажиллагсдын тусламж, дэмжлэг



## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад 1998 оноос хойш хийгдсэн судалгаанд хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл, ахмад настнуудын эсрэг хүчирхийлэл, хүн худалдаалах, бэлгийн мөлжлэгийн асуудлыг хамруулжээ. Хүн амд суурилсан судалгаа болон үйлчилгээний тоо баримтаас харахад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хамрах хүрээ, байршил, хэлбэр, хохирогч эмэгтэйчүүд болон хүчирхийлэгч эрэгтэйчүүдийн талаарх мэдээлэл, хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн өртөг болон хүчирхийллийн шалтгааны талаарх олон нийтийн үзэл бодлыг хамруулан судалсан байна.

Хүн амд суурилсан хэд хэдэн (1998, 2005) судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад 3 эмэгтэй тутмын нэг нь, 4 эрэгтэй тутмын нэг нь хүчирхийлэлд өртдөг, хүүхдүүдийн тэн хагас нь, 4 ахмад настны нэг нь ямар нэг хүчирхийлэлд өртдөг байна. Гэвч өмнө хийгдсэн хүн амд суурилсан судалгаанд хугацааны хязгаарыг амьдралын турш хэмээн авч үзсэн нь жендерээс үүдэлтэй хүчирхийллийн динамик өөрчлөлтийг харуулж чадахгүй байна. Арван жилийн өмнөх хүчирхийллийн илрэх хэлбэр, шалтгаан, нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс нь одоогийнхоос эрс ялгаатай байх нь мэдээж юм.

Судалгааны арга зүйн хувьд өмнөх судалгаанд хүчирхийллийг авч үзэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэсэн үзэл баримтлалыг ашиглан дүн шинжилгээ хийсэн байна. Энэ үзэл баримтлал нь эмэгтэйчүүд, хүүхдийг хохирогч, эрэгтэйчүүдийг хүчирхийлэгч мэтээр хараадуулдаг. Иймээс судалгаанд ихэвчлэн хохирогч эмэгтэйн үзэл бодлыг тусгадгаас биш жендерээс үүдэлтэй хүчирхийллийн суурь шалтгааныг тусгадаггүй. Хэрэв эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл жендерээс үүдэлтэй бол жендерийн дүн шинжилгээ хийхгүйгээр энэхүү хүчирхийллийг тайлбарлах боломжгүй юм.

Судалгаанд хүйсээр ангилсан тоо баримт, жендерийн дүн шинжилгээ нийтлэг дутагдж байна. Ялангуяа хүүхэд болон ахмад настнуудын талаар мэдээллийг хүйсээр огт ялгаж үздэггүй. Хүйсээр ялангуяа дүн шинжилгээ хийгээгүйгээс гадна зөвхөн хохирогч бүлгийн эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настнууд хэмээн ангилсан байна. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр, шалтгаан нь өөр хоорондоо эрс ялгаатай, тэдний хүчирхийлэлд өртөх байдал, хариу үйлдэл, сэтгэл зүйн онцлог өөр өөр байдаг учир энэ төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ ч өөр байх нь ойлгомжтой. Аливаа арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд зорилтот бүлгийн нас, хүйс болон бусад онцлог хэрэгцээг харгалzan үзэх шаардлагатай.

Өрхөд суурилсан түүвэр судалгаа гэр бүлийн хүчирхийлэл гэдэгт бэлгийн хамтрагчийн хоорондын, хүүхэд, ахмад настны эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн

## *Жендерээс цүдэлтэй хүчирхийлэл Монголд*

---

бусад гишүүдийн хоорондын хүчирхийллийг хамруулан нэг дор авч үзсэн байна. Ийм олон хэлбэрийг нэг нэр томъёонд хамруулан авч үзэх нь асуудлыг ойлгоход хүндрэлтэй болгож байгаа тул бэлгийн хамтрагчийн харилцаанд илэрч буй хүчирхийллийг гэр булийн бусад гишүүдийн хоорондын хүчирхийллээс тусад нь ангилан, хүйсээр ялгаатай авч үзэх шаардлагатай байгаа нь харагдлаа.

Ажлын байр, боловсролын байгууллага, олон нийтийн орчинд үйлдэгдэж буй хүчирхийллийн талаарх судалгаанд төлөөлөх чадвар бүхий түүвэр дутагдаж байгаагаас энэ төрлийн хүчирхийллийг тэр бүр баримтжуулж чадаагүй байна.

Гэр булийн доторх хүчирхийллийн асуудлыг судлахад “хэн нэгэн танихгүй хүн орж ирээд асуулт асуух арга” нь тэр бүр тохиромжтой бус байдаг. Өрхөд сууринсан түүвэр судалгаа нь ураг төрлийн хүчин гэх мэт гэр булийн доторхи эмзэг асуудлыг гаргаж чаддаггүй. Иймээс эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг хамруулсан оролцооны судалгааны аргыг олон улсын туршлагаас авч ашиглаж болох юм.

Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн судалгаанд сэтгэл санааны, бие махбодийн, бэлгийн, эдийн засгийн гэх мэт харилцан уялдаатай, давхардсан төрлүүдэд хуваан авч үзсэн байна. Гэтэл эдгээр төрлийн хүчирхийлэл нь дангаараа илрэх нь ховор байдаг. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид сэтгэл санааны дарамтанд давхар өртөх, нөхөртөө зодуулдаг эмэгтэйг нөхөр нь бэлгийн харилцаанд орохыг шаардах зэргээр хохирогч хүчирхийллийн эдгээр хэлбэрт давхар өртдөг.

“Хүчирхийлэл” гэдэг нь хүмүүс өөр өөрийнхөөр тайлбарладаг ойлголт юм. Түүнчлэн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэхдээ тодорхой зан байдал, үйл хөдлөлөөр биш урьдчилан ангилсан ангилалд хуваан авч үзсэн нь учир дутагдалтай байна. Судалгааны зарим асуултууд нь хэмжих гэж байгаа ойлголтоо хэмжиж чадахгүй байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлж байна.

Түүвэр судалгаанд санамсаргүй түүврийн аргыг ашигласан тохиолдолд судалгааны дүнг хүн амд ерөнхийлөн дүгнэх боломжтой. Урьд өмнө хийгдсэн судалгаанд түүвэрлэлтийн аргачлалын талаар дурьдаагүй байгаа нь арга зүйд дүгнэлт хийх боломжгүй болгож байв. Ихэнх судалгаа нь Улаанбаатар хотын дүүргүүдийг хамардаг тул бус нутаг, аймаг, сумын түвшин дэх ЖҮХ-ийн талаархи мэдээлэл хангальгүй байна.

Ихэнх судалгаанд хүчирхийллийн эсрэг авч буй арга хэмжээ, хохирогчид болон хүчирхийлэгчид үзүүлж буй үйлчилгээний үр дүнгийн талаар мэдээлэл хангальгүй байсан.

Эцэст нь, хүн амын өргөн түүврийг хамарсан үндэсний хэмжээний судалгааг 1998 оноос хойш хийгээгүй байгаа нь цаашид ийм судалгааг хийх, чингэхдээ динамик өөрчлөлтийг харуулсан аргачлал бий болгох хэрэгцээг харуулж байна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТӨД ЖЕНДЭРИЙГ  
ИНСТИТУЦИЛАХ ҮЙЛ ЯВЦ**

### Институцилал гэж юу вэ?

Энэ бүлэгт Лондонгийн Их сургуулийн Хөгжлийн төлөвлөлтийн нэгжийн захирал, доктор Карен Леви өөрийн боловсруулсан “институцилалын тор”<sup>21</sup> хэмээх загвараа танилцуулсан судалгааны өгүүллийг түүний зөвшөөрөлтэйгээр товчлон орчуулсныг танилцуулж байна. Бээжинд 1995 онд болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн бага хурлаас хойш 20 жилд хүн амын тал хувийг төлөөлдөг эмэгтэйчүүдийг хөгжлийн үйл ажиллагаанд оролцуулах талаар төдийлөн амжилт гараагүй байдалд дүгнэлт хийж, хөгжлийн үйл явцад оролцож байгаа засгийн газрууд болон бусад байгууллагын практикт тогтвортой өөрчлөлт, шинэ хандлагыг бий болгоход үзэл баримтлал, практик үйл ажиллагааг эргэн харах хэрэгцээ байгааг тэмдэглэжээ. Тэрээр *институцилал* гэдгийг “ниймээс тогтоосон хэм хэмжээгээр зохицуулагдах, тогтвортой үргэлжлэх, дахин давтагдах нийгмийн практик” хэмээн тодорхойлоод, *институци* гэдэгт нийгмийн бүх салбар (тер, хувийн хэвшил, нийгмийн), бүх түвшин дэх байгууллагуудын практик үйл ажиллагааг ойлгоно гэжээ.

Нийгмийн бусад харилцааны нэгэн адил жендерийн хандлагыг институцилахад асуудлын цөм нь эрх мэдлийн харилцаанд оршдог. Энэ асуудлыг судлах зорилгоор хөгжлийн бодлого, төлөвлөлт, практикт жендерийн хандлагыг институцилах шинжилгээний болон ажиллагааны хүрээг санал болгожээ. Түүний загварт жендерийг институцилахад шаардагдах нөхцлийг тодорхойлсон, тус бүр нь эрх мэдлийн харилцааг илэрхийлдэг 13 элементийг авч үзсэн байна. Эдгээр нь бүгд эрх мэдлийн харилцааг агуулж байдаг учраас элемент тус бүрийн дотор өөрчлөлт хийх хамтын үйл ажиллагаанд боломж, эсэргүүцэл аль аль нь тулгарч болно. Эрх мэдлийн харилцаа зөвхөн нүдэнд харагдахуйц бүтээгдэхүүн, практикаас гадна байгууллагын үр дүнд нөлөөлж, түүнийг тодорхойлж байдаг нүдэнд үл үзэгдэх үнэлэмж, хүсэл эрмэлзэлийг мөн илэрхийлдэг. Иймээс элемент бүрийн цаана тухайн элементтэй холбоотой “байгууллагын соёл” оршдог.

### Институцилалын тор

Нөхцөл байдалд шинжилгээ, оношилгоо хийх, түүний бүтцийг тодорхойлох, цаашлаад үнэлгээ хийсний эцэст өөрчлөлт шинэчлэл хийх, институцийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлоход эдгээр элемент чухал арга хэрэгсэл болдог. Эдгээр элемент нь зүгээр нэг хувьсагч биш, харин өөр хоорондоо тодорхой байдлаар холбоотой, харилцан хамааралтай, эцэст нь бие биеэ бэхжүүлэх шинж чанартай учраас “**институцилалын тор**” хэмээн нэрлэжээ. Энэ бүх элемент бүрдсэн, тэдгээр нь хоорондоо харилцан үйлчилсэн цагт л жендерийг бодлого төлөвлөлт, практик үйл ажиллагаанд тусгах ажил

<sup>21</sup> Levy, C. The Process of Institutionalizing Gender in Policy and Planning: The “Web” of Institutionalisation. Development Planning Unit, University College London. Working Paper No74. United Kingdom. 1999.

жинхэнэ утгаар хэрэгжих боломжтой, зөвхөн зарим хэсгийг нь бий болгосноор жендерийн тэгш эрх, тэгш байдлыг бий болгох боломжгүй юм. Торны гурван шинж чанар чухал ач холбогдолтой.

Нэгдүгээрт, элемент чухам ямар хэлбэртэй байх вэ гэдэг тухайн нөхцөл байдлаас шалтгаалдаг. Ийнхүү өөрчлөлт нь улс төр, нийгэм, эдийн засгийн өөр өөр нөхцөл байдал, мөн өөр өөр цаг хугацаанд явагдана гэсэн үг. Иймд өөр өөр нөхцөл байдалд жендерийг институцилах стратеги ялгаатай байх шаардлагатай.

Хоёрдугаарт, элемент бүр төрөл бүрийн бүлэг, иргэд, байгууллагын үйл ажиллагааны хүрээнд оршин тогтох учраас өөр өөр хэлбэртэй байна. Эдгээр бүлгүүд тус бүртээ жендерт хандах ялгаатай хандлагатай байдгаас үүдэн боломж, эсэргүүцэл, мөн түүнчлэн өөрчлөлт хийх нөхцөл харилцан адилгүй байна гэсэн үг.

Гуравдугаарт, тухайн хүн гүйцэтгэж буй үүрэг, албан тушаал, эрх мэдлийнхээ хүрээнд эдгээр элементийн зөвхөн заримд нь нөлөөлж чадна. Иймд торны бүх элементийг бий болгохын тулд төрөл бүрийн түвшинд зөрчилдөөнийг зохицуулах, хамтын ажиллагааг хөхиулэн дэмжих, хэлцэн зөвшилцэх зэргээр холбогдох бүх талуудын хамтын хүчин чармайлт шаардлагатай болно.

#### **Институцилалын торны элементүүд**

Жендерийн хандлагыг институцилахад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн туршлага, бодит байдлын талаарх тэдний ойлголт чухал байдаг. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн жендерийн сонирхол, үүрэг, эх үүсвэрийг захиран зарцуулж буй байдал, жендерийн хэрэгцээг ойлгоход зөвхөн тэдэнтэй хэдэн удаагийн ярилцлага хийх нь хангалтгүй юм. Тэдний сонирхол улс төрийн хүрээнд хамтын ажиллагааны түвшинд илрэх ёстой. Иймд торны дараагийн хоёр элементтэй холбогдож байна.

#### **Зураг 1**



Эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгмийн анги, нас, үндэсний цөөнх гэх мэт хүндрэлтэй асуудал тулгарах бөгөөд жендерийн сонирхлоо илэрхийлэхийн тулд хамтын зохион байгуулалтын ямар нэг хэлбэрт орох үйл явц шаардагдана. Энэ нь сонирхлын бүлгүүдэд нэгдэх, эсвэл шинээр бүрдүүлэх үйл явц байж болно. Эдгээр сонирхлын бүлгүүдийн шахалт жендерийг институцлиахад чухал юм.

Гэхдээ сонирхлын бүлгүүдийн шахалт дангаараа хангалтгүй бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүс албан ёсны улс төрийн тогтолцооны хүрээнд улс төрийн төлөөллөө сонгох, тэдэнтэй идэвхитэй харилцах чадвартай байх хэрэгтэй. Эс тэгвээс тэдний ашиг сонирхол албан ёсны улс төрийн гадна үлдэнэ.

Дээрх гурван элементийн гурвалжин биеэ биеэ бэхжүүлсэн холбоо тогтвортой өөрчлөлт бий болгоход чухал ач холбогдолтой. Жендерийн асуудлын талаар ойлголттой болох нь нэг хэрэг, харин энэхүү ойлголтыг хамтын хүчээр улс төрийн хүрээнд гаргаж тавих нь жендерийн хандлагыг институцлиах чухал алхам болно. Сонирхлын бүлгүүдийн зүгээс лобби хийх замаар улс төрийн төлөөллийн бүтцэд нөлөөлөх боломжтой. Улс төрийн төлөөлөл нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн туршлага, бодит байдалтай улс төрийн хариуцлага хүлээх замаар холбогддог.

Энэ гурвалжин улс төрийн хүрээний өөр нэг гурвалжинтай огтолцож байна. /Зураг 2-ыг хар./ Сонирхлын бүлгүүд болон улс төрийн төлөөллийн тогтолцооны лобби, эсвэл шууд үйл ажиллагааны үр дүнд жендерийн асуудал улс төрийн үүрэг амлалт болон хувирч болно.

## Зураг 2




Гэхдээ улс төрийн үүрэг амлалт дангаараа хангалтгүй бөгөөд энэ нь бодлогод тусгалаа олсон байх хэрэгтэй. Сүүлийн 20 жилийн туршлагаас харахад тус бодлогын хэлбэр нь чухал байна. Эмэгтэйчүүдийн, эсвэл жендерийн асуудлаар

тусгайлсан бодлогын баримт бичиг дангаараа байснаар бодлогын үндсэн чиглэлд жендерийг тусгахад төдийлөн нөлөөлж чадаагүй байна. Тэрээр ихэвчлэн үндэсний хөгжлийн төлөвлөгөөний нэг бүлэг (гол төлөв хамгийн сүүлчийн бүлэг нь байдаг) л болон үлддэг. Тусгайлсан бодлоготой байх үндэслэл бий боловч жендерийн хандлага бий болгоход хангалттай нөхцөл биш юм. Энд асуудлын гол нь хэлбэртээ бус, харин түүний агуулга, боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц юм. Иймд салбарын болон салбар дамнасан (байгаль орчин гэх мэт) бодлогуудад жендерийн бодлого хэрхэн туссан бэ гэдгийг асуух нь чухал.


Улс төрийн үүрэг амлалт нь бодлогыг дэмжсэн Эх үүсвэр болон хувирах шаардлагатай. Жендерийн асуудлыг тусгахад байгаа бодлого, төсвийг ашиглахаас гадна жендерийн мэдрэмжтэй ашиглах хэрэгтэй.

### Зураг 3




Эх үүсвэрийг хуваарилах болон жендерийг тусгах бодлогыг зохицуулах нь жендерийн асуудлаарх хариуцлагыг хаана, хэнд ногдуулахаас ихээхэн хамаардаг. Жендер, эсвэл эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан тусгай бүтэц бий болгосноор хүн амын тал хувийг эзэлдэг эмэгтэйчүүд бусад яамдын үйл ажиллагаанд хамааралгүй мэт үлдэж болдгийг олон улсын туршлага харуулжээ. Энд аливаа яамны үйл ажиллагаа нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг оролцуулдаг, эсвэл тэдний амьдралд нөлөөлдөг бол жендерийн асуудлыг тусгах үүргийг жендерийн, эсвэл эмэгтэйчүүдийн яам бус, харин тухайн яам хариуцна гэдгийг тодруулах нь чухал юм. Энэ нь тухайн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаагаа явуулах арга барил, хандлагад соёлын томоохон өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн үг юм.

#### Зураг 4




Гэхдээ үүрэг хариуцлагыг тодорхой болгож, жендерэйн мэдрэмжтэй бодлого боловсруулж хэрэгжүүлснээр асуудал дуусахгүй, жендержсэн заавар журмаар бататгах шаардлагатай болно. /Зураг 5-ыг харна уу./ Заавар журам гэдэг нь байгууллага, хувь хүмүүсийн дотоод болон тэдний хоорондын өдөр тутмын харилцааг зохицуулж байдаг дүрэм юм. Жишээлбэл байгууллагын ажил үүргийн хуваарь боловсруулах дүрэмд жендерэйн асуудлыг тусгах заалт байхгүй, харин жендерэйн гарын авлагад байх нь энэ асуудал дутуу орхигдсон гэсэн үг юм. Хичнээн сайн бодлого боловсруулж, үүрэг хариуцлагыг тодорхой болголоо ч гэсэн захиргааны дүрэм журамд тусгагдаагүй тохиолдолд бюрократ тогтолцоо жендерт чиглэсэн арга хэмжээг сулруулж болно.

#### Зураг 5




Эндээс бодлого хэрэгжүүлэх гол гурвалжин руу шилжиж байна. /Зураг 6-г харна уу./ Бодлого, заавар журам аль аль нь зохих хүний нөөцийг хөгжүүлэх элементгүйгээр үр нөлөөгүй байна. Энд хүний нөөцийг хөгжүүлэх гэдэгт нэг талаас байгууллагын эмэгтэй, эрэгтэй бүх ажилтныг жендерийн бодлого, төлөвлөлт хийх ур чадварт суралцуулах, нөгөө талаас байгууллагын ажилд авах, сургах, албан тушаалд дэвшүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд эрэгтэй, эмэгтэй ажиллагсдад аль алинд нь тэгш боломж олгох тухай ярьж байна гэж ойлгох хэрэгтэй. Жендерийн хандлагыг төлөвшүүлэх явц нь сургалтанд онцгой анхаарал өгсөөр ирсэн. Гэтэл сүүлийн 15 жилийн туршлага сургалт дангаараа практик үйл ажиллагаанд тогтвортой өөрчлөлт авчирдаггүй болохыг харуулсан. Эрх мэдлийн харилцаа үйлчилж байдаг учраас тэдний үйл ажиллагааг зохицуулж байдаг жендерийн бодлогын зохистой хүрээ, тодорхой заавар журам байхгүй тохиолдолд эрэгтэй, эмэгтэй албан хаагчид жендерийн сургалтанд хамрагдсан ч жендерийн мэдрэмжгүй, эсвэл эсэргүүцэл үзүүлсэн хэвээр байх бөгөөд сургалт ач холбогдоо алдах болно. Шинэ ур чадварыг хэрэглэхгүй бол мартагдана. Өөрөөр хэлбэл заавар журам, хүний нөөцийг хөгжүүлэх нь харилцан бие биес бататгадаг гэсэн үг.

### Зураг 6



Хүний нөөцийг хөгжүүлэх асуудал хоёр талтай болох талаар дээр өгүүлсэн. Энэ нь хүний нөөцийг хөгжүүлэх, ажиллагсдын практик үйл ажиллагаанд жендерийн мэдлэгийг нэвтрүүлэхэд чиглэсэн сургалт явуулахад тодорхой арга зүй чухал болохыг харуулж байна. /Зураг 7-г харна уу./ “Тодорхой” арга зүй гэдэг нь хөгжлийн практикт жендерийг тусгах тодорхой үндэслэл, жендерийн асуудлыг шийдвэрлэх арга хэрэгсэлтэй байх шаардлагатай гэсэн үг юм.


Зураг 7



Хүний нөөцийг хөгжүүлэх замаар зохих арга барил бий боллоо гэхэд үр дүн нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээг хангах бодит хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгалаа олохгүй бол хөгжлийн бүх үйл ажиллагаа үр дүнгүй байна гэсэн хэрэг болно. Энэ нь хэд хэдэн гурвалжингийн огтолцол дээр байгаа чухал элемент юм. /Зураг 7-г харна уу./ Нэгдүгээрт, жендерэйrin мэдрэмжтэй хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, удирдахад бодлогын тааламжтай орчин чухал. Хоёрдугаарт, хөтөлбөр, төслийг “хэрэгжүүлэх” гэдэг нь дээрээс доош утгыг илэрхийлэх боловч энэ үйл ажиллагаанд мэргэжлийн хүмүүсээс гадна үр шимийг хүртэг эмэгтэй, эрэгтэй хүмүүс мөн адил оролцох шаардлагатай. Хэрэв эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн туршлага, бодит байдлын талаарх тэдний ойлголт, ашиг сонирхол, хэрэгцээг тусгана гэвэл тэд хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, удирдах талаар шийдвэр гаргахад улс төрийн төлөөлөөрөө дамжуулан оролцох шаардлагатай болно. Гэхдээ энэ нь зөвхөн үндэсний түвшний үйл ажиллагааг хамарч байгаа биш орон нутгийн түвшинг мөн адил хамрах шаардлагатай.


Хөтөлбөр, төслийн үр нөлөөг сайжруулахын тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн туршлага, хувьсан өөрчлөгдөж байгаа бодит байдлыг судлах хэрэгтэй болно. Хэрэглээний судалгаа нь энд эдгээр элементийг бататгах холбоос болно. /Зураг 8-ыг харна уу./

**Зураг 8**



Эцэст нь хэрэглээний судалгаа бол бодит амьдралын нөхцөл байдлын талаар үнэлгээ хийхээс гадна жендерэйг бодлого, төлөвлөлтөд тусгах мэдлэг хуримтлуулахад хувь нэмрээ оруулдаг. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бодлого, төлөвлөлт жендерэйг хувьсагчаар тусгах онол бий болгоход тусалж, мөн арга зүй боловсруулах элементтэй харилцан хамааралтай байдаг. /Зураг 9./

**Зураг 9**




## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

**ЖЕНДЭРЭЭС ҮҮДЭЛТЭЙ ХҮЧИРХИЙЛЛИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ЦОГЦ  
ШИНЖИЛГЭЭ**

## Удиртгал

Монгол Улс дахь жендерээс үүдэлтэй хүчирхийллийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх, урьчилан сэргийлэх бодлого, арга хэмжээний үр нөлөөг өмнөх бүлэгт танилцуулсан институцшилалын торыг ашиглан хийсэн шинжилгээний дүнг энэ бүлэгт танилцуулж байна.

Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл нь гэр бүл, нийгэм, төрийн хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх мэдлийн тэгш бус харьцаанаас үүдэн гардаг бөгөөд төрөл бүрийн шалтгаанаар эмэгтэйчүүдийн эсрэг чиглэж, тэд илүүтэйгээр хохирол амсдаг хэмээн тодорхойлсон. Иймд ЖҮХ-ийг судлахад тус бүртээ эрх мэдлийн харилцааг илэрхийлдэг 13 элементийн хүрээнд шинжилгээ хийх нь бүрэн дүр зургийг харуулах боломж олгоно хэмээн судалгааны баг үзлээ. Эдгээр элемент хоорондоо хэрхэн уялдаж, харилцан үйлчилснээр “иргэн”, “бодлого” “зохион байгуулалт”, “үйлчилгээний” хүрээг бүрдүүлдэг болохыг Зураг 1-ээс харна уу.



Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тухай ойлголт Монголын нийгэмд бүрэн тогтоогүй, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондын хүйсийн ялгаатай байдал, эрх тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийллийг зөвхөн эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл гэдэг утгаар ойлгох нь нийтлэг байна. Гэтэл түүнд эмэгтэйчүүд, хүүхдээс гадна эрэгтэйчүүд өртдөг бөгөөд энэ төрлийн хүчирхийлэл гэр бүлийн хүрээнээс гадна ажлын байр, сургууль, гудамж талбай, олон нийтийн газар болон орон нутагт, цаашилд төрийн бодлого, үйл ажиллагааны үр дагаврын улмаас гардаг байна. Жендерээс үүдэлтэй хүчирхийллийг эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл хэмээн явцуу ойлгодгоос эмэгтэйчүүд-хохирогч, эрэгтэйчүүд-хүчирхийлэгч хэмээн ерөнхийлөх хандлага түгээмэл байна. Судлаачид, бодлого боловсруулагчдын дунд ч ийм явцуу ойлголт байдаг нь судалгааны арга зүй, бодлого, хөтөлбөр боловсруулах, үйлчилгээ хүргэхэд өрөөсгөл хандлага бий болоход нөлөөлж байна. Тус судалгааны нэг зорилго нь энэхүү ойлголтыг тодорхой болгоход оршсон болно. Нийгмийн ажлын хөгжлийн төвөөс 2008 оны сүүлээр хийсэн фокус бүлгийн ярилцлагын үр дүнд тулгуурлан ЖҮХ-ийн талаарх иргэдийн ойлголт, бодит нөхцөл байдлын талаарх мэдээллийг тус бүлгийн эхний хэсэгт авч үзэв.

Институцилалын торын нэг бүрэлдэхүүн хэсэг болох “үйлчилгээний” хүрээнд шинжилгээ хийхдээ Монгол Улсад ЖҮХ-ийн асуудлыг шийдвэрлэх талаар хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг тодорхойлохыг оролдсон ба ингэхдээ холбогдох байгууллагуудын төлөөлөл, мэргэжлийн хүмүүстэй хийсэн ярилцлагыг үндэслэв. Харин “бодлогын” болон “зохион байгуулалтын” хүрээнд дүн шинжилгээ хийхдээ хоёрдогч эх үүсвэрийн мэдээлэл, баримт бичигт дүн шинжилгээ хийх, шүүх, цагдаагийн болон нийгмийн ажилтнууд, бодлого боловсруулагчид болон олон нийтийн бүлгийн ярилцлагаар гарсан санал дүгнэлтэд үндэслэв. Мөн энэ асуудлыг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хөтөлбөр, төсөл, үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийн тоймыг хавсаргав (Хавсралт нэг: ЖҮХ-ийн асуудлаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, үйлчилгээний тойм).

## A. ИРГЭНИЙ ХҮРЭЭ

Иргэний хүрээ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдралд хүчирхийлэл хэрхэн илэрч байгаа, үүнийг иргэд хэрхэн тайлбарлаж, ойлгож байгаа болон энэхүү бодит байдал нь тэднийг төлөөлж буй улс төрийн бүтэц, сонирхлын булгийн нөлөөлөлд хэрхэн илэрч байгаа тухай асуудлыг хамарна.

### Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдралын туршлага, бодит байдлыг тайлбарлаж буй байдал

Эмэгтэй, эрэгтэй хүмүүс болон охид, хөвгүүд гэр бүл, ажлын байр, боловсролын байгууллага, олон нийтийн орчинд нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, улс төрийн хоорондоо хамааралтай хүчин зүйлсээс улбаалсан олон төрлийн хүчирхийлэлд өртдөг болох нь судалгаагаар харагдсан. Бүх насны эмэгтэйчүүд тэдний бэлгийн хамтрагч, эцэг эх, ах дүү, эсвэл үл таних хүмүүсийн зүгээс төрөл бүрийн хүчирхийлэлд өртөж сэтгэл санаа, бие мах бодь, бэлгийн хохирол амсдаг байна.

### Гэр булийн хүрээн дэх жендерээс үүдэлтэй хүчирхийлэл

Бэлгийн хамтрагчийн зүгээс үйлдэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь гэр булийн хүрээн дэх хамгийн нийтлэг хүчирхийлэл хэмээн эмэгтэйчүүд үзэж байна. Эмэгтэйчүүдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл нь ихэнхдээ тэдний эсрэг бие махбодийн, цаашлаад бэлгийн хүчирхийлэл болох нь элбэг байна.

Нөхөр нь эхнэрээ өөрийн өмч гэж үздэгээс ажил хийлгэхгүй байх, салсан, эсвэл тусдаа амьдардаг нөхөр нь ирж айлган сүрдүүлж, зоддог тохиолдлууд байна. Хадам эцэг эхийн зүгээс, ялангуяа хадам эхийн зүгээс хосуудын амьдралд оролцохдоо тэдний хэн хэнд нь сэтгэл зүйн дарамт учруулдгаа мэддэггүй. Эмэгтэйчүүд ихэвчлэн тэдний нөхөн үржихүйн эрх, хүүхэд асрах үүрэгтэй нь холбоотой дарамт хүчирхийлэлд өртдөг бол эрэгтэйчүүдийг мөнгө олж, гэр орноо тэжээх үүрэгтэй гэж үзэн дарамт учруулдаг. Тухайлбал эхнэр нь хүүхэд гаргах боломжгүй байх, эсвэл олон хүүхэд гаргах, эсвэл гэр орныхоо зарим ажил үүргийг нөхрөөрөө хийлгэнээс болж хэл амаар доромжуулдаг бол нөхөр нь ажил олж чадахгүй байх, байнгын орлогогүй байх зэргээс үүдэн доромжуулж, тэр ч бүү хэл хүчээр салгах тохиолдол байдгийг олон нийтийн бүлгүүд хэлж байв. Харин эмэгтэйчүүдийг бизнес хийх, орлого олох үйл ажиллагаа эрхлэхийг нь хадмын талынхан тэр бүр хүлээн зөвшөөрдөггүй, ойшоодоггүй байна.

Эмэгтэй хүнийг ар гэрээ асрах ёстой гэж үздэгээс гэрлээд тусдаа гарсан хойно нь ч гэр бүлээ асарч тэтгэх шаардлага тавьдаг. Иймээс эцэг эх, ах дүү нар нь ажилгүй тохиолдолд тухайн эмэгтэй өөрийн гэр бүлээс гадна, төрсөн гэр бүлээ асрах үүргийг хүлээдэг. Мөн ах эсвэл эрэгтэй дүү нь согтуу ирж мөнгө нэхэх, тэр ч бүү хэл зодох зэргээр гэр бүлийнх нь амгалан тайван байдлыг алдагдуулдаг. Ахмад

## *Жендерээс цүдэлтэй хүчирхийлэл Монголд*

---

настай эмэгтэйчүүдийн хувьд тэднийг гэр бүлийн эрэгтэй гишүүд нь тухайлбал, төрсөн хүү, хүргэн, ач хүү нь зодох, мөнгө нэхэх зэрэг дарамт учруулдаг.

Айлын хүү нь гал голомтоо залгамжилдаг, эмэгтэй хүнийг нөхөр нь авч явах ёстой гэж үздэгээс гэрлэсэн болон гэрлээгүй эмэгтэйг эрэгтэй дүү нь гэрээс нь хөөх тохиолдол байна.

Охидыг бага наснаас нь гэр орны ажил хийх ёстой гэж дарамтлан, хоол унд өгөхгүй байх тохиолдол байна. Зарим эцэг “хөвгүүд шиг том болоод өс санахгүй” гэж үзэн охиноо зоддог. Хойд эцэг, эхтэй охид зодуулах, гэрээсээ хөөгдөх нь элбэг гэж олон нийтийн бүлэг үзэж байв. Ялангуяа эцэг нь архи хэтрүүлэн хэрэглэдэг, хоорондоо байнга хэрэлддэг эцэг эхтэй хүүхдүүд, тэр тусмаа охид сэтгэл санааны дарамт хүчирхийлэлд өртөх нь элбэг байна.

Бүх насны охид, эмэгтэйчүүд гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртдөг. Гэр бүлийн хүрээн дэх хүчирхийлэгч нь ихэвчлэн тэдний ойр дотны хүмүүс (төрсөн эцэг, хойд эцэг, төрсөн ах, хадам ах, авга ах, г.м.) эсвэл гэр бүлийн гишүүдийн найз (хөрш, аавын, ахын найз, г.м) байна. Энэ төрлийн хүчирхийлэл ихэвчлэн хүчирхийлэгч нь согтуу үед гардаг.

Эрэгтэйчүүдийн хувьд хэдийгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл шиг нийтлэг биш ч гэсэн, ямар нэг хэмжээгээр гэр бүлийн хүрээнд хүчирхийлэлд өртдөг байна. Эрэгтэйчүүдийн эсрэг жендерээс үүдэлтэй хүчирхийллийн гол шалтгаан нь тэднийг гэрийн эзэн учраас гэр бүлээ тэжээх үүрэгтэй гэж үздэгтэй холбоотой байна. Иймээс тэднийг ажил олж чадахгүй байх, эхнэрээсээ бага орлого олох тохиолдолд эхнэрийн зүгээс болон хадам эцэг эхийн зүгээс хэл амаар доромжлох, гэрээс нь хөөх, ар гэр нь ядуу бол хайртай охиних нь эцэг эх хүчээр салгах зэргээр сэтгэл санааны дарамт учруулдаг. Харамсалтай нь эрэгчүүдийн сэтгэл санааны хямралаа “тайлах” арга нь архи уух байдгаас энэ нь тэднийг “хэл амаар доромжлуулах” бас нэг шалтгаан болдог.

Түүнчлэн гэр бүл салсан тохиолдолд хүүхдийг асран халамжлах үүргийг эмэгтэйчүүдийн талд шийдэж, эрэгтэйчүүдэд шударга бус ханддаг гэж эрэгтэйчүүд үзэж байна. Мөн эрэгтэйчүүд хохирогч байх тохиолдолд ч тэднийг хүчирхийлэгч гэж үзэх нь элбэг байдаг байна.

## *Боловсролын байгууллага, ажлын байран дахь хүчирхийлэл*

Охидыг гэр орны ажил хийх үүрэгтэй, “цэвэр ариун, гоё сайхан байх ёстой” гэсэн үзэл сургуулийн орчинд ч үргэлжилдэг. Багш нар охидыг, мөн охид бие биенээ гадаад үзэмж, хувцаслалтаар нь ялгаварлан гадуурхаж, доромжилдог. Охидын үзлэгт хүчээр оруулахыг тэднийг ялгаварлан гадуурхах, сэтгэл санаагаар дарамтлах үйлдэл хэмээн үзэж байв. Учир нь охидын үзлэгийн дараа үзлэгийн үр

дүнгийн талаар багш нар цуу яриа тараах, “ийм, тийм байсан” гэж доромжлох явдал гардаг. Өсвөр насын охид жирэмсэлсэн тохиолдолд сургуулийн нэр хүндийг гутаасан гэж үздэгээс сургуулиа орхихоос өөр аргагүй болдог.

Дунд сургуулийн багш нар жендерийн талаар хэт хуучинсаг үзэлтэй бөгөөд энэ үзлээ хүүхдэд тулгах замаар сургуульд аюултай орчин бий болгож байна. Багш нар охидыг анги цэвэрлэх ёстой гэж үздэгээс хичээлийн дараа үлдээж анги цэвэрлүүлдгээс охид харанхуй гудамжаар шөнө оройн цагаар явж гэртээ харих шаардлагатай болдог. Хөвгүүдийг хичээлийн цагаар ямар нэг юм зөвлгөх зэрэг биеийн хүчний ажилд туслуулдгаас хичээлээс хоцордог. Хичээлээс хоцорсон хөвгүүдийг хар ажил хийж амьдарч болно хэмээн багш нар тусалж дэмждэггүй. Иймээс хөвгүүд том болоод оюуны хөдөлмөр эрхлэх боломж нь багасдаг.

Хөдөө сумын дотуур байрны охид бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа нь энэ орчинд хүүхэд хамгааллыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Харин хөвгүүдийн хувьд багш нар нь зодож цохих, бусад хөвгүүд дээрэмдэх зэргээр бие махбодийн хүчирхийлэлд ихээхэн өртдөг. Ер нь “эрэгтэй хүүхдийг зодож хүмүүжүүлдэг” гэсэн ойлголт эрчүүдийн дунд нийтлэг байна. Хөвгүүд гэр бүлдээ, сургуулийн орчинд, хожим том хүн болсны дараа ч ажлын байранд болон гудамж талбайд бие махбодийн хүчирхийлэлд өртөх нь элбэг байна.

Цэрэг, цагдаа, хүчний байгууллагуудад “эрэгтэйчүүдийн соёл” давамгайлдгаас ажлын байрандаа зодуулж, дарамтуулдаг. Ялангуяа цагдаагийн ажилтны хувьд ажлын байрны аюулгүй байдал хангагдаагүй, янз бүрийн хүмүүс тэднийг ирж айлан сүрдүүлдэг. Гэтэл нийгэмд нийтлэг тархсан цагдаад хандах сөрөг үзлээс улбаатайгаар оройтсон, олон цаг ажилладаг, цалин багатай гэх зэргээр гэр бүлийн гишүүд нь хүртэл сэтгэл зүйн дарамт учруулдаг.

#### *Нийгмийн хүрээн дэх жендерээс үүдэлтэй хүчирхийлэл*

Нийгмийн хүрээнд бүх насын эмэгтэйчүүд бэлгийн дарамт, хүчирхийлэлд илт илүүтэйгээр өртдөг. Тухайлбал хүчингийн болон бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалсан хэргийн хохирогч ихэвчлэн эмэгтэйчүүд байдаг. Биеэ үнэлэх, баар цэнгээний газраар явах, орцны жижүүрийн ажил эрхлэх нь эмэгтэйчүүдийн бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Нийтийн газарт эрэгтэй хүмүүс ихэвчлэн бие махбодийн хүчирхийлэлд өртдөг. Эрэгтэйчүүдийн дунд бие биенээсээ архи, тамхины мөнгө нэхэх/дээрэмдэхтэй холбоотой хууль бус үйл ажиллагаа нийтлэг байдаг. Түүнчлэн эрэгтэйчүүд, тухайлбал шорон, сүм хийд гэх мэт газруудад бэлгийн хүчирхийлэлд өртдөг байна. Эрэгтэйчүүдийн зүгээс мөнгөтэй эмэгтэйг уруу татах, мөнгөөр өөртөө татахыг тэдний хүсэл зорилгын эсрэг хүчирхийлэл гэж олон нийтийн булгүүд үзэж байв.

Хөвгүүдийг “эмэгтэй хүүхэд шиг” гэсэн шалтгаанаар бөгснөөс нь базах зэргээр доромжилдог нь эмэгтэй хүүхдийг ингэж болно гэсэн үзлийг улам даамжуулж байгааг харуулж байна.

Эрэгтэйчүүдийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн зүгээс ихэвчлэн “хүчирхийлэгч” хэмээн үздэгээс хуулийн тогтолцоонд ч тэдний эрх ашгийг бүрэн хамгаалдаггүй гэж олон нийтийн бүлгүүд үзэж байлаа.

Лесби, бисекс эмэгтэйчүүд болон трансжендер хүмүүсийг нийгмийн зүгээс ялгаварлан гадуурхах байдал өргөн тархаж, үл хайхрах, гадуурхах, бие махбодийн болон бэлгийн дарамт шахалт үзүүлэх зэрэг олон хэлбэрээр илэрч байна. Энэхүү ялгаварлан гадуурхалт нь төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудад тухайлбал, цагдаа, хууль хяналтын байгууллага, эрүүл мэнд, боловсролын болон орон сууц, хэвлэл мэдээллийн салбарт түгээмэл байдаг<sup>22</sup>.

#### *Төрийн хүчирхийлэл*

Төрийн хүчирхийллийн хэлбэрт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдэд тулгарч буй хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр төрөөс авах эс үйлдлээс гадна төрийн нэрийн өмнөөс иргэдэд үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтнуудын ёс зүйгүй харилцаа, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах явдлыг хамруулан ойлгож байна.

Шүүх, цагдаагийн байгууллагын хууль бус үйл ажиллагаанаас ихэвчлэн эрэгтэйчүүд илүүтэйгээр хохирч байна. Тухайлбал шүүхийн байгууллагад эрэгтэйчүүдэд үйлдээгүй хэргийг хүчээр тулган хүлээлгэх практик байдгийг олон нийтийн бүлгүүд эрэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж буй явдал гэж үзэж байлаа. Энэ төрлийн хүчирхийлэлд залуу эрэгтэйчүүд ихэвчлэн өртдөг байна. Түүнчлэн төрийн цагдаа эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж бусдыг өвлийн хүйтэнд гудамжинд гавлаж орхих, зодох, мөнгийг нь дээрэмдэх зэргээр хүчирхийлж байгааг төрийн хүчирхийлэл хэмээн иргэд ойлгож байна.

---

<sup>22</sup> Лесби, бисекс эмэгтэйчүүд болон трансжендер хүмүүсийн байдал. ЭЯГБХУ Конвенцийн хорооны 42 дугаар Хуралдаанд зориулсан сүүдрийн илтгэл. 2008

## Сонирхлын бүлгийн шахалт

Хүчирхийлэлд өртөгчдийг төлөөлөн хамгийн идэвхтэй, ил тод үйл ажиллагаа явуулдаг сонирхлын бүлэг бол эмэгтэйчүүдийн болон хүний эрхийн төрийн бус байгууллагууд юм. Гэхдээ УБЕГ-т бүртгэлтэй ТББ-уудаас олон нийтийн сонирхлыг төлөөлдөг, тэр тусмаа хүчирхийлэлд өртөгсдийн эрх ашгийг хамгаалдаг ТББ харьцангуй цөөхөн байна. Энэ нь гэр бүл дэх хүчирхийллийг гэр бүлийн дотоод асуудал хэмээн үздэг, хүчирхийлэлтэй тэмцэхэд нийгмийн бүх гишүүдийн оролцоо чухал гэсэн ухамсар нийгмийн дунд бүрдээгүй байгаатай холбоотой байж болох юм.

ТББ-уудын дунд эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах, ялангуяа ЖҮХ-ийн зарим хэлбэрт өртөх эрсдэлтэй бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг цөөн хэдэн байгууллага байна. Тухайлбал Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төв, Хүний эрх хөгжил төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагыг дурьдаж болно. Монгол Улсад ЖҮХ-ийн асуудлыг ойлголт, шийдэх алхмуудыг өнөөгийн түвшинд хүргэхэд Засгийн газар болон бодлого боловсруулагчдад нөлөөлөх, дотоодын болон олон улсын хөрөнгийн эх үүсвэрийг дайчлахад эдгээр ТББ чухал хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Ялангуяа эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн дотоод асуудал бус нийгмийн асуудал болохыг нийгэмд хүлээн зөвшөөрүүлж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулж чадсан юм.

Гэвч эдгээр байгууллагын үйл ажиллагаа ихэвчлэн нийслэл Улаанбаатар хотод төвлөрч, цөөн хэдэн хандивлагч байгууллагын санхүүжилтээс хараат байна. Зөвхөн цөөн хэд нь (ХЭҮТ, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо) зарим орон нутагт салбартай ч боловсон хүчин, хөрөнгө мөнгөний дутагдалтай байдлаас шалтгаалан орон нутагт үйл ажиллагаагаа тэр бүр тогтмол явуулж чадахгүй, хамрах хүрээ нь хязгаарлагдмал байна. Иймээс орон нутгийн иргэд ТББ-уудыг тэдний ашиг сонирхлыг тэр бүр төлөөлж чаддаггүй гэж үзжээ.

Төрөөс бүхнийг нэхэн суудаг өмнөх тогтолцооны үеийн сэтгэлгээнээс улбаалан орон нутагт эрэгтэй, эмэгтэй хүмүүс тодорхой асуудлаар, тухайлбал хүчирхийллийн эсрэг эвсэн нэгдэж, хамтын үйл ажиллагаа явуулах соёл, туршлага дутагдаж байна. ЖҮХ-тэй тэмцэх ажилд иргэдийг зохион байгуулах, ойлголт мэдлэгийг нь нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь судалгаагаар харагдав.

Хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээнд эрэгтэйчүүдийн хандах хандлага, тэдний мэдлэг, туршлагыг тусгадаггүй, тэдний дуу хоолойг огт сонсдоггүй бөгөөд тэднийг зөвхөн хүчирхийлэгч хэмээн харах хандлага нийтлэг байна. Хүчирхийллийн асуудлаар эрэгтэйчүүдийн хүсэл сонирхлыг төлөөлөх бүтэц

огт байхгүй байна. Хэдийгээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг ихэвчлэн эрэгтэйчүүд үйлддэг ч эрэгтэй, эсвэл эмэгтэй хүний зүгээс үйлдэх ЖҮХ- эс эрэгтэйчүүд ч мөн адил хохирдог гэдгийг хүлээн зөвшөөрөх цаг болжээ.

Охид, хөвгүүдийн хувьд тэдний дуу хоолойг зарим байгууллага анхааран авч үздэг болсон ч эдгээр нь зөвхөн хүүхдийн цөөн хэдэн байгууллага байна<sup>23</sup>. Хүүхэд хамгааллын асуудал, тухайлбал охид, хөвгүүдийг дарамт, хүчирхийлэл, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахын төлөө ажилладаг байгууллагууд нь ихэвчлэн үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд байна. Тэдний зарим нь сонгож авсан цөөн орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг.

Хүүхдийн дуу хоолойг илэрхийлэх байгууллагууд, тухайлбал хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, “хүүхдийн элч”, хүүхдийн эрхийн ажилтан, хүүхдийн төлөө төвүүд хүүхдийн боловсрол, эрүүл мэнд гэх мэт нийтлэг асуудалд төвлөрдөг байсан бол сүүлийн үед хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдал, ялгаварлан гадуурхах явдлыг анхааран авч үзэх болсон.

Хүүхэд, эмэгтэйчүүдийн төлөөллийн бүтэц нь хоорондоо уялдаа муутай ажилладаг дутагдал байна. Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгч байгууллагууд нь зөвхөн насанд хүрсэн эмэгтэйд анхаарлаа хандуулдаг бол хүүхдийн байгууллагууд нь хүүхдийн асуудлыг авч үзэхдээ охид, хөвгүүд өөр хоорондоо ялгаатай гэдгийг анхааран авч үздэггүй.

Орон нутгийн түвшинд ажлын зарим эхлэлүүд байна. Тухайлбал, Дорнод аймагт хүүхэд, эмэгтэйчүүдийн байгууллага болон бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран Хүчирхийлэлтэй тэмцэх орон нутгийн сүлжээг 2008 онд байгуулжээ. Энэ сүлжээ нь орон нутагт хүчирхийллийн эсрэг явуулж буй үйл ажиллагааг удирдан чиглүүлэх цогц бодлого боловсруулах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

---

<sup>23</sup>Хүүхдийг ивээх сан, Зохистой хөгжил, жендер төв. “Хүүхдийг зодож шийтгэх талаар хүүхдийн үзэл бодол” тайлан, УБ, 2005; НУБХС, БСШУЯ, ХЭҮК. “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүчирхийлэл: УБ, 2007

### Улс төрийн төлөөллийн бүтэц

Монгол Улсад улс төрийн шийдвэр гаргах бүтцэд үндэсний болон орон нутгийн түвшний аль алинд эрэгтэйчүүд давамгайлсан байдаг ба эрэгтэйчүүдийн дунд жендерийн мэдрэмжтэй хөгжлийн бодлогын талаарх ойлголт тун сул байдаг. Иймээс улс төрийн шийдвэр гаргах бүтцэд эмэгтэйчүүдийн төлөөлөл бий болгохыг зорихын хажуугаар улс төрийн бүтэц дэх шийдвэр гаргагч эрэгтэйчүүдэд нөлөөлөх, тэдний ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх стратегийг давхар хэрэгжүүлэх нь зүйтэй.

ЖҮХ-ийн асуудлыг өнөөгийн түвшинд авч үзэж буй байдал нь ихэвчлэн эмэгтэйчүүдийн болон хүний эрхийн ТББ-уудын бодлогод нөлөөлөх, бодлого боловсруулагчдын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх уйгагүй үйл ажиллагааны үр дүн гэж хэлж болно. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр болсон нь ч мөн эдгээр байгууллагын олон жилийн нөлөөллийн ажлын үр дүн юм.

Орон нутгийн түвшинд үндэсний түвшнийх шиг ийм нөлөөллийн ажил мөн чухал ач холбогдолтой байна. Дээр дурьдсанчлан Дорнод аймагт хүчирхийллийн эсрэг орон нутгийн сүлжээ байгуулсан нь орон нутгийн улс төрийн төлөөллийг хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах эхлэл болж чадсан. Тус сүлжээ нь аймгаас УИХ-д сонгогдсон гишүүд, улс төрийн намын удирдлагууд, орон нутгийн ИТХ-ын гишүүдтэй лобби уулзалтуудыг зохион байгуулснаар ЖҮХ-ийн асуудлаарх тэдний ойлголтыг нэмэгдүүлж, улмаар ЖҮХ-тэй тэмцэхэд шаардлагатай бодлогын шинэчлэл хийх, хөрөнгө нөөцийг хуваарилахад нөлөөлөх боломж бий болгож байна. Энэхүү сүлжээний гишүүд болон Хэрлэн сумын ИТХ-ын гишүүдтэй ярилцахад хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох эрмэлзэлтэй байгаа нь харагдаж байсан. Мөн хүүхэд хамгааллын хамтарсан багийн туршлагыг дэмжиж орон нутгийн төсвөөс баг бүрт нийгмийн ажилтан ажиллуулах зардлыг хуваарилж өгчээ. Судалгааны үеэр орон нутгийн түвшинд хүчирхийллийн эсрэг хамтран ажиллаж буй үүнтэй ижил туршлага ХЭҮТ, ХЭХТ, Иргэний Альянс төвүүдийн өөр 6 аймагт хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд бий болсон байсан. Эдгээр нь орон нутгийн төлөөллийн оролцооны ач холбогдлыг тод илэрхийлж байна.

### Б. БОДЛОГЫН ХҮРЭЭ

#### Улс төрийн үүрэг амлалт

Монгол Улс өнөөгийн байдлаар олон улсын хүний эрхийн 50 орчим гэрээ конвенцид нэгдэн орсон. Үүнээс жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй холбоотой заримыг нь дурдвал: 1979 оны Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх

хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцид 1981 онд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид 2000 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2001 оны 182 дугаар конвенци, Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай нэмэлт протоколд 2002 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци, түүний нэмэлт протокол болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх” тухай протоколд 2008 онд тус тус нэгдэн орсон байна.

Монгол Улсын Засгийн газар олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсноороо тэдгээрийн үзэл баримтлал, заалтуудыг өөрийн орны хууль тогтоомж, бодлого хөтөлбөрт тусгах үүрэг хүлээдэг<sup>24</sup>. Гэвч энэ үүргээ биелүүлэхэд улс төрийн хүсэл эрмэлзэл дутагдалтай, цаасан дээрх амлалтаа бодитой арга хэмжээ болгох шаардлага байсаар байна. Засгийн газрын үүрэг амлалтыг бодитой болгоход тодорхой хууль, бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлээд зогсохгүй, шаардагдах эх үүсвэрийг гаргах шаардлагатай байна.

### **Бодлого, төлөвлөлт**

Монгол Улс бодлого, хөтөлбөр боловсруулах, бодлогын түвшний өөрчлөлт хийх талаар нэлээдгүй амжилт олсон билээ. Үүнд Жендерэйrin тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2002-2015), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2007-2015), Боловсролын хуульд суралцагчийн бие махбодид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэхийг хориглох тухай оруулсан нэмэлт өөрчлөлт (2006), Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг (2005-2015) дурьдаж болно.

Дээрх амжилтын зэрэгцээ эмэгтэйчүүд, хүүхдийг жендерээс үүдэлтэй хүчирхийлэлд өртөхөөс хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйн хангалттай орчин бүрдээгүй гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хохирогчдын аюулгүй байдлыг хангах болон хүчирхийлэл үйлдэгчидтэй хариуцлага тооцох боломжийг тэр бүр хангахгүй байна гэсэн шүүмжлэл байна<sup>25</sup>.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооноос садар самуун, бэлгийн мөлжлөг болон хүүхэд, эмэгтэйчүүдийг хил дамнуулан худалдаалахтай тэмцэх чиглэлээр үндэсний

<sup>24</sup> Олон улсын эрх зүйн баримт бичгийн талаарх Венийн конвенци (1969), 26 ба 27 дугаар зүйл

<sup>25</sup> Улс орны жендерэйин үнэлгээ: Монгол Улс, АХБ, ДБ, 2005

хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүчирхийлэл үйлдэгчдийг эрэн сурвалжлах, зохих шийтгэл оноох, гэрчийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүн худалдаалах үйл ажиллагааны золиос болсон эмэгтэйчүүдэд нөхөн сэргээх болон нийгмийн үйл ажиллагаанд эргэн орох боломжийг хангах механизм бүрдүүлэхийн чухлыг зөвлөсөн<sup>26</sup>. Тус хорооноос гэрлэлтийн хүчинг гэмт хэрэгт тооцох шаардлагатай хэмээн зөвлөмж болгосон. Түүнчлэн Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөлд орсон боловч хүлээгдээд байгаа бэлгийн дарамт шахалт үзүүлэх үйлдлийг хориглохыг уриалсан.

Гэр бүлийн тухай хууль (1999), Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль (1996, 2003 онд өөрчлөн шинэчилсэн), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004), Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль (1997) болон Эрүүгийн хууль (2002, 2008 онд өөрчлөн шинэчилсэн)<sup>27</sup> зэрэгт хүүхэд, ялангуяа охидыг хүчирхийлэл, дарамт шахалтаас хамгаалах чиглэлээр зарим нэг заалт орсон боловч хангалттай бус байна. Монгол Улсын хууль тогтоомж, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх олон улсын гэрээнд хэрхэн нийцэж байгаа байдалд хийсэн үнэлгээгээр<sup>28</sup> хүүхдийг дарамт шахалт, хүчирхийлэл, үл хайрхах, эдийн засаг болон бэлгийн мөлжлэг зэргээс хамгаалах хууль эрх зүйн хамгаалалт хангалтгүй байна хэмээн үзжээ. Жишээ нь садар самуун үзүүлбэрт ашиглах зорилгоор хүүхдийг элсүүлэх, санал болгох болон мөлжих зэрэг гэмт хэргийг шийдэх хуулийн заалт хангалтгүй байна.

### Эх үүсвэр

Улс төрийн үүрэг амлалтын биелэлтийг аливаа бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг бий болгосон байдлаар хэмжиж болно. Гэр бүлийн хүчирхийлэл, хүний наймаа болон бэлгийн мөлжлөгтэй тэмцэх тухай эрх зүйн баримт бичиг, үндэсний хөтөлбөртэй байснаар хүссэн үр дүнд шууд хүрчихнэ гэсэн үг биш юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэд, мэргэжлийн хүмүүс, төрийн албан хаагчид бүгд сэтгэл хангалуун биш байна. Хуулийн болон хөтөлбөрийн хэрэгжилт ийнхүү сул байгаа нь шаардлагатай санхүүгийн нөөц хангалттай биш байгаатай холбоотой юм.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд туслах зорилготой хамгаалах байр ажиллуулахад зориулан ХЭҮТ-д бага хэмжээний санхүүжилтийг 2002 оноос эхлэн

<sup>26</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хорооноос ирүүлсэн зөвлөмж, 2008 оны 11 сар.

<sup>27</sup> <http://www.endcorporalpunishment.org/pages/progress/reports/mongolia.html>

<sup>28</sup> Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБХС, ДБ-ы хамтарсан судалгааны төслийн хүрээнд хийгдсэн “Хүүхдийн ажлыг ойлгох нь” сэдэвт хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх олон улсын конвенцид Монгол орны хууль журам нийцэж байгаа байдалд хийсэн үнэлгээний тайлан., 2009, Монгол Улс

олгох болсон<sup>29</sup>. Түүнчлэн Төв аймгийн хамгаалах байрыг ажиллуулахад шаардлагатай зардлын зарим хэсгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргадаг. Эдгээр нь төр болон орон нутгийн засаг захираганаас хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа цөөн тохиолдол бөгөөд ерөнхийдөө төрийн зүгээс жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг бага байна.

Шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгадаггүй нь зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр бус, хандивлагчидтай хамтран санхүүжүүлдэг цөөхөн хэдэн хөтөлбөрөөс (Тогтвортой амьжиргаа, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөтөлбөрүүд зэрэг) бусад бараг бүх хөтөлбөрийн хувьд түгээмэл байдаг бэрхшээл юм. Энэ нь санхүүгийн эх үүсвэр дутагдалтайгаас биш, харин зохицуулалтын механизм дутагдалтай байгаатай холбоотой юм. Хөтөлбөрт сууриссан төсвийн төлөвлөлтийн аргачлалыг нэвтрүүлснээр байдлыг сайжруулах боломжтой<sup>30</sup>.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дагуу Жендерэйн тэгш байдлын хороо, Сангийн яам жил бүрийн улсын төсөвт тусгах замаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийг шийдвэрлэх үүрэгтэй боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт суулган УИХ-аар батлуулахаар өргөн барьсан тохиолдол нэг ч байхгүй байна<sup>31</sup>.

Нийгмийн халамжийн тухай хуулийн төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх, ялангуяа хамт олонд түшиглэсэн үйлчилгээг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэх заалт нь ХЭҮТ-д хуваарилдаг бага хэмжээний хөрөнгийг эс тооцвол амьдралд хэрэгжихгүй байна. Тиймээс Засгийн газар шаардлагатай зарим төрлийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй<sup>32</sup>.

Цагдаагийн байгууллага, прокурор болон шүүхийн байгууллагуудын төсөвт ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд зориулсан тусгай төсөв байдаггүй<sup>33</sup>.

<sup>29</sup> 2002 оноос хойш жил бүр 3 сая төгрөг, 2008 онд 16 сая төгрөг хуваарилах шийдвэр гарсан (Засгийн газрын 2008 оны 2 сарын 23-ны өдрийн #152 тогтоол).

<sup>30</sup> Яамдын ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлага, 2009 оны 2 сар

<sup>31</sup> ХЗДХЯ: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ тайлан (2008 оны 12 сар)

<sup>32</sup> Английн Хүүхдийг ивээх сангаас 2005 онд НХХЯ-д нийгмийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлаар энгийн, ойлгомжтой, шаардлагатай бүх хүснэгт, хэлбэрийг багтаасан удирдамжийг боловсруулж өгсөн. НХХЯ-ны зүгээс энэ чиглэлээр арга хэмжээ аваагүй байна.

<sup>33</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл: Монгол Улсын Засгийн газар анхаарал тавьж байна уу, Баримтын хуудас 2006, Нээлттэй нийгэм хүрээлэн

## В. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭ

Эх үүсвэрийг хуваарилах, үр нөлөөтэй бодлого хэрэгжүүлэх нь жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг, хариуцлагыг Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагууд, ажилтнуудын хооронд хэрхэн хуваарилснаас ихээхэн хамаарна.

### Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Засгийн газар “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг 2007 онд батлах үндэслэлдээ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоо талаар гол үүрэг хариуцлага хүлээх төрийн байгууллагуудын тусгай үүрэг хариуцлагыг тодорхой заасан хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, механизм хангалттай бүрдээгүй, энэ төрлийн хүчирхийлэл бий болж байгаа шалтгаан, нөхцлийг арилгах арга зүй, чадавхи дутмаг, үндэсний бусад төрөлжсөн хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгүүдтэй уялдуулах нэгдмэл удирдлага, зохицуулалт бүрдээгүйгээс салбар хоорондын ажлын уялдаа холбоо хангагдаж чадахгүй байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих асуудал чухлаар тавигдаж байна” гээд хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, хяналт тавих үүргийг Жендерэйин тэгш байдлын үндэсний хороонд, хариуцсан чиглэл тус бүрийнхээ арга хэмжээг эрхлэх асуудлыг хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг даргад даалгажээ<sup>34</sup>.

Жендерэйин тэгш байдлын үндэсний хорооноос тус хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийг хуваарилахад оролцсон зэргээр энэхүү зохицуулалтын үүргээ гүйцэтгэж байгаа талаарх баримт, аймаг, сумын Засаг дарга нарын түвшинд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар явуулсан үйл ажиллагааг нэгтгэн дүгнэсэн тайлан, мэдээ байхгүй байна.

Гэхдээ энэ чиглэлээр зөвхөн 2009 он гэхэд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай”, “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд ёртсөн хохирогчдод үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээ байгуулах тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журмыг батлах тухай” асуудлаар ХЗДХЯ, ЭМЯ, НХХЯ-ны хамтарсан

---

<sup>34</sup> Засгийн газрын 2007 оны 9 сарын 12-ны өдрийн тогтоол #225.

шийдвэр гарсан нь жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь салбар дамнасан асуудал болохыг хүлээн зөвшөөрч байгаагийн нэг тод илрэл болж байна.

Жендерийн тэгш байдлын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд яамд, орон нутгийн захиргаадад жендерийн асуудал хариуцсан орон тооны бус ажилтнууд бий болсон. Гэвч эдгээр ажилтан жендерийн асуудлаарх уулзалт, сургалтад яам, байгууллагаа төлөөлөн оролцооос илүү онцын үүрэг гүйцэтгэж чадахгүй байгаа бөгөөд тэдний үүрэг, хариуцлага сүүлийн жилүүдэд улам бүдгэрсээр байна. Жендерийн асуудлыг илүү бодлогын буюу дээд түвшний албан тушаалтанд, тухайлбал наад зах нь газар, хэлтсийн дарга нарт хариуцуулах нь зүйтэй юм. Эрх мэдэл багатай гүйцэтгэх албан тушаалтанд хариуцуулснаар жендерийн асуудлыг яамд, орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд тусган уялдуулах үр дүн бага гарч байна.

### Заавар журам

Жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагааны талаар тусгайлан заавар, дүрэм журам байдаггүй нь энэ чиглэлээр манай орны хувьд маш бага ахиц дэвшил гаргасантай холбоотой байж болох юм.

Нийгэм даяараа, байгууллага хамт олноороо хүчирхийллийг үл тэвчих соёлыг бий болгох нь хамгаас чухал. Байгууллагын хүрээнд хүчирхийллийн эсрэг, ялангуяа бэлгийн дарамт, хүүхэд хамгааллын чиглэлээр бодлоготой байх нь аливаа байгууллагын хувьд зайлшгүй шаардлагатай соёлыг бий болгох эхлэл болно. Жишээлбэл, Боловсролын яамны зүгээс багш, ажилтнуудын ёс зүйн дүрмийг сайтар мөрдүүлэх, түүнчлэн сургуулийн дотоод журмыг ажиллагсад болон суралцагчдад хамааралтай болгон хэрэгжүүлэх ажлыг илүү үр дүнтэй явуулснаар боловсролын байгууллагын хүрээнд жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. Эдгээр механизм, дүрэм журам нь сургуулийн орчин нь хүчирхийлэл, жендерийн ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамт шахалт, болон бэлгийн мөлжлөгөөс ангид байх ёстой гэдгийг маш тодорхой харуулсан, ойлгомжтой мэдээллийг агуулсан байх шаардлагатай юм<sup>35</sup>. Ёс зүйн дүрэмтэй байх нь мэдээж хангалттай биш, харин энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдлуудыг мэдээлэх ойлгомжтой, тодорхой механизм байхын зэрэгцээ түүний мөрөөр хариу арга хэмжээг хэн, хэрхэн авах талаар тодорхой заасан байх шаардлагатай. Дээрх хэлбэрийн урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээ авахгүй нөхцөлд оюутан сурагчид ялангуяа дотуур байранд амьдарч байгаа охид, их дээд

<sup>35</sup> Сумын нийгмийн ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлага, 2008 оны 11 сар

сургууль, коллежид сурч байгаа эмэгтэй оюутнууд жендерээс үүдэлтэй хүчирхийллийн хохирогч болох тохиолдол их байсаар байна.

Цагдаа, нийгмийн ажилтнууд болон шүүгч зэрэг мэргэжлийн хүмүүстэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас харахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэг шалтгаан нь хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль хяналтын болон үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын ажилтнуудын дагаж мөрдөх, ашиглах журам, заавар байхгүй байгаа явдал юм. Ялангуяа хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах тухай шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд хэн хяналт тавих,<sup>36</sup> гэр бүлийн хүчирхийллийн байдалд үнэлгээ хийж, эрсдэлийн зэргийг тодорхойлоход цагдаагийн болон нийгмийн ажилтнуудын үүрэг хариуцлага юу болох; түүнчлэн юуг яж хийх; архи уугаагүй, эрүүл үедээ хүчирхийлэл үйлдэгчийн хувьд болон амралтын өдрүүдээр эрх хязгаарлах тухай шүүхийн шийдвэрүүдийг хэрхэн гаргуулах<sup>37</sup> гэх зэрэг олон асуудлаар тодорхой зааварчилгаа удирдамж байдаггүй байна.

Хэдий явц удаан байгаа ч дүрэм журмыг тодорхой болгох чиглэлээр зарим ахиц гарч байна. Гэр бүлийн хүчирхийллийг үндэсний хэмжээний эрүүгийн гэмт хэргийн бүртгэл мэдээллийн тогтолцоонд оруулсан нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн үндэсний хэмжээний мэдээлэлтэй болох эхлэлийг тавьсан<sup>38</sup>. Үндэсний хэмжээнд 2008 оны 1-11 дүгээр сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 272 гэмт хэрэг бүртгэгдсэн; гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч 220 хүн болсон байна. Хэдийгээр эдгээр тоон мэдээллэл үнэн зөв эсэх нь тодорхой биш ч гэр бүлийн хүчирхийллийн холбогдолтой тоон мэдээллийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах нэг алхам болсон.

Түүнчлэн, 2008 оны байдлаар цагдаагийн байгууллагын захиргааны зэрчлийн арга хэмжээ авсан тухай мэдээллийн маягт шинэчлэгдэж<sup>39</sup>, энэ маягтанд гэр бүлийн хүчирхийллийн тохиолдлын дуудлага, гомдол саналын талаар зарим үзүүлэлтүүдийг нэмж оруулсан. 2008 онд үндэсний хэмжээнд 9073 дуудлага, гомдол санал хүлээн авсан бөгөөд үүний 9057 нь хуулийн дагуу “шийдвэрлэгдсэн” гэсэн байна.

<sup>36</sup> Цагдаагийн ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлага, 2009 оны 2 сар, шүүгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага, 2009 оны 3 сар

<sup>37</sup> Дорнод аймгийн цагдаагийн ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлага (2008 оны 11 сар), Улаанбаатар (2008 оны 3 сар)

<sup>38</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2007 оны #4 тушаал

<sup>39</sup> Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны #4 тушаал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас 2009 онд авсан чухал арга хэмжээ нь НХХЯ, ХЗДХЯ-ны хамтарсан шийдвэрээр<sup>40</sup> гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээний маягт, аюулын түвшингийн зэргийг тодорхойлох заавар, цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж эрх хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах загвар, хүчирхийлэл үйлдэгчийн мэдээний маягт, гэр бүлийн хохирогчийн бүртгэлийн маягтыг батлан гаргасан явдал юм. Тус шийдвэрт мөн цагдаагийн болон нийгмийн ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод дээрх ажил үүргүүдийг нэмж тусгахыг холбогдох байгууллагуудад даалгажээ. Үүний зэрэгцээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн талаар судалгаа, төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаар тайлан мэдээг багтаасан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээллийн сан бий болгох үүргийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт даалгажээ.

Хорооны болон сургуулийн нийгмийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг боловсруулах ажил 2005 оноос хойш хүлээгдэж байгаа. Хамгийн сүүлийн хувилбар нь<sup>41</sup> НХХЯ болон БСШУЯ-ны хамтарсан тушаалаар батлагдах шатандаа байгаа бөгөөд энэхүү хувилбар нь нийгмийн хамгаалал, халамж, боловсролын салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын үүрэг, хариуцлагыг нилээн тодорхой болгохоор боловсруулагдсан байна. Ялангуяа сургуулийн нийгмийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь болон ажлын зааварчилгааны хувилбарт нь сургуульд түшиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг хэрхэн явуулах чиглэлээр тодорхой заавар зөвлөмжийг багтаасан байгаа нь сайшаалтай. Энэхүү зааварчилгааг амьдралд амжилттай хэрэгжүүлснээр одоогийн нийгмийн ажлын үйлчилгээг хүүхдүүд, охид, хөвгүүдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамт шахалт, ялгаварлан гадуурхал, үл хайхрах зэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх болон хамгаалах, боловсролын байгууллагад аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлийн ажлыг илүү мэргэжлийн түвшинд хүргэхэд ахиц дэвшил болох нь дамжиггүй. Сум, хорооны нийгмийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг боловсруулахдаа сургуулийн нийгмийн ажилтнуудад зориулсан зааварчилгааны адилаар тэдний үүрэг хариуцлага, түүнийг практикт хэрхэн хэрэгжүүлэх талаар зааварчилгаа, зөвлөмжөөр хангах нь илүү үр дүнтэй юм.

---

<sup>40</sup>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай, 2009 оны 9 сарын 21, #128/188.

<sup>41</sup> Сургуулийн нийгмийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийн төсөл, 2009 оны 3 сар  
Сум, хорооны нийгмийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийн төсөл, 2009 оны 3 сар

### Хүний нөөцийг хөгжүүлэх

Сайн боловсруулсан дүрэм журамтай байх нь чухал боловч түүнийг хэрэгжүүлэхийн тулд хүний нөөцийг хөгжүүлэх шаардлагатай алхмыг хийхгүйгээр төдийлэн үр дүнд хүрч чадахгүй. Хүчирхийлэл үйлдэгчид болон хүчирхийллийн хохирогчдод шууд үйлчилгээ үзүүлдэг цагдаагийн болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч, өмгөөлөгч зэрэг гол гол мэргэжлийн ажилтнуудын мэдлэг, ур чадварын түвшинээс жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүн ихээхэн хамаарна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар ажилладаг мэргэжилтнүүдийн дунд мэдлэг туршлага дутмаг байгаа тухай олон судалгааны тайланд дурдсан байна. ХЭҮТ-ийн судалгааны (2007) тайланд үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийн ихэнх нь (73.3%) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд мэдлэг чадварын хувьд хангалттай биш байна гэж хариулсан байна. Үүний шалтгаан нь тэдэнд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай заавар зөвлөмж дутмаг, үйлчилгээ үзүүлэх болон зохицуулах тодорхой механизм байхгүйтэй холбоотой юм.

Мэргэжилтнүүд болон иргэдийн төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас мэргэжилтнүүд, ялангуяа нийгмийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар үйлчилгээ үзүүлэх шаардлагатай түвшинд байхгүй байгаа нь харагдсан. Энэ нь хэд хэдэн хүчин зүйлээс, тухайлбал 1) нийгмийн хамгаалал, халамжийн салбарт ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын зөвхөн 6.8% нь нийгмийн ажилтны мэргэжлээр бэлтгэгдсэн; 2) нийгмийн ажилтнуудыг дахин сургалтанд хамруулах, хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар мэргэшүүлэх чиглэлээр бэлтгэх талаар Засгийн газраас авч буй системтэй арга хэмжээ байхгүй байгаа; 3) их дээд сургуулийн сургалт нь нийгмийн ажлын чиглэлээр сурч байгаа оюутнуудад төгссөнийхөө дараа хүчирхийллийн асуудлаар үр дүнтэй ажиллах мэдлэг, ур чадварыг хангалттай эзэмшүүлдэггүй<sup>42</sup> зэрэг болно. Нийгмийн ажлын боловсролын магадлан итгэмжлэх систем байхгүйгээс мэргэжлийн нийгмийн ажилтан бэлтгэх сургалтын чанарыг баталгаажуулах боломжгүй байна.

Судалгаанд оролцсон мэргэжилтнүүд хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр мэдлэгийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагууд чухал хувь нэмэр оруулдаг болохыг онцлон тэмдэглэв. ХЭҮТ, ХТЭТ, ХЭХТ зэрэг ТББ-аас зохион байгуулдаг сургалтууд нь ЖҮХ-ийн талаар мэдлэг мэдээлэл олгоход ихээхэн үр дүнтэй байдаг ба цаашид ч эрэлт хэрэгцээ ихтэй байсаар байна. Хүүхдийн болон бусад асуудлаар ажилладаг олон улсын

<sup>42</sup> Сумын болон сургуулийн нийгмийн ажилтнуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлага, 2008 оны 11 сар.

байгууллагуудын (НУБХАС, Швейцарийн хөгжлийн агентлаг, Английн хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн болон АДРА г.м.) зохион байгуулсан сургалтууд болон чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа нь үр дүнтэй болсныг тэмдэглэх нь зүйтэй юм. ТББ-ын болон олон улсын байгууллагын төсөлд хамрагдсан ажилтнууд сум, хорооны ажилтнуудтай харьцуулахад мэргэжлийн хувьд өсч хөгжих боломж илүүтэй байдгийг харуулж байна. Хамтын ажиллагааны томоохон сүлжээний гишүүн (үндэсний болон олон улсын түвшний) байх нь энэ салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд мэргэжлийн хувьд өсч хөгжих томоохон боломж олгодог.

Ажилтнуудыг хөгжүүлэхэд харилцан хамааралтай дараах хоёр асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Нэгдүгээрт, ажилтнуудыг мэргэжлийн хувьд хөгжүүлэх чиглэлээр хийгдэж байгаа ажиллагаа, сургалтын хамрах хүрээ бодит хэрэгцээтэй харьцуулахад туйлын хангалтгүй; хоёрдугаарт, хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа хөгжлийн шинэ шатанд гарсан учраас энэхүү шинэ шаардлагад нийцүүлэн ажилтнуудыг бэлтгэх, сургалтын агуулга, хэлбэрийг өөрчлөх шаардлага байна. Энэ асуудлыг холбогдох салбарт олон жил ажилласан, сургалтанд хамрагдсан ажилтнуудын зүгээс хөндөж байсан. Тэд ТББ-аас зохион байгуулж байгаа сургалт нь зарим тохиолдолд агуулгын хувьд шинэлэг мэдээллээр дутмаг, өмнөхөө давтсан байдалтай байгааг тэмдэглэв. Энэ нь ажилтнуудыг хөгжүүлэх нэг нь негөө дээрээ сууриссан, системтэй, багц сургалт үгүйлэгдэж байгаа (ихэнх нь санхүүгийн хязгаарлагдмал байдалтай холбоотой), болон одоогийн явагдаж буй ганц нэг удаагийн сургалтаар хязгаарлагдаж байгааг илтгэж байна.

Түүнчлэн, хүчирхийлэл үйлдэгч эрэгтэйчүүдтэй хэрхэн ажиллаар чадвар эзэмшүүлэх сургалтууд дутагдалтай байгаа бөгөөд энэ чиглэлээр илүү анхаарах шаардлагатай байна.

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын дунд хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийг хүмүүсийн хувийн асуудал хэмээн үзэх хандлага хэвээр байсаар байгаа, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэх ажил хангалтгүй байгаа нь ЖҮХ-ийн асуудлаар холбогдох ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Ийм хэрэгцээ шаардлага бодлого боловсруулагчид, эмч, сувилагч зэрэг мэргэжлийн ажилтнуудын хувьд ч байсаар байна. ЖҮХ-ийн асуудлаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг илүү өргөн хүрээтэй хэрэгжүүлснээр зохицуулалтыг сайжруулах боломжтой болно.

## Г. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

Энэ хүрээнд хүчирхийллийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөр, төслийдийг төлөвлөх/боловсруулах болон тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой үйл явцыг авч үзлээ. Түүнчлэн хүчирхийллийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний гол үндэс болж байгаа суурь онолууд, арга зүй, судалгааны талаар авч үзэх болно.

### Үйлчилгээг хүргэх нь

Засгийн газрын болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн захиргаад, олон улсын байгууллагуудаас хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх чиглэлээр авч байгаа арга хэмжээ дараах зорилтот бүлгүүдэд чиглэгдэж байна:

- Хүн амын тодорхой бүлгүүд (эцэг эхчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд, охид, өсвөр үеийнхэн г.м.)
- Эрсдэл бүхий тодорхой бүлгүүд (ажил хөдөлмөр эрхэлж байгаа, хараа хяналтгүй хүүхэд, бэлгийн мөлжлөг болон хүний наймааны гэмт хэргийн хохирогч охид, эмэгтэйчүүд г.м.)
- Хүчирхийллийн асуудлаар ажиллаж байгаа мэргэжлийн албан хаагчид (нийгийн ажилтнууд, сэтгэл зүйч, багш, эмч, хил, гаалийн ажилтнууд, элчин сайдын яамдын ажилтнууд, цагдаа, хуульч, шүүгч, өмгөөлөгчид г.м.)

Үйл ажиллагааны хувьд ухуулга, сурталчилгаа хийх, хүчирхийллийн асуудлаар ажиллах мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, хүчирхийллийн эрт үеийн шинж тэмдгийг олж илрүүлэх, хүчирхийллийг газар авахаас нь өмнө таслан зогсоох мэдлэг, ур чадвар эзэмшигүүлэх зорилгоор олон улсын туршлагаас суралцуулах зэрэг хэлбэрийг хамарч байна.

Ядуу, орлого багатай иргэдэд эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх төвүүдийг ХЗДХЯ, НҮБХХ, Нээлттэй нийгэм форум хамтран бүх аймгийн төв, Улаанбаатар хотын дүүргүүдэд 2008 онд байгуулаад байна. Иргэдийн хариултаас үзэхэд тус төвийн үйлчилгээний талаар мэдлэг, мэдээлэл бага байгаа нь харагдаж байв.

НҮБ-ын системийн байгууллагууд - НҮБХХ, НҮБХАС, НҮБХС, ДЭМБ-аас 2007-2008 онд хамтран хэрэгжүүлсэн “Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” төслийн үр дүнд ЖҮХ-ийн хохирогчдод үйлчлэх нэг цэгийн үйлчилгээг бий болгох талаар ХЗДХЯ, НХХЯ, ЭМЯ-ны хамтарсан журмыг<sup>43</sup> боловсруулан гаргаж, Гэмтэл согогийн үндэсний төв, Шүүх эмнэлэг, Сүхбаатар

<sup>43</sup> Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмерийн сайдын хамтарсан тушаал: Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах тухай, 2009 оны 9 сарын 22, #308/189/129

Дүүргийн эрүүл мэндийн нэгдэл дээр гэр булийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлэх нэг цэгийн үйлчилгээг цагдаа, нийгмийн ажилтан, эмнэлгийн мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн багтай 2009 оноос ажиллуулж эхлээд байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хүйсийн тэгш эрхийн төв нь ЖҮХ-ийн хохирогчдод мэргэжлийн түвшний үйлчилгээ үзүүлдэг ТББ-үүд юм. ХЭҮТ нь 14 аймаг, Улаанбаатар хотын алслагдсан хоёр дүүрэгт салбартай үйл ажиллагаагаа явуулж байна. Тэрээр хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдэд сэтгэл зүй, хуулийн зөвлөгөө өгөх, шүүх ажиллагааны үеэр өмгөөллийн болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах, хүчирхийллийн хохирогчдод итгэлийн утас, интернэтээр зөвлөгөө өгөх, хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд, хүүхдийг түр хамгаалах байраар хангах үйлчилгээ үзүүлдэг. ХЭҮТ нь “Хүчирхийлэл үйлдсэн эрэгтэйчүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. “Эрэгтэйчүүдийн боловсрол” нэртэй анхны зөвлөгөө өгөх, сургалт явуулах сургалтын хөтөлбөрийг Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа баривчлан саатуулах төвд хоригдож байгаа эрэгтэйчүүдэд зориулан боловсруулсан. Энэ хөтөлбөр нь санхүүгийн дэмжлэг, төсвийн хомсдолын улмаас хэрэгжээгүй байна.

ХТЭТ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод (бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлэгийн хохирогч болон зуучлалын гэрлэлтийн хохирогч г.м.) нутагтаа эсэн мэнд эргэж ирэх, эргэж ирсний дараа нөхөн сэргээх өргөн хүрээтэй цогц үйлчилгээг үзүүлдэг. Эдгээр үйлчилгээ тусламжийн хүрээнд хүний наймааны хохирогчдыг тухайн улс оронд нь олж холбоо тогтоох, тэднийг хүний наймааны золиос болохоос нь аврах, Монголдоо ирснийх нь дараа нөхцөл байдалдаа дасч хэвийн байдалд эргэн ороход нь туслах зэрэг үйлчилгээ багтдаг. Монгол орныхоо нөхцөлд байдалд дасч, хэвийн байдалдаа эргэн ороход нь туслах үйлчилгээнд хамгаалах байраар хангах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хуулийн шаардлагатай тусламж үзүүлэх, боловсролын болон мэргэжлийн сургалтанд хамруулах, дамжих байр эсвэл арай урт хугацаагаар амьдрах орон байраар (Монгол гэр г.м.) хангах зэрэг үйлчилгээ багтдаг. ХТЭТ нь хүний наймааны болон бэлгийн хүчирхийллийн хохирогч золиос болсон эмэгтэйчүүд, охидод зориулсан хамгаалах байр ажиллуулдаг. Одоогоор эрэгтэй хохирогчдод зориулсан хамгаалах байр байхгүй байна<sup>44</sup>.

---

<sup>44</sup> “Монгол Улсад хүний наймааны гэмт хэрэгтэй тэмцэх нь: Хохирогчдыг нутагт нь эргүүлэн авчрах, нийгэмших, чадавхижих үйл явцад нь дэмжлэг үзүүлэх нь” төслийн үнэлгээний тайллан, 2008

### Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв байгуулагдаа

“Хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлийн үйл ажиллагаа ихэвчлэн хүчирхийлэл бүхий нөхцөлд байгаа, хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалахад түлхүү чиглэсэн байдаг. Харин хүчирхийлэл үйлдэж байгаа болон үйлдсэн хүмүүст чиглэсэн, тэдний хүчирхийлэл үйлдэж буй сэтгэл зүйн учир шалтгааныг тодруулах, тэрхүү зан үйлд нь зэрэгээр нөлөөлөх, хүчирхийллийн хор холбогдлыг ойлгуулах энэ талаар зөв ойлголтыг олон нийтэд хүргэхэд чиглэсэн ажил дутагдалтай байгаа юм.

Одоогийн байдлаар хүчирхийллийн үйлдэлдээ хариуцлага хүлээж байгаа, албадан саатуулах, баривчлах төвд саатуулагдаж буй хүмүүсийн ихэнх нь энэ асуудлаар албадан саатуулагдаж байгаа эрчүүд байна. Тухайлбал: АСБТөвд 2010.01.01-04.01-ний байдлаар нийт 1157 хүн албадан саатуулагдсанаас: садар самуунтай холбоотой асуудлаар - 7, гэр булийн зөрчил, хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар - 426, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон - 334, удаа дараа эрүүлжүүлэгдсэн - 250, танхайрсан - 139 гэсэн тоо баримт байна.

Дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн хүчирхийллийг бууруулахад эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтаар оролцогчийн зүгээс үйлдэгдэх бүх хэлбэрийн хүчирхийллийг дуусгавар болгох зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, НҮБХХ-ийн Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх төсөл, Монголын эрэгтэйчүүдийн холбоо хамтран анх удаа Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвийг 111 дүгээр албадан саатуулах, баривчлах байр дээр байгуулж, 2010 оны 6 дугаар сард нээлтээ хийжээ.

Уг төв нь хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдийг сургалтад хамруулснаар харилцааны ур чадвар эзэмшүүлэх, хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх, аливаа эрсдэлээс өөрийгөө хамгаалах чадварт сургах, хүчирхийлэл, хууль эрх зүйн талаар ерөнхий ойлголт мэдлэг мэдээлэлтэй болгох, зан үйлд нөлөөлөх сургалтанд хамрагдсанаар хохирогчийн аюулгүй байдлыг давхар хамгаалах зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах юм.

Эх үүсвэр: [www.humanrights.mn](http://www.humanrights.mn)

Орон нутагт гарч байгаа санаачлагаас дурдвал хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах сум, хороо, багийн Засаг дарга, цагдаа, эрүүл мэнд, нийгмийн ажилтны

мэргэжлийн хамтарсан багийг 2000 оноос эхлэн байгуулж 2007 оны байдлаар Улаанбаатар хот, Дорнод, Өмнөговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дундговь, Дархан-Уул, Баян-Өлгий, Баянхонгор аймгуудын Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ ийм баг байгуулж, холбогдох ажилтнуудын ажил үүргийн хуваарыт өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан байна.

НҮБХАС-ын дэмжлэгтэйгээр Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд “Гэр бүл, эмэгтэйчүүд хүүхдүүдэд зөвлөгөө өгөх төв”-ийг байгуулжээ. Энэ төв хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, холбогдох ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байна.

### **Хэрэглээний судалгаа**

Үйлчилгээг иргэд, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн өмнө тулгамдаж буй хэрэгцээг бодит байдалтай нийцүүлэх нь үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх ажлын эхлэл болох юм. Тиймээс бодит хэрэгцээг тодорхойлоход **судалгааны** гүйцэтгэх үүрэг чухал болдог. Ихэнх хөтөлбөр, төслийг тодорхой судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулдаг бөгөөд аливаа шинэ үйлчилгээ нь тухайн үед хэрэгжүүлж байгаа үйлчилгээ ба арга хэмжээг хэрэгжүүлэх явцад тодорхойлсон хэрэгцээн дээр үндэслэн бий болдог. Судалгаа шинжилгээний байгууллагууд, эрдэмтэд, мэргэжлийн хүмүүс, төрийн бус байгууллагуудын хийсэн нилээд олон тооны судалгаа байна.

Мэргэжилтнүүд болон судлаачдын хариултаас харахад судалгааны үр дүнг ашиглах явдал тун хангалтгүй байна. Ихэнх тохиодолд судалгааны үр дүн, зөвлөмжүүд нь зөвхөн судлаачид болон судалгааг захиалан хийлгэсэн байгууллагын хүрээнд үлддэг. Судалгааны илтгэлд ашигласан үг хэллэг төдийгүй мэргэжлийн нэр томъёог тайлбарласан, ашигласан байдал нь судалгааны тайланг үр дүнтэй ашиглах эсэхэд нөлөөлөх чухал хүчин зүйл юм. Үүнд аливаа судалгааны тайланг бичиж байгаа судлаачдын монгол хэлний мэдлэг болон орчуулгын чанар (хэрэв тайланг орчуулсан бол) гээд бусад олон асуудал нөлөөлдөг. Зарим тайлан зөвхөн англи хэл дээр байдаг нь англи хэлний мэдлэггүй хүмүүс болон олон нийтийн хувьд ашиглах боломжгүй баримт бичиг болон үлддэг.

Энэхүү судалгаанд хамрагдсан нийгмийн асуудлаар судалгаа явуулдаг судлаачид болон бусад олон хүний үзэж байгаагаар судалгааны чанарыг сайжруулах зайлшгүй шаардлага байна.

Хүчирхийллийн асуудлаар өмнөх судалгаанд хийсэн үнэлгээнээс дүгнэхэд тэдгээрийн ихэнх нь эмэгтэйчүүдийн дунд хийгдсэн хүн амд суурилсан,

хүчирхийллийн асуудлаар эмэгтэйчүүдийн ойлголт, туршлагыг судлахад чиглэсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэл болон хил дамнуулан худалдаалах хэргийн хохирогч болсон хүмүүсийн асуудлаар “үйлчилгээнд суурилсан” судалгааны тоо харьцангуй цээн байна. Судалгааны үр дүнгээс хараад хүчирхийлэл нь гэр орон, ажлын байр, боловсролын байгууллагууд болон олон нийт гэх зэргээр нийгмийн бүхий л хүрээнд үйлдэгдэж байна. Гэхдээ эдгээр судалгаа нь хүйсээр ангилсан мэдээлэл, дүн шинжилгээний хувьд дутагдалтай байна. Ялангуяа хүүхэд, өндөр настай хүмүүсийн тухай мэдээллийн хувьд эдгээр нь жендерийн үүднээс харалган хандсан нь харагдаж байна.

### Онол бий болгох нь

**Онолын хувьд** авч үзвэл хүчирхийллийн асуудлын нарийн төвөгтэй байдлаас үүдээд түүнийг тайлбарласан янз бүрийн онол байдаг. Хүчирхийллийн асуудлаарх судалгаануудад<sup>45</sup> хамгийн олон иш татаж хүчирхийллийг тайлбарласан онолуудаас нэрлэвэл Биологийн хувьд тайлбарласан онол<sup>46</sup>, Хувь хүний сэтгэцийн эмгэгийн онол<sup>47</sup>, Хосуудын болон гэр бүлийн харилцааны онол<sup>48</sup>, Нийгмээс суралцахуйн болон хөгжлийн үе шатны онол<sup>49</sup> болон Нийгмийн бүтцийн онол<sup>50</sup> болно.

Гэр бүлийн хүчирхийллийн шалтгааныг тайлбарласан хүчин зүйлийн талаарх янз бүрийн үзэл баримтлалын зэрэгцээ эдгээр онолд түгээмэл байдаг итгэл үнэмшилүүд бас бий. Эдгээрт: i) гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн асуудал болохыг үл хайхрах явдал саяхныг хүртэл байсаар байсан бөгөөд одоог хүртэл бүрэн гүйцэд сайн тайлбарлагдаагүй/оилгогдоогүй хэвээр байна; ii) гэр бүлийн хүчирхийлэл нь олон хүчин зүйлээс үүдэлтэй олон талт асуудал юм; iii) хүүхэд бага насандаа хүчирхийлэлд болон өөр бусад төрлийн айдаст өртөж байснаас

<sup>45</sup> Emerging Strategies in the Prevention of Domestic Violence, David A. Wolfe and Peter G, 1999

- Theory-derived explanation of male violence against female partners: literature update and related implications for treatment and evaluation. Alison Gunningham etc, 1998

<sup>46</sup> Энэ онолын дагуу, хүчирхийлэгч зан үйл нь биологийн буюу органик шинжтэй бөгөөд удамшил, биохимийн үйл явц, болон гэмтлийн улмаас үссэн тархины үйл ажиллагааны өөрчлөлтөөр тайлбарлагдана. Энэхүү онолын үнэн эсэх нь маргаантай, судалгааны баримт нотолгоо бага байдаг ч ихэнх судлаачид зарим тохиолдолд биологийн хүчин зүйл тодорхой үүрэг гүйцэтгэнэ гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

<sup>47</sup> Энэ үзлээр, гэр бүлийн хүчирхийлэл нь хувь хүний сэтгэцийн эмгэг байдлаас эсвэл хувь хүний гажуудсан зан төлвөөс үүдэлтэй ба ихэвчлэн төрөлхийн гэхээс илүүтэйгээр бага насны амьдралын туршлагаас бий болдог.

<sup>48</sup> Энэ онол нь гэр бүлийн хүчирхийллийг хосууд болон гэр бүлийн тогтолцооны гажуудал, харилцааны доголдлоос үүдэлтэй бөгөөд гэр бүлийн харилцааны нөхцөл байдал, хэв шинж, төлөвийг ойлгохгүйгээр хувь хүний хүчирхийлэгч зан үйлийт засахыг оролдох боломжгүй гэж үздэг.

<sup>49</sup> Энэ үзэл нь гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүрээнд болон нийгмийн зүгээс үлгэрлэн, сайшааж, дэмжсэнийн улмаас сурч авдаг зан үйл юм гэж тайлбарладаг.

<sup>50</sup> Энэ үзлээр бол, гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүл доторхи тэнцвэртэй биш эрх мэдлээс үүдэлтэй бөгөөд үүнийг зөвхөн нийгмийг бүхэлд нь дүгнэн шинжлэх замаар л ойлгож болно. Гэр бүлийн хүчирхийлэл нь тухайн нийгэмд эмэгтэйчүүдийн тэгш эрх хангагдаагүй болон үүнийг нийгмийн бүтэц, тогтолцоо нь улам бэхжүүлж байгаагийн илрэл юм.

үүдэлтэй хүүхэд насын айdas, сэтгэлийн гүн хямрал цочрол нь гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлдөг байх талтай; iv) гэр бүлийн хүчирхийллийг олон нийт болон байгууллагуудын зүгээс хүлээн зөвшөөрөх ойлголт хандлага байсаар байгаа нөхцөлд урьдчилан сэргийлэх ажлууд үр дүнтэй байх боломж тун бага юм.

Хүчирхийллийн олон талт байдал болон түүнийг шийдвэрлэх амархан шийдэл байдаггүй учраас түүнийг дан ганц онолоор хангалттай тайлбарлах боломжгүй боловч онол бүр тус тусын чухал тайлбарыг өгдөг. Онолын баримт бичгүүдэд гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн хүчин зүйл, гэр бүлийн байдал, эсвэл хувь хүмүүсийн зан чанартай илүүтэй холбон тайлбарладаг бөгөөд нийгэм, гэр бүл, хувь хүний хүчин зүйлсийн үүднээс тайлбарлахыг оролдож буй судлаачдын тоо нэмэгдсээр байна. Олон талт үзэл баримтлал, хандлагууд нь асуудлыг шийдвэрлэхэд энгийн хариу арга хэмжээ авах байдлаас зайлсхийх, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг олон нийтээрээ далайцтай тэмцэх, түүний дотор эрсдэлд байгаа хүмүүс төдийгүй олон нийтэд хандсан соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудад хүчирхийллийг үл тэвчих бодлого боловсруулан ажиллах, сургуулийн хүүхдүүдийн дунд урьдчилан сэргийлэх ажил зохиох, хэвлэл мэдээллээр хүчирхийллийг өөгшүүлэн сурталчлах байдалд хяналт тавих, эрэгтэйчүүд эмэгтэйчүүд нийгмийн тэгш эрхтэй гишүүд байхад саад болж байгаа бүтцийн чанартай бэрхшээлүүдийг арилгах чиглэлээр ажиллах шаардлага байгааг дутуу үнэлэхэд нөлөөлж байна.

### Арга зүй

Мэргэжлийн хүмүүсийн ур чадварыг сайжруулахад зөвхөн сургалт явуулах нь хангалттай биш. **Арга зүй** онцгой ач холбогдолтой.

Газар дээр нь үзэж танилцах явцад хүчирхийлэлтэй тэмцэх, үйлчилгээ үзүүлэх талаарх мэдлэгийг практик дээр хэрхэн хэрэглэж ажиллах талаар сургалт зохион байгуулах шаардлагатай нь харагдсан. Сургалтын практик байдал болон арга зүйг ч мөн өөрчлөх шаардлагатай байна. Энэ нь ялангуяа хүчирхийллийн хохирогчид болон хүчирхийлэл үйлдэгчдэд нөхөн сэргээх чиглэлээр шууд үйлчилгээ хүргэн ажилладаг нийгмийн ажилтнууд болон сэтгэл зүйчдийн хувьд онцгой чухал юм. Тэдний хувьд онолын хувьд юу хийх ёстойгоо мэдэх боловч амьдрал дээр түүнээ хэрхэн хэрэглэх арга зүйн зааварчилгаагаар дутаж байдаг. Мэргэшсэн төрийн бус байгууллагууд, судлаачид, сургач багш нарын хамтын ажиллаганаы үр дүнд энэ чиглэлээр сүүлийн үед зарим нэг ахиц гарч байна. Олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэд хэдэн гарын авлага<sup>51</sup> гарсан. “Нийгмийн

<sup>51</sup> Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага: Гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг судлах, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь” ХЭҮТ, Азиин Сан, USAID, 2008  
Хүүхэд хамгаалал ба хүний наймаа, НҮБХС, 2009

ажилтнуудад зориулсан гарын авлага: Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь” (2008) гарын авлага нь хүчирхийллийн эрсдэл бүхий гэр бүлийн нөхцөл байдлын судалгааг хэрхэн хийх, гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийн үнэлгээ хийх, нийгмийн ажлын урьдчилан сэргийлэх болон нөхөн сэргээх үйлчилгээг хэрхэн хийх талаарх зааварчилгааг багтаасан болно.

Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх нь зөвхөн нийгмийн ажилтнуудын хариуцах асуудал биш гэдгийг онцгойлон дурдах нь зүйтэй. Тиймээс, хууль хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх чиг үүрэг бүхий бусад мэргэжилтнүүдийн хувьд ч ийм хэлбэрийн арга зүйн зөвлөмж, сургалтууд мөн адил чухал ач холбогдолтой.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан албадан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Албадан сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр батлах тухай ХЗДХЯ, НХХЯ-ны хамтарсан шийдвэр 2009 онд гарсан байна<sup>52</sup>. Тус хөтөлбөрт албадан сургалтын сэдвийн жагсаалтыг баталсан бөгөөд цаашид сургалтын агуулга, ашиглах гарын авлага, материалыг боловсруулж, сургагч багш нарыг яаралтай бэлтгэх хэрэгцээ байна.

Хүчирхийллийн асуудлаар орон нутагт ажиллаж байгаа мэргэжлийн хүмүүст мэргэжлийн удирдлагыг ашиглаж байгаа байдал тун ховор<sup>53</sup> бөгөөд ихэнх нь “ажлаа хийх явцдаа” суралцаж байгааг харгалзан үзэж ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхижуулах, мэргэжлийн удирдлагаар хангах тусгай арга хэмжээ авах шаардлагатай байна. Байгууллагын соёл, төлөвлөгөө, журам, төсөв нь ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх шинээр гарч байгаа хэрэгцээнд нийцсэн хүчирхийлэлтэй тэмцэх байгууллагын зорилго, зорилтуудтай уялдсан байх ёстой.

Хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр тэргүүн туршлагыг олж илрүүлэх, түүнчлэн арга туршлага, механизмын талаар харилцан туршлага солилцох нь арга зүйг боловсруулах болон амьдралд үр дүнтэй хэрэгжүүлэх үйл явцад ахиц гаргахад эрэгээр нөлөөлнө.

---

(Төсөл) Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага: Хүний наймааны хохирогчидтой ажиллах нь, 2009  
(Төсөл) Сэтгэл зүйчдэд зориулсан гарын авлага: Хүний наймааны хохирогчидтой ажиллах нь, 2009

<sup>52</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаал: Албадан сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр батлах тухай, 2009 оны 3 сарын 20 #69/55

<sup>53</sup> Газар дээр үзэж танилцах судалгааны үеэр мэргэжлийн удирдлагыг ганцхан Английн хүүхдийг ивээх сан хэрэгжүүлдэг болох нь харагдсан. Эмээг бүлгийн гэр бүл, хүүхдүүдтэй ажилладаг нийгмийн ажилтнуудад мэргэжлийн удирдлага, зааварчилгаагаар хангах үүрэгтэй нийгмийн ажлын мэргэжлийн өндөр зэрэгтэй нийгмийн ажилтныг гэрээгээр ажиллуулдаг байна.

## ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Энэхүү шинжилгээнд жендерэрийн “институцилалын төр”-ын аргыг ашигласан нь ЖҮХ-ийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, үзүүлж буй үйлчилгээ, оролцогч талуудын санал бодлыг хамруулан өргөн хүрээнд дүгнэлт хийх боломжийг олгосон юм.

- Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлд эмэгтэйчүүд илүү өртдөгөөс энэ асуудлыг эмэгтэйчүүдийн асуудал гэж үзэж, түүний нийгэм, эдийн засаг, улс төрийн суурь шалтгааныг анхааран авч үздэггүй нийтлэг хандлага байна. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хоорондын эрх мэдлийн ялгаатай байдлыг авч үзсэнээр жендерээс үүдэлтэй хүчирхийллийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх бодлого боловсруулах боломжтой болно.
- Засгийн газраас үндэсний олон хөтөлбөрийг баталж гаргасан нь хүчирхийллийн асуудалд ач холбогдол өгч байгааг харуулж байгаа ч ЖҮХ-ийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдэд үйлчилгээ үзүүлэх үүрэг үндсэндээ төрийн бус байгууллагуудын нуруун дээр байгаа гэж хэлж болно. Мэргэжлийн үйлчилгээний хүртээмж орон нутагт хангалтгүй, ихэвчлэн Улаанбаатар хотод төвлөрсөн байна.
- Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ нь ихэнхдээ хохирогч эмэгтэйчүүд, хүүхдэд чиглэсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулсан хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлдэгчдэд чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагаа байхгүй байна. (Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвийн ажил дөнгөж эхлэлийн шатандаа байгаа).
- Хохирогчдод чиглэсэн үйл ажиллагаа дангаараа үр дүнд хүрч чадахгүй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхдээ эрсдэлд байгаа иргэдтэй ажиллахын зэрэгцээ хүчирхийллийг үл тэвчих нийгмийн соёл бий болгох, сургуулийн хүүхдүүдийн дунд урьдчилан сэргийлэх ажлыг өрнүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийллийн агуулгатай зүйл сурталчлахыг хориглох, иргэний боловсролыг дээшлүүлэх зэрэг хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлийг өөрчлөхд чиглэсэн урьдчилан сэргийлэх олон талт стратеги бий болгох шаардлагатай.
- Хүчирхийллийн эсрэг тэмцэлд эрэгтэйчүүдийн оролцоо бага байна. Жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд эрэгтэйчүүд, хөвгүүдийг татан оруулахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Эрэгтэйчүүдийг үе тэнгийнхэн болон гэр бүлдээ нөлөөлөх зэргээр

*Жендерээс цүдэлтэй хүчирхийлэл Монголд*

хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд оролцуулах боломжоор хангах шаардлагатай.

- Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн чиглэлээр ажилладаг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаа, шүүх, эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, туршлага шаардлага хангахгүй байна. Ялангуяа сум, хорооны түвшинд ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх нь үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

**Хавсралт нэг: Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, үйлчилгээ**

Энэхүү хавсралтад төрийн болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлж байгаа хүчирхийлэлтэй шууд болон шууд бус холбоотой хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны талаар мэдээллийг тоймлон оруулав. Энэхүү мэдээллийг хөгжлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын удирдах ажилтнууд хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөхөд ашиглана хэмээн найдаж байна.

**Нэг. Засгийн газрын хөтөлбөрүүд**

**Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, 2003-2015**

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр нь төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа – механизмыг бүрдүүлэх, уул эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг туштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үйлсэд засаг төрийн байгууллага, албан тушаалтны санаачлага, хариуцлагыг дээшлүүлэн, иргэний нийгэм, юуны өмнө нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн оролцоог өргөтгөн, үр нөлөөг нь сайжруулах, иргэдийн санаачлагыг өрнүүлэх чиглэл, арга замыг тодорхойлсон баримт бичиг юм.

Тус хөтөлбөрт эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар дараах заалтууд тусгагджээ:

2.2.6.4 Эмэгтэйчүүд, хүүхдийг элдвээр дарамтлах, доромжлох, хүнлэг бус хандах, тарчилган зовоох зэрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тэдгээрийн шалтгааныг илрүүлэн арилгах талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын чармайлтыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон Засгийн газрын түвшинд нэгтгэн зохицуулж, үр дүнг жил бүр мэдээлж байна. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хөлслөх (янхан болгох) зэргийг хатуу хориглохын хамт, тийм гэмт үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, байнгын хүчирхийлэлд өртөж болзошгүй эмэгтэйчүүд, хүүхдийг асран хамгаалах талаар гүйцэтгэх эрх мэдлийн зохих байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ.

2.2.6.6. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци зэрэг Монгол Улсын олон улсын гэрээнүүдийг гүйвалтгүй биелүүлж, энэ талаар НҮБ-ын зүгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар анхааралдаа авна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэх явдлыг устгах

тухай тунхаглал зэрэг эмэгтэйчүүдийн эрхийг хөхиулэн дэмжих талаар байгуулагдсан бүх хэллэлцээрт нэгдэх арга хэмжээ авна.

### **Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2007-2015**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд:

**Хамгаалах** - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэний дараа өртөх эрсдэл, болзошгүй аюул заналаас хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хүний эрхэд суурилсан эрх зүйн таатай орчин, бодлого, удирдамжийг боловсруулан хөгжүүлэх.

**Үйлчилгээ үзүүлэх** - Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийн хэрэгцээ, сонирхол, насанд тохирсон цогц үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх нийгмийн ажлын үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг сайжруулан хөгжүүлэх.

**Урьдчилан сэргийлэх** - Олон нийтэд урт болон богино хугацааны боловсрол олгох албан ба албан бус хөтөлбөрөөр дамжуулан гэр бүлийн хүчирхийллийг эсэргүүцэх, үл тэвчих ойлголт, мэдлэг, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, зан үйл, хандлагын эерэг өөрчлөлтийг бий болгохыг дэмжих.

### **Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр (2005-2015)**

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самоунд татагдахаас хамгаалах тухай Нэмэлт протокол, Хүн амын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 234 дугаар тогтоолоор баталсан. Хөтөлбөрийн зорилт:

- Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахын эсрэг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, бусад баримт бичигт туссан үйл ажиллагааг үндэсний түвшинд хэрэгжүүлэх.
- Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх тэмцэхтэй холбогдсон эрх зүйн орчинг боловсронгуй болгох.
- Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах, тэднийг садар самоунд уруу татах, дотооддоо болон хил дамнуулан худалдах гэмт хэрэг түүний улмаас хүүхэд эмэгтэйчүүдэд учирч болох хохирол, гарах үр дагаврын талаарх иргэний нийгэм, эцэг, эх, хүүхэд, залуучуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх.

- Нийгмийн ажилтан болон боловсрол, аялал жуулчлал үйлчилгээ, хууль хяналтын байгууллагын ажилтны чадавхийг бэхжүүлэх, хүүхэд эмэгтэйчүүдтэй ажиллах мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх.
- Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах дотооддоо болон хил дамнуулан худалдахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирогчийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд төрийн, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах.
- Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдний зүгээс гарсан санал санаачлагыг дэмжих.

**Хоёр: Олон улсын болон үндэсний байгууллагуудаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд**

#### **Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)**

НҮБ-аас 2007-2011 онд Монгол Улсад үзүүлэх Хөгжлийн туслалцааны хүрээнд жендерээс үүдэлтэй хүчирхийлэл, эдийн засгийн мөлжлөг, дарамт, үл хайхрах, эмзэг бүлгийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах эрх зүйн орчин, бодлогын арга хэмжээг бэхжүүлэх гэсэн зорилт тавьсан байна.

**НҮБ-ын системийн байгууллагуудын хамтарсан төсөл:** Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь, 2007-2008

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хамтран эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийг чадваржуулах, хохирогчдод үзүүлэх хууль эрх зүйн болон зөвлөх үйлчилгээг сайжруулах чиглэлээр төрийн болон иргэний нийгмийн нэгдсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх, энэ үйл явцад НҮБ-ын байгууллагуудын зуучлагчийн үргийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжүүлсэн.

Төслийн санхүү, техникийн туслалцаатайгаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төвийг байгуулах, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг боловсруулах бэлтгэл ажлыг эхлүүлснээр 2009 онд ЭМЯ, ХЗДХЯ, НХХЯ-ны холбогдох шийдвэр гарсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах үүрэгтэй аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын эрх зүйн 60

ажилтан, 20 сэтгүүлч, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж болох эрсдэлтэй, хил залгаа сумын иргэд, төрийн албан хаагчид 150 хүн, цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын 40 гаруй ажилтан жендерээс үүдэлтэй хүчирхийлийн сургалтанд хамрагдсан байна.

Төслийн хүрээнд гарсан эдгээр санаачлага одоо хүртэл үргэлжилж байгаа бөгөөд хүчирхийлэлтэй тэмцэхэд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх зорилготой “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв”-ийг ХЗДХЯ, Цагдаагийн ерөнхий газар, НҮБХХ-ийн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх” төсөл, Монголын эрэгтэйчүүдийн холбоо хамтран анх удаа 111 дүгээр албадан саатуулах, баривчлах байр дээр байгуулж, 2010 оны 6 дугаар сард нээлтээ хийжээ. Жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэх салбар хоорондын ажлын хэсэг төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоотой байгуулагдсан бөгөөд одоо хэр нь идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

### **НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ)**

Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх төслийг 2007 оноос эхлэн Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран хэрэгжүүлж байгаа. Энэ төслийн хүрээнд ядуу, орлого багатай иргэдэд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийг 21 аймаг, Нийслэл хотын дүүргүүдэд байгуулан ажиллаж байна. Тус төвүүд нь ЖҮХ-ийн хохирогчдыг хүлээн авч үйлчилдэг бөгөөд төвийн өмгөөлөгч наарт зориулан ЖҮХ-ийн талаар сургалт зохион байгуулж, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй хийж байна. Эмэгтэйчүүдийг ялгavarлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтэд дэмжлэг болгож цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага, төрийн бус байгууллагын ажилтнуудад сургалт хийх, Жендерийн тэгш байдлыг хангах хуулийг батлуулах ухуулга, сурталчилгааны ажлыг явуулж байна. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орох үйл ажиллагааг дэмжиж, конвенцийг сурталчлах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулжээ.

“Эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлээс урьдчилан сэргийлэх нь” НҮБ-ын хамтарсан төслийн хүрээнд эхлүүлсэн санаачлага болох гэр бүлийн болон ЖҮХ-ийн хохирогчдод үйлчлэх нэг цэгийн үйлчилгээг байгуулах, хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийг боловсруулах техник туслалцаа үзүүлж, ЖҮХ-тэй тэмцэхэд эрэгтэйчүүд, хөвгүүдийг татан оролцуулах кампанит ажлыг тус төслийн хүрээнд дэмжин ажиллаж байгаагийн нэг жишээ нь Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвийг байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

### **НУБ-ЫН ХҮН АМЫН САН (НУБХАС)**

Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн талаарх судалгаа, ойлголтыг бий болгох үйл ажиллагаа, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлдэг.

НУБХАС-ын дэмжлэгтэйгээр Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд “Гэр бүл, эмэгтэйчүүд хүүхдүүдэд зөвлөгөө өгөх төв” байгуулжээ. Энэ төв нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, холбогдох ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байна.

### **НУБ-ЫН ХҮҮХДИЙН САН (НУБХС)**

#### *Хүүхэд хамгааллын хөтөлбөр (2007-2011)*

Энэхүү хөтөлбөр нь бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдийн чадавхийг бэхжүүлэх, тэдэнд нөлөөлөх замаар хүүхэд хамгааллын орчинг сайжруулах. Хөтөлбөрийн дэд зорилтуудад: 1) Хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдлаас хамгаалах цогц механизмыг бий болгох; 2) Хүүхдийн эрхийн тухай конвенци болон олон улсын стандартад нийцсэн хүүхэд хамгаалал, ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэгт өртсөн хүүхэд, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчинг сайжруулах; 3) Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн болон ТББ-уудын үйлчилгээг хүргэх чадавхийг бэхжүүлэх; 4) Бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчид, иргэний нийгмийн байгууллагуудын хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх.

#### *Боловсролын хөтөлбөр (2007-2011)*

“Хүүхдэд ээлтэй сургууль” төсөл нь суурь боловсролын багш нарын хүүхэд төвтэй заах арга зүйн чадавхийг бэхжүүлэх, үндэсний, орон нутгийн болон сургуулийн түвшинд хүүхдэд ээлтэй сурах орчинг бүрдүүлэх, ялангуяа хүчирхийлэл, дарамт, зодож шийтгэх явдлыг устгахад чиглэсэн чадавхийг бэхжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилготой.

**Олон улсын шилжин суурьшлын байгууллага (ОУШСБ): “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх; хохирочид үзүүлэх тусламж, дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх ” төсөл**

Энэхүү төсөл нь 1) Холбогдох төрийн байгууллага, тухайлбал, элчин сайдын яамд, ТББ-үүд, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх, хүн худалдаалагдаж буй зарим цэгүүдээр дамжуулан хохирочийг буцаан авчрах, хэвийн амьдралд нь эргэж оруулах, хохирогчдыг олж илрүүлэх, хамгаалах, туслах механизмыг бий болгох; 2)

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх магадлалтай хүн ам болон бусад оролцогч талуудын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, 3) Монголд болон гадаад улс оронд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах: Үүнд: түр орон байраар хангах, эмнэлгийн болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, буцах зардлыг нь даах, хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслах.

Төслийн үйл ажиллагаа нь дараах зорилтот бүлэгт чиглэгдсэн: 1) Төрийн болон хууль хэрэгжүүлэх байгууллагууд, тухайлбал гадаад оронд суугаа элчин сайдын яамд; 2) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг Монголын болон монгол хүн худалдаалагдаж буй зарим гадаадын орны ТББ, иргэний нийгмийн байгууллагууд; 3) Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй бүлгүүд; 4) Худалдаалагдсан залуу хохирогч эмэгтэйчүүд.

Сүүлийн нэг жилийн дотор уг төслийн 142 хохирогчид туслалцаа үзүүлснээс 109 нь эмэгтэй, 33 нь эрэгтэй, 13 нь хүүхэд байсан<sup>54</sup>.

**Олон улсын хөдөлмөрийн байгууллагын АЙПЕК хөтөлбөр: "АНУ-ын Хөдөлмөрийн департмантаас санхүүжүүлсэн хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах"**  
Үндэсний дэд хөтөлбөрийг дэмжих төсөл (2005-2009)

ОУХБ АЙПЕК-аас хоорондоо уялдаатай дараах хоёр стратеги зорилтыг дэвшүүлсэн. Үүнд: 1) Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний хэмжээний үйл ажиллагааг дэмжсэн зэрэг орчныг бэхжүүлэх (бодлого, хууль эрх зүй, чадавхи ба мэдлэг бий болгох); 2) Охид, хөвгүүдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх зорилгоор сонгосон аймаг, орон нутгийн хэмжээний үйл ажиллагааны загварыг хэрэгжүүлж дэлгэрүүлэх зорилготой.

### **Бусад олон улсын байгууллагууд**

#### **АДРА: Боловсролын төсөл**

Өсвөр насны хүүхэд болон сургагч багш нарыг бэлтгэх замаар сургуулийн орчинд жендерээс үүдэлтэй хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэх төслийг хэрэгжүүлдэг. (Улаанбаатар хотын 4-р сургуульд). Төслийн хүрээнд хүүхэд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургуулийн орчинд бие биенээ дээрэлхэхийг багасгах мэдлэг, ур чадварыг зааж сургадаг. Сургагч багшийг бэлтгэх сургалтын хөтөлбөр нь харилцааны ур чадвар, зөрчлийг шийдвэрлэх аргууд, сэтгэл хөдлөлөө удирах аргууд, уур хилэн, охид хөвгүүдийн хоорондын харилцаа, урьдчилан

<sup>54</sup> IOM, Project External Evaluation Report, 2008. Combating Trafficking in Persons in Mongolia: Return and Reintegration Victims' Assistance and Capacity Building

сэргийлэх, аюулгүй байдлаа хангах зэрэг сэдвийг багтаасан. Өсвөр үеийн сургагч багш нар сургууль дээрээ өөрсдийн анги хамт олны дунд үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү төслийн хүрээнд АДРА-гаас хэрэгжиж байгаа бүх олон нийтийн сургалтын хөтөлбөрт жендерээс үүдэлтэй хүчирхийллийн асуудлыг тусгахаар төлөвлөж байгаа.

### **Азийн сан**

Азийн сан нь үндэсний төрийн бус байгууллагуудад төслийн санхүүжилт хийх замаар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх орон нутгийн санаачилгыг дэмждэг. Тус сан нь 2004 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулахад чиглэсэн лобби, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжсэн ба түүнээс хойш дараах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.

- Хохирогчийг хамгаалах байрыг шинэчлэх, өргөтгөх, цагдаа болон бусад мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалт, ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаа; гэр бүлийн хүчирхийллийг бүртгэх компьютерт сууриссан мэдээллийн систем бий болгох; хохирогчийг хамгаалах, хүчирхийлэгчийг шийтгэхэд ашиглах баримт нотолгоог бүрдүүлэх үйл ажиллагааг сайжруулах; гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх (ХЭҮТ);
- Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар үндэсний болон олон улсын хууль эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийх, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчдэд хүлээлгэх хариуцлага тооцох механизм бий болгох (ХЭХТ);
- Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр ажилладаг хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудад хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт явуулах; 24 цагаар утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгосноор хохирогчид болон эрсдэлтэй бүлгүүдийг шаардлагатай мэдээллээр хангах (ХТЭТ);
- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх (Монголын оюутны холбоо).

### **Дэлхийн зөн – Монгол (ДЗМ): “Хүүхдийн эрх ба нөлөөлөл” хөтөлбөр**

Дэлхийн зөн хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийн оролцоог хангах, сэтгэцийн эмгэгтэй хүүхдүүдэд олон нийтэд сууриссан үйлчилгээг хүргэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зэргээр өргөн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд хохирогч хүүхэд, насанд хүрэгчдэд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хохирогчийг хамгаалах үйлчилгээний арга зүйг сайжруулах зэрэг багтдаг. Эмэгтэйчүүд, хүүхдийг хил давуулан худалдаалах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагаа нь судалгаа, сургалт, ойлголт нэмэгдүүлэх, хохирогчдод дэмжлэг үзүүлэх, хууль эрх зүйн орчин, нийгмийн хяналтыг сайжруулах.

### Их Британий Хүүхдийг ивээх сан: Хүүхэд хамгааллын хөтөлбөр

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн үйл ажиллагаа нь: 1) Бүх орчинд хүүхдийг бие махбодь, сэтгэл санааны шийтгэл ногдуулхаас хамгаалах, чадавхи бэхжүүлэх, нөлөөлөх, энэ чиглэлээр олон нийтийн хандлагыг өөрчлөх, хүүхэд хүмүүжлийн өөр хувилбаруудыг бий болгох, хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгох; 2) Олон нийтэд сууриссан хүүхэд хамгааллын үйлчилгээг өөрийн олон нийтийн төвүүд, хүүхэд асрах төвүүд, хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа явуулж буй төвүүдээрээ дамжуулан хөгжүүлэх.

ИБ-ний ХИС нь боловсролын чиглэлээр 2 төсөл хэрэгжүүлсэн. 1) Хүчирхийллээс ангид сургуулийн орчинг бий болгох (2008-2011), 2) Хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд (2008-2009). Эдгээр төслүүдийн зорилго нь: 1) Боловсролын хуульд орсон өөрчлөлтийн талаар сургуулийн удирдлага, багш, эцэг эх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх (2006); 2) Багш нарын хүүхэдтэй ажиллах эерэг аргыг ашиглах чадавхийг дээшлүүлэх, 3) Боловсролын хуульд орсон зарим өөрчлөлт, тухайлбал, хүүхдийг зодож шийтгэх, ялгаварлан гадуурхах, хууль бусаар мөнгө татах зэрэг заалтын талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх.

### Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА): Монгол дахь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр<sup>55</sup>

Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах үйл ажиллагааг эрчимжүүлэх явдал юм. Хөтөлбөр нь хууль эрх зүйн орчинг сайжруулах, тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг гэмт хэрэгт оролцсон хэмээн шийтгүүлдэг байдлыг зогсоох, тэдэнд үзүүлэх тусlamж дэмжлэг, хамгаалалтыг сайжруулах зорилготой. Хөтөлбөрийн 1-р үе шат (2008-2010)-нд гарахаар төлөвлөж буй үр дүн нь: 1) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тусlamж үзүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна; 2) Эмзэг бүлгийн иргэдээс хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх магадлал багассан байна; 3) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид болон тэдний гэр бүлд үзүүлэх үйлчилгээ, хамгаалал сайжирсан байна; 4) Хохирогчид үзүүлэх үйлчилгээ, хамгааллын чиглэлээр үндэсний хэмжээнд хууль сахиулах байгууллагуудын чадавхи нэмэгдэж, бусад орны байгууллагуудтай хамтын ажиллагаа сайжирсан байна.

### Эмнести интернэшнл

Эмнести интернэшнл нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичигт заасан хүний эрхийг дэлхийн хүн бүрт эдлүүлэх чиглэлээр ажилладаг ТББ юм. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх кампанит ажил зохион байгуулдаг. “Охидод ээлтэй сургууль” санаачлага нь

<sup>55</sup> [http://www.sdc.mn/en/Home/Development\\_Cooperation/Combating\\_Human\\_Trafficking](http://www.sdc.mn/en/Home/Development_Cooperation/Combating_Human_Trafficking)

## *Жендерээс цдэлтэй хүчирхийлэл Монголд*

---

бодлого, үйл ажиллагааг өөрчлөх замаар сургуулийн орчинд аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн хүчирхийллээс ангид болгож, охидыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чадвартай болгох зорилготой.

### **Гурав: Үндэсний ТББ-ын сүлжээ**

**Ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг ТББ-удын үндэсний сүлжээ:** Хэд хэдэн ТББ хамтран ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг үйл ажиллагаагаа нэгтгэхээр<sup>56</sup> байгуулагдсан. Сүлжээ нь гишүүн байгууллагуудаараа дамжуулан хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод эрх зүйн туслалцаа, сэтгэл зүйн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар зөвлөгөө өгөх, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар ойлголтыг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулах, хохирчийг хамгаалах хууль эрх зүйн орчинг сайжруулахад нөлөөлөх зэрэг үйл ажиллагааг явуулдаг.

**Монголын эмэгтэйчүүдийн сан (МЭС):** 2000 онд хөрөнгө нөөц дайчлан эмэгтэйчүүдэд санхүүгийн болон бүтэц, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлдэг анхны үндэсний түвшинд байгуулагдсан сан юм. Тус сан нь эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулах замаар нийгмийн хөгжилд бодитой эерэг нөлөө үзүүлж болно гэж үздэг. МЭС нь олон улсын болон үндэсний түвшинд хөрөнгийг бий болгож, эмэгтэйчүүдийн ТББ-уд, анхан шатны бүлгүүдэд төсөл хэлбэрээр өгдөг.

Эмэгтэйчүүдийн сан нь ТББ-удын дараах санаачилгуудыг дэмжиж 2001-2008 онуудад нийт 157 төсөлд 498.6 сая төгрөгийн санхүүжилт өгсөн. 2008 онд 25 төсөлд 108.9 сая төгрөгийн санхүүжилт өгсөн. Үүнд: 1) Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх; 2) Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх; 3) Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх. Хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлийн санхүүжилт нь ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар судалгаа, нөлөөлөл, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа, хүчирхийллийн хохирогч болсон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хүүхэд хамгааллын нэгжид дэмжлэг үзүүлэх, өсвөр наасны хохирогчдод хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх гэх мэт.

**Монголын эмэгтэйчүүдийн ТББ-удын сүлжээ (МОНФЕМНЕТ):** Энэхүү сүлжээ нь үндэсний хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 30 орчим байгууллагыг нэгтгэн, хөгжилд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, хөгжлийн үр

---

<sup>56</sup> Member organizations are: the NCAV, CCA, CHRD, MGECC, Gal Golomt Movement, MONFEMNET, MONES, Ber Tsetseg NGO, Mongolian Women Lawyers Association, Women Leaders Fund, Otgontenger University, MONEF, MCTU and Nisora Development Fund.

шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

**Монголын эрэгтэйчүүдийн холбоо (МЭрХ):** МЭрХ нь 2002 онд эрэгтэйчүүдийн гэр бүлдээ болон нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой байгуулагдсан. Уг холбоо нь эрэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаар ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний дуу хоолойг төлөөлөх, хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Эмэгтэйчүүдийн болон хүний эрхийн байгууллагуудтай нягт хамtran ажиллах замаар жендерийн хэвшмэл үзлийг өөрчлөх, жендерээс үүдэлтэй хүчирхийлэлтэй тэмцэхэд эрэгтэйчүүд, хөвгүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэж байна.

**Нисора хөгжлийн сан:** Нисора хөгжлийн сан нь 2005 онд ядуурал, ажилгүйдэл, гэр булийн хүчирхийллийн улмаас эрх нь зөрчигдэж байгаа эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настнуудын эрхийг хамгаалах зорилготой байгуулагдсан. Үндсэн үйл ажиллагаа нь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ойлголт нэмэгдүүлэх болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, дэмжих бүлэг ажиллуулах зэрэг үндсэн үйл ажиллагаанаас гадна хүчирхийлэгчийн зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн анхны алхмуудыг хийж эхэлсэн. Нисора сан нь ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ТББ-уудын сүлжээний зохицуулах байгууллагаар ажиллаж байна.

**Өсвөр үеийн хөгжлийн төв (ӨҮХТ):** Өсвөр үеийн хөгжлийн төв ТББ нь охидыг биеэ үнэлэх гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хөндийрүүлэх, нөхөн сэргээх, хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөгийн асуудлаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

**Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ):** ХТЭТ нь 2002 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой байгуулагдсан. ХТЭТ нь Олон улсын шилжин суурьшлын байгууллагын техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нийгэмд эргэн ороход нь туслах, чадваржуулах, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр тусламж үзүүлдэг. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх; гэмт хэргийн хохирогч, хүн худалдаалах гэмт хэрэг, хүчингийн гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогчийг хамгаалах хууль эрх зүйн орчинг бий болгох, тэдэнд холбогдох нийгмийн үйлчилгээг үзүүлэх, жендерийн тэгш байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

**Хүний аюулгүй байдлын бодлого, судлалын төв (ХАББСТ):** ХАББСТ нь Швейцарийн Хөгжлийн агентлагтай хамtran хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр (2008-2010)-ийг хэрэгжүүлэхэд хамtran ажиллаж буй ТББ.

**Хүний эрх хөгжил төв (ХЭХТ):** ХЭХТ нь 1998 онд байгуулагдсан. Хүний эрх, хууль эрх зүйн нөлөөлөл, өмгөөлөл, мониторинг хийх, судалгаа явуулах, зөвлөмж боловсруулах, мэдээлэл түгээх, сургалт, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, ном гарын авлага хэвлэн түгээх, дотоод гадаадын байгууллагуудтай сүлжээ холбоонд хамрагдах, олон нийтийн кампанит ажил зохион байгуулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлэх, чадавхижуулах үйл ажиллагаа явуулдаг. Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр нь Монгол Улсад хүн худалдах гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа хийх, сургалт явуулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тэдгээрт олон улсын жишигт нийцсэн нэмэлт өөрчлөлт оруулах, хохирогчдын эрх ашгийг хамгаалж тэдэнд хууль зүйн туслалцаа, өмгөөлөл үзүүлэх, мөн монгол иргэд ихээр зорчиж, хохирогч болдог улс орнуудтай хамтын ажиллагааг бий болгох, өргөжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулахад төвлөрдөг.

**Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний сүлжээ:** Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний сүлжээ нь 2008 оны 10-р сард ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (IPEC)-ийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан. Нийт 20 гаруй төрийн болон ТББ-ууд нэгдэн хүүхдийн бэлгийн мөлжлөг зэрэг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтарч ажилладаг.

**Хүүхэд хамгааллын үндэсний эвсэл:** Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн ТББ-уудын хамтын ажиллагаа, харилцаа холбоог бэхжүүлэх, хүүхдийг хүчирхийлэл дарамтаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулах зорилгоор 2007 онд байгуулагдсан. Дээрх эвслийг Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төв удирдан ажилладаг. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах төв нь хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг. Үүнд: 24 цагийн зөвлөх утас, хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх утас ажиллуулах, судалгаа, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг.

**Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ):** ХЭҮТ нь Монгол Улсад эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр байгуулагдсан анхны ТББ юм (1995). ХЭҮТ нь 14 аймаг, Улаанбаатар хотын алслагдсан хоёр дүүрэгт үйл ажиллагаагаа явуулж байна. Тус байгууллага нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдэд сэтгэл зүй, хуулийн зөвлөгөө өгөх, шүүх ажиллагааны үеэр өмгөөллийн болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах, хүчирхийллийн хохирогчдод итгэлийн утас, интернэтээр зөвлөгөө өгөх, хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд, хүүхдийг түр хамгаалах байраар хангах үйлчилгээ үзүүлдэг. ХЭҮТ нь “Хүчирхийлэл үйлдсэн эрэгтэйчүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. “Эрэгтэйчүүдийн боловсрол” нэртэй анхны зөвлөгөө өгөх, сургалт явуулах сургалтын хөтөлбөрийг Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа баривчлан

саатуулах төвд хоригдож байгаа эрэгтэйчүүдэд зориулан боловсруулсан. Энэ хөтөлбөр нь санхүүгийн дэмжлэг, төсвийн хомсдолын улмаас хэрэгжээгүй байна.

**ЭКПАТ-ЫН Үндэсний сүлжээ:** ЭКПАТ-ын Монгол дахь үндэсний сүлжээ нь хүүхдийн биеийг үнэлүүлэх, хүүхдийг садар самоун үзүүлбэрт (порнографид) ашиглах зэрэг хүүхдийн бэлгийн мөлжлөгийн бүх төрөл, хүүхдийг бэлгийн зорилгоор дамжуулан худалдаалах явдалтай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хамгаалах, энэ талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх зорилготойгоор 2004 онд байгуулагдсан. Энэхүү сүлжээ нь эхлээд үндэсний ТББ, цөөн хэдэн олон улсын ТББ-үүд, төрийн зарим байгууллагуудаас бүрдсэн 30 орчим гишүүн байгууллагатай үйл ажиллагаа явуулдаг ба Монгол Улсад хүүхдийн эрхийг хангах, хүүхдийг биеэ үнэлэх, садар самоунд уруу татах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилготой. Өсвөр үеийнхний хөгжлийн төв ТББ нь энэ сүлжээний зохицуулах байгууллагаар ажилладаг.

**Хавсралт хоёр: Жендерээс үүдэлтэй хүчирхийллийн тухай эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн туршлага - Фокус бүлгийн судалгаа**

Фокус бүлгийн ярилцлагын арга нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ойлголт туршлагыг судлахад ашигладаг чанарын судалгааны арга юм. Түүвэр судалгааны аргатай харьцуулахад чанарын судалгааны арга нь асуудлын олон талт шалтгаан, үр дагавар, нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгоход илүүтэйгээр тусалдаг. Түүнчлэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүчирхийллийн шалтгаан, үр дагаврын талаарх ойлголт, хандлагыг судлахад үр дүнтэй аргад тооцогддог.

Фокус бүлгийн ярилцлагын арга нь бусад аргатай харьцуулахад хэд хэдэн давуу талтай. Фокус бүлгийн ярилцлагаар хүн амд суурилсан судалгаа эсвэл үйлчилгээний мэдээллээр илрэхгүй асуудлын өөр олон талыг харуулж чаддаг. Фокус бүлгийн ярилцлагын үед оролцогдоос тэдний хувийн амьдралын талаар биш олон нийтийн туршлага, үзэл бодлыг асуудаг учраас оролцогчид мэдээлэл өгөх дуртай байдаг. Иймээс фокус бүлгийн ярилцлагаар хувь хүний тохиолдлууд биш, олон нийтийн нийтлэг туршлага илүү сайн харагддаг. Фокус бүлгийн сул тал нь бүлгийн ярилцлагын мэдээллийг хүн амд ерөнхийлөн дүгнэж болдоггүйд оршино. Фокус бүлгийн ярилцлага нь орон нутгийн хүмүүсийн үзэл бодлын талаар ерөнхий дүр зургийг харуулдаг. (Creswell, 1998).

**Судалгааны зорилго** нь жендерээс үүдэлтэй хүчирхийлэл гэр бүл, ажлын байр, сургуулийн орчин, нийтийн газар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдралд хэрхэн ялгаатайгаар илэрдэг, хэн хүчирхийлэгч, хэн хохирогч болох эрсдэлтэй байдаг, үүнээс хамгаалах хүчин зүйлс болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд энэ асуудлыг хэрхэн шийддэг зэргийг тодорхойлоход оршсон болно. Судалгаанд Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүрэг, Монгол Улсын баруун болон зүүн бусийн төлөөлөл болгон сонгон авсан Ховд, Дорнод аймгийн хүн амын өөр хоорондоо нас хүйс, нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай хэсгүүдийг төлөөлсөн 52 бүлгийг хамруулан хийсэн ярилцлагын үр дүнг ашиглав. Судалгааны хүрээнд дараах асуултуудад хариу эрэлхийлсэн. Үүнд:

- ЖҮХ-ийг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хэрхэн ойлгодог вэ?
- Тэдний амьдралд, ЖҮХ ямар хэлбэр, үйлдлээр илэрдэг вэ? Энэ нь бусад хүчирхийлээс ямар ялгаатай вэ?
- ЖҮХ-ийн хэлбэрүүд нь бэлгийн хамтрагч хосуудын харилцаа, гэр бүл, боловсролын байгууллага, ажлын байр, орон нутагт хэр нийтлэг оршдог вэ?
- Хэн ихэвчлэн хүчирхийлэгч болдог вэ?
- Хэн хохирогч болдог вэ? Ямар хүчин зүйл хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлдэг вэ?
- ЖҮХ-ээс ангид байх ямар хүчин зүйл байна вэ?

- ЖҮХ-ийн шалтгаан юу вэ? Эрх мэдлийн ялгаа, соёлын онцлог байна уу?
- Эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд ЖҮХ-д өртсөн тохиолдолд ямар арга хэмжээ авдаг вэ? Энэ чиглэлээр ямар үйлчилгээ, дэмжлэг байна вэ? Эдгээр үйлчилгээнүүд нь хэр үр дүнтэй вэ?

Дээрх фокус бүлгийн ярилцлагын үр дүнг гуравдугаар бүлэгт дэлгэрэнгүй танилцуулсан болно.

**Ашигласан эх сурвалж, ном зүй**

**Монгол хэл дээрх эх сурвалжууд:**

Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, USAID. 2006. *Хүн худалдаалах хэрэг Монголд: эмзэг, эрсдэл байдал, үр дагавар.*, УБ хот.

АНУ-ын Төрийн департамент, USAID, Азийн Сан, Хүний эрх, хөгжил төв. 2007. *Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор хийсэн судалгааны ажлын танилцуулга.*, УБ хот.

Ахмадын холбоо, Зохистой хөгжлийн жендер төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. 2004. *Ахмад настны эсрэг хүчирхийлэл*. УБ хот.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан, Монгол Улсын Боловсролын их сургууль, Хүний эрхийн үндэсний комисс. *Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам*. Судалгааны тайлан. УБ хот.

Их Британий Хүүхдийг ивээх сан, Зохистой хөгжлийн жендер төв. 2005. *Сургууль болон цэцэрлэгийн орчин дахь бие махбодийн шийтгэлийн талаар судалгаа*. УБ хот.

НҮБ-ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Дэлхийн зөн. (2006) *Хүн худалдах гэмт хэрэг ба охид, эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг*. УБ хот.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сан. 2004. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл. УБ хот.

Хөгжлийн Нисора сан, Ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ТББ-ын сүлжээ. 2006. *Ажлын байран дахь бэлгийн дарамт*: Сургалтын материал УБ хот.

Монгол Улсын Засгийн газар, Жендерийн тэгш байдлын үндэсний хороо. (2007). *Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр*. УБ хот.

Монголын эрэгтэйчүүдийн холбоо, НҮБ-ын Хүн амын сан. (2007). “*Эрэгтэйчүүдийн зан үйл - хүчирхийлэл үйлдэх шалтгаан нөхцөл бусад хүчин зүйлс*” судалгаа. УБ хот.

Хүн ам зүй сургалт судалгааны төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (1998). “*Хүчирхийлэл ба хууль*” судалгаа. УБ хот.

Хүний эрх хөгжил төв. (2005). *Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь: Асуудал ба арга зам.* УБ хот.

Хүний эрхийн үндэсний комисс ба НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр. (2007). *Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа.*, НҮБ-ын Ерөнхий НБД-ын тайлан /орчуулга/, УБ хот.

Эрүүл мэндийн яам, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. (2007). *Жендерээс үүдэлтэй хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн монгол дахь байдал.*, УБ хот.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн тусlamжийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан. 2005. *Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр булийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар.*, УБ хот.

ЭКПАТ, Тэгш мөр, НҮБ-ын Хүүхдийн сан. (2004). *Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн зорилгоор ашиглах, худалдах, зуучлах, хил дамжуулан худалдаалах асуудлаарх олон нийтийн ойлголт хандлагыг тодорхойлох нь.*, УБ хот.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын ахмадын холбоо. *Aхмад настнуудад учирч буй дарамтлал, хүчирхийлэл, судалгаа.* УБ хот.

Хүний эрх, хөгжил төв. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, ЭЯГБХУКХХ Үндэсний сүлжээний төв. *Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин, Судалгааны тайлан,* УБ хот.

#### **Англи хэл дээрх эх сурвалжууд:**

Asia Foundation, Gender Equality Center, USAID. (2006). *Trafficking in Mongolia: Risk, vulnerabilities and consequences.* Ulaanbaatar, Mongolia

Center for Human Right and Development, National Center Against Violence & CEDAW Watch Network. (2000). *Status of violence against women in Mongolia and Legal Environment.* Ulaanbaatar, Mongolia

Center for Human Right and Development, USAID, Asia Foundation & World Vision (2005). *Combating human trafficking in Mongolia: issues and opportunities.* Ulaanbaatar.

Ellsberg, M & Heise L. (2005). *Researching violence against women: Practical guide for researchers and activists.* Washington, DC: World Health Organization, PATH.

*Жендерээс цүдэлтэй хүчирхийлэл Монголд*

---

Levy, C. The Process of Institutionalizing Gender in Policy and Planning: The “Web” of Institutionalisation. Development Planning Unit, University College London. Working Paper No74. United Kingdom. 1999.

Ministry of Education Culture and Science, UNICEF, Mongolian State University of Education, National Human Right Council of Mongolia. Research Report. Violence at school and kindergarten environment and the ways to eliminate it. Ulaanbaatar, Mongolia

Ministry of Health, Health Development Center & UNICEF. (2005). Domestic violence against children and women and its health consequences. Ulaanbaatar, Mongolia.

Ministry of Health, National Center Against Violence & World Health Organization (2007) The status of Domestic Gender-based Violence and Violence against children in Mongolia. Ulaanbaatar.

Mongolian Association for Elderly, Gender Center for Sustainable Development & National Center Against Violence (2004) *Research on Violence Against Elderly*. Ulaanbaatar, Mongolia (in mongolian)

Mongolian Men's Association, UNFPA (2007). Men's violent behavior: causes, conditions and other factors. UB.

National Center Against Violence. Beneficiaries' Analysis for 2006. Internal report.

National Center Against Violence & Population Teaching and Resource Center (1998). Violence and Law: Survey

National Center Against Violence & World Vision. (2007). Implementation of Domestic Violence Law of Mongolia: Research Report.

National Center Against Violence & World Vision CPProgram. (2007). Implementation of Domestic Violence Law: Research Report.

State Great Hural of Mongolia. Resolution No.25. Parliament Resolution on the Millennium Development Goals of Mongolia.

UN Human Rights and Gender Thematic Group. (2004). Report on Domestic Violence Needs Assessment UB Mongolia.

WHO Centre for Health Development. (2007). National report on violence and health in Mongolia. Kobe, Japan.